

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-34
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	34-116
1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	35
2.“Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	35-91
3.Улсын Их хурлын гишүүн Г.Лувсанжамцаас Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газарт хандсан асуулгын хариуг хэлэлцэх	91-116

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 27-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 28 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, Р.Сэддорж, А.Ундраа;
Чөлөөтэй: Ж.Золжаргал, Б.Уянга;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Одбаяр;
Тасалсан: З.Мэндсайхан, О.Цогтгэрэл.

Нэг.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Э.Сундуй, “Өмгөөллийн Грандлекс партнерс” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмгөөлөгч Ж.Дамбаасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ё.Энхтуяа, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль эрх зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга Т.Гантогтох, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмацэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулав.

Төслийн эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, С.Цэнгүүн, Р.Батболд, Ц.Баатархүү, О.Батнайрамдал, Б.Заяабал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх хуульд нийцүүлж гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Н.Наранбаатар, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Б.Батбаяр, П.Ганзориг, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ч.Ундрам, Г.Уянгахишиг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх;

“3/Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	5
Бүгд:	23

78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, 2.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсвийн төслийг боловсруулахдаа бүрэн тусгасан байх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	6
Бүгд:	23

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын “төсөл, арга хэмжээг” гэснийг дараа “эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлэн өндөр үр өгөөжтэй төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжид” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	6
Бүгд:	23

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

5/“Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулж бүс нутгийн түвшинд хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт манлайлан, хүний эрхийн салбарын хамтын нийгэмлэг, үндэсний хүний эрхийн байгууллагууд /NHRI/, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, судалгааны зангилаа төв болон хөгжиж, аялал жуулчлал шинэ урсгалыг бий болгож, эерэг үр дүн гарна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	7

Бүгд: 23
69.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-6.4.7, 6.4.9, 6.4.11, 6.4.16, МУХТЖҮЧ-6.2.1.1, ЗГҮАХ-3.4.2.1, 3.4.2.2”, Төсөл, арга хэмжээ “Айл өрхийн сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид зориулсан ногоон зээлийн хүүгийн татаас олгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл нэвтрүүлсэн айл өрхийн тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5,000” гэж, Зорилтот түвшин “38,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “300,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.8 дахь дэд заалтын “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ” гэснийг “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, МУХТЖҮЧ-1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1” гэснийг “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.2.1, 2.3.1.1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.3 дахь дэд заалтын “Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах ажиллагаанд хүнгүй техник хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Суурь он “2025” гэснийг “2024” гэж, Суурь түвшин “102” гэснийг “10” гэж, Зорилтот түвшин “112” гэснийг “20” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэснийг “3,300.0” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Хүний эрхийн боловсрол, судалгаа шинжилгээний бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5, 5.1.8”, “МУХТЖҮЧ-7.6.1”, “ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027”

гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “900.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “900.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гадаад харилцааны яам” гэж, Хамтран хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	6
Бүгд:	23

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “6-9 дүгээр ангийн нийт 263808 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээллэх хоног 180, нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 3500 төгрөг/” гэж, Шалгуур үзүүлэлт “6-9 дүгээр ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “228,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “228,300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	6
Бүгд:	23

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2 дахь заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.20, 2.1.25, МУХТЖҮЧ-1.1.2.3, ЗГҮАХ-2.2.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн сурагчдын Монгол хэлний чадварыг сайжруулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Бага ангийн сурагчдын эх хэлний чадавхыг сайжруулах “Эрдмийн түлхүүр” төсөл хэрэгжүүлэх” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “341,000” гэж, Зорилтот түвшин “341,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,820.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,820.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	6
Бүгд:	23

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.14, 2.1.26, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад шим тэжээллэг хоолны үйлчилгээг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Бага ангийн нэг суралцагчийн сургуулийн хоолны үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Төгрөг” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “2500/3400 төгрөг” гэж, Зорилтот түвшин “3500/4000 төгрөг” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “65,448.4” гэж, Тухайн жилд

шаардагдах санхүүжилт сая.төг “65,448.4” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.14, 2.1.26, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад шим тэжээллэг хоолны үйлчилгээг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Дотуур байрны нэг хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын санхүүжилтийн хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Төгрөг” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “6000/6300 төгрөг” гэж, Зорилтот түвшин “8000/8300 төгрөг” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “7,342.5” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,342.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулав.

13.Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.8”, “МУХТЖҮЧ-6.2.2.1”, “ЗГҮАХ-3.3.3.6, 3.3.3.9, 3.3.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хөтөлбөрт хамрагдсан өрх” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “298,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “89,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат саналаа тайлбарлаж үг хэлэв.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

5/“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны

талаарх мэдээлэл, гүйцэтгэгч, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн тайлан, аудитын дүгнэлтийг олон нийтэд нээлттэй цахим системээр улирал тутам мэдээлэж байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Буулгаж дахин барих цэцэрлэг 74 дүгээр цэцэрлэг Чингэлтэй дүүрэг 10-р хороо, Далан давхрын урд талд” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “буулгаж дахин барилгажуулах цэцэрлэг /56 дугаар цэцэрлэг/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал саналаа тайлбарлаж үг хэлэв.

17.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Буулгаж дахин барилгажуулах цэцэрлэг /70 дугаар цэцэрлэг/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12”, “МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Малчин сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “13,316.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,438.7” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын 45 дугаар сургуулийн барилга буулгаж шинээр барих 960 суудалтай” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “28,158.8” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “18,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “10-12 дугаар ангийн нийт 134491 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээлэх хоног 185 нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 4000 төгрөг/” гэж, Шалгуур үзүүлэлт “10-12 дугаар ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “128,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “128,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.5 гэж, Төсөл арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Шинээр барьж эхлүүлэх сургууль” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “200,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “80,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн санал нь хуульд заасан шаардлагад нийцээгүй тул санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их хурлын гишүүн Ж.Галбадрах саналаа тайлбарлаж үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар нэмэлт тайлбар хийв.

22.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн дутагдлыг бууруулах” гэсэн төсөл, арга хэмжээний, зорилтот түвшин “1100” гэснийг “0” нэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэснийг “50,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “-” гэснийг “20,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв гэснийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт гэж өөрчлөх гэсэн санал нь хуульд заасан шаардлагад нийцээгүй тул санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их хурлын гишүүн Ж.Галбадрах саналаа тайлбарлаж үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх нэмэлт тайлбар хийв.

23.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1, 2.1.9” гэж, Төсөл, арга хэмжээ “Залуу зохион бүтээгчдийн ордон шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Барилга” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,110.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,110.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн тайлбар хийв.

24.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.3.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.13”, “МУХТЖҮЧ-1.1.3.3”, “ЗГҮАХ-2.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын Нийслэлийн дүүргүүдэд барих нэг маягийн зураг төсөлтэй байгууламж бэлтгэл ажлыг хангах” гэж, Шалгуур үзүүлэлт

“Барилгын ажлын явц” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагчид “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх гэсэн санал нь хуульд заасан шаардлагад нийцээгүй тул санал хураалт явуулаагүй болно.

25.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “1.2.1.6.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрээр асрах, сувилах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.7, ЗГҮАХ-2.3.4, 2.3.2.2, 2.3.2.8” гэж, Төсөл, арга хэмжээ “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрээр асрах, сувилах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Гэрээр асрах үйлчилгээ авч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “5000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “20,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “20,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж, Хамтран хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их хурлын гишүүн С.Эрдэнэбат саналаа тайлбарлаж үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нар нэмэлт тайлбар хийв.

26.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтад “Урьдчилан сэргийлэх эрт, илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1, 2.3.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрт илрүүлгийн арга хэмжээний хүрээнд бүрдсэн хүн амын эрүүл мэндийн өгөгдөлд эпидемиологийн, өртөг-үр ашгийн шинжилгээ хийж бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,750.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,750.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв /батлагдсан урсгал зардал” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа саналаа тайлбарлаж үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн нэмэлт тайлбар хийв.

27.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтад Бодлогын үндэслэл “МУХТЖҮЧ-1.2.1.11, ЗГҮАХ-2.3.2.5,” гэж, Төсөл, арга хэмжээ “Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан, аялал жуулчлалын чиглэлтэй интеграцчилсан үйлчилгээний хөгжлийн загварыг нэвтрүүлэх.” гэж, Шалгуур үзүүлэлт “интеграцчилсан үйлчилгээний жишиг загвар” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Үр дүнгийн үзүүлэлт Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “4,600.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв /батлагдсан урсгал зардал” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж, Хамтран хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	14
Бүгд:	23
39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Дээрх саналтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн тайлбар хийв.

28.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалтын “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах эмнэлэг, эрүүл мэндийн барилгуудыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах” гэснийг “Аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв, байгуулах” гэж, Зорилтот түвшин “100” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	14
Бүгд:	23
39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Дээрх саналтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх тайлбар хийв.

29.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.11, 2.2.12, МУХТЖҮЧ- 1.2.1.3, ЗГҮАХ- 2.3.2.1, 2.3.2.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг хүн төвтэй, нэгдмэл загварт шилжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Үр дүнгийн үзүүлэлтэд суурь он “2025” гэж, суурь түвшин “0” гэж, зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,430.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,430.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
-------------	----

Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.14, 2.2.11, 2.2.27, МУХТЖҮЧ-1.2.1.3, ЗГҮАХ-2.3.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум 20 ортой Эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,365.29” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “9,365.29” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.6.10, МУХТЖҮЧ-1.2.1.5, ЗГҮАХ-2.3.2.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын төвийн тоног төхөөрөмж” гэж, Шалгуур үзүүлэлт “-” гэж, Хэмжих нэгж “-” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “5,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “5,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Заяабал: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10

Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Заяабал: 32.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.6.10, МУХТЖҮЧ-1.2.1.5, ЗГҮАХ-2.3.2.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Дүүргийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгад шаардлагатай тоног төхөөрөмж /мэдээлэл технологи, эмнэлгийн тоног төхөөрөмж, Хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулах, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлт “-” гэж, Хэмжих нэгж “-” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “20,218.8” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “10,218.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.3.3, МУХТЖҮЧ-2.1.4.1, ЗГҮАХ-2.1.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан өрх” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “1259” Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.1-1.5, МУХТЖҮЧ-3.1.2.1, ЗГҮАХ-3.3.6.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум “Угсаатны зүйн музей”-н барилга” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “35,391.65” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “12,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

35.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.2.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, МУХТЖҮЧ-4.2.4.2, ЗГҮАХ-2.1.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Ахмадын хөгжлийн төвийн барилгын өргөтгөл /Сүхбаатар, Баруун-Урт сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,200.4” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,100.2” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.2.1, 2.3, 2.3.1, 2.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Гэр бүлийн боловсрол, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үндэсний нөлөөллийн хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Нөлөөллийн ажилд хамрагдсан хүний тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв, бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Соёлын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.4.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.2.1, 2.3, 2.3.1, 2.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Олон хүүхэдтэй болон залуу гэр бүлийг дэмжих бодлогын арга хэмжээг боловсронгуй болгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дэмжлэгт хамрагдсан олон хүүхэдтэй болон залуу гэр бүлийн хувь” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “20” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам, Монголбанк” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.4.4 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.2.1, 2.3, 2.3.1, 2.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Эцэг, эхийн боловсрол, хүүхэд хамгааллын сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Сургалтад хамрагдсан эцэг, эхийн тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “700.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Боловсролын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.3.3, МУХТЖҮЧ-4.4.1.1, 4.2.4.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Түр хамгаалах байр төрөлжүүлэн зохион байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Төрөлжүүлсэн хамгаалах байр” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “21” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “20,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “20,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч” “Аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.3.3, МУХТЖҮЧ-4.4.1.1, 4.2.4.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвсгөл аймаг, Бүрэнтогтох суманд хүүхдийн хөгжил, амралт-сургалтын “Найрамдал-2” цогцолбор байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Баригдсан хүүхдийн зуслангийн хүчин чадал” гэж, Хэмжих нэгж “Ор” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “5,443.1” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,443.1” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.2.4 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “4.2.4.7.цагдаагийн байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлнэ” гэж, Бодлогын үндэслэл “АХ-7.4.13,

МУХТЖҮЧ-4.2.5.4, ЗГҮАХ-4.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Заамар сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,975.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,975.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

42.Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.17, 8.3.35, МУХТЖҮЧ-4.3.1.3, ЗГҮАХ-3.3.4.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах иж бүрэн судалгаа хийдэг хүнсний хүрээлэнгийн лаборатори шинээр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “44,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “44,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Гадаадын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

43.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.3”, “МУХТЖҮЧ 4.4.1”, “ЗГҮАХ 2.4.3.3” гэж, Төсөл, арга хэмжээ “1000 айлын орон сууцны хороолол”-ын гадна ус хангамж, ариутгах татуурга, гадна холбоо /Дорнод, Хэрлэн сум/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,790.6” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,895.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” Хамтран хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, МУХТЖҮЧ-4.4.1.3, ЗГҮАХ-2.4.1.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Бүх сумдад Төрийн албан хаагчдад зориулсан 10-15 айлын орон сууц барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ашиглалтад орсон орон сууцны тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0”

гэж, Зорилтот түвшин “400” гэж, Нийт санхүүжилтийн сая.төг “6,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат саналаа тайлбарлаж үг хэлэв.

Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн нэмэлт тайлбар хийв.

45.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь заалтад “4.4.4.3.6.Хүннү хотын ногоон нуур, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх гэсэн санал нь хуулийн шаардлагад нийцээгүй гэж үзэж санал хураалт явуулаагүй болно.

Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн тайлбар хийв.

46.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, МУХТЖҮЧ-4.4.1.3, ЗГҮАХ-1.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн бие даасан дулааны эх үүсгэврийн барилга байгууламж /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 10 хороо/” гэж, Шалгуур үзүүлэлт “Дэд бүтцийн ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “-” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,386.5” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “9,386.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

47.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, МУХТЖҮЧ-4.4.1.3, ЗГҮАХ-1.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 10 дугаар хороо, Далан давхрын урд талд/” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “-” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “11,010.7” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “11,010.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

48.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.3.14, 3.23, МУХТЖҮЧ-4.3.2, ЗГҮАХ-4.4.4.4, 4.4.4.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Уул аймаг Шарын гол сум гал түймэр унтраах аврах 55-р ангийн өргөтгөлийн барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “822” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “822” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Шадар сайдын Ажлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.4.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.3, МУХТЖҮЧ-4.4.4.1, ЗГҮАХ-1.1.4.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Баянчандмань сумын Дархан-Эрдэнэтийн зам дээр гүүрэн зам тавих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, “Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,100.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.14”, “МУХТЖҮЧ-5.1.1.1”, “ЗГҮАХ-3.3.1.13” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, Шалгуур үзүүлэлт “Нүүрснээс үйлдвэрлэх шатахуун, хийн түлшний дотоодын хэрэглээнд эзлэх хувь хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “75,645.70” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,564.57” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагчид “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 16
Бүгд: 23

30.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн тайлбар хийв.

51.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтын “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Хүрэн нүүрснээс хагас кокс эрчим хүч үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	15
Бүгд:	23

34.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

52.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.14 МУХТЖҮЧ-5.1.1.1, ЗГҮАХ-1.3.4.1” гэж, Төсөл, арга хэмжээ “5.1.1.1.8 Улаанбаатар хот, зарим аймгийн төвүүдийн ахуйн хэрэглэгчдийг хагас коксожсон байгаль орчны бохирдлыг бууруулах түлшээр хангах нүүрс пиролизын үйлдвэрийг байгуулна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “240 тэрбум” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	15
Бүгд:	23

34.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

53.Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.20, МУХТЖҮЧ-5.1.2.1, ЗГҮАХ-3.3.4.31” гэж, Төсөл, арга хэмжээ “Малчдын оролцоонд суурилсан, мал бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бүхий малын түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөөгийн хүн амын амьжиргааг дэмжих зорилгоор “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” төслийн техник эдийн засгийн үндэслэл, иж бүрэн зураг төсөл боловсруулна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Баримт бичиг боловсруулах” гэж, Хэмжих нэгж “Техник, эдийн засгийн үндэслэл” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “3,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн санал нь хуулийн шаардлагад нийцээгүй тул санал хураалт явуулаагүй болно.

54.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.4.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Жаргалант-Шинэ Идэр-Мөрөн авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт

“Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “334,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “334,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж, Хамтран хариуцагч “Хөвсгөл аймаг” гэж нэмэх гэсэн санал нь давхардсан учир санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ саналаа тайлбарлаж үг хэлэв.

55.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.4.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвөгч гүүр” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “3,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж, Хамтран хариуцагч “Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сум” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	18

52.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Заяабал: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.4.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ /Булган аймаг, Сэлэнгэ сум- Орхон аймаг, Баян-Өндөр сум/ “40 км хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “57,776.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “57,776.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж,

Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ саналаа тайлбарлаж үг хэлж, Эдийн засаг хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн нэмэлт тайлбар хийв.

57.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.39, МУХТЖҮЧ-5.6.1.3, ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “5.6.1.3.3 Багануурын уурхайг түшиглэн 300МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “-”, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр хувийн хэвшил” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн санал нь хуулийн шаардлага хангаагүй тул санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат тайлбар хийв.

58.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, МУХТЖҮЧ-5.6.1.1, ЗГҮАХ-1.1.2.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 15, 19, 20-р хороо/” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “3,600.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их хурлын гишүүн О.Батнайрамдал саналаа тайлбарлаж үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат нар нэмэлт тайлбар хийв.

59.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.35”, “МУХТЖҮЧ 5.6.1.1”, “ЗГҮАХ 3.3.3.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Хавирга хилийн боомтын өргөтгөлийн цахилгаан хангамж Хавирга 35 Кв ЦДАШ, 35/10 кВ-ын 2/1600 кВА чадлын “Хавирга” дэд станц 35/10 кВ-ын “Хэрлэн”

дэд станцын өргөтгөл /Дорнод/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,402.7” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “5,201.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.39”, “МУХТЖҮЧ-5.6.1.3”, “ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорноговь аймгийн Айраг сумын 8 МВт хүчин чадалтай дулааны зуух барих, шугам сүлжээ өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “8,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “8,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагчид “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн санал нь хуулийн шаардлага хангаагүй тул санал хураалт явуулаагүй болно.

61.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-1.3.3.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 92.13 км авто зам барих /Орхон, Дархан-Уул, Төв/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “150,034.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “11,139.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбатын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 87.9 км” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “45” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбатын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойр-Мандалговь-Арвайхээрийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “230.98 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “105.0 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Ховд-Улиастайг холбох хатуу хучилттай авто замын үргэлжлэл, Донойн хөндий-Сархайрхан-Дөргөн чиглэлийн 335.9 км хатуу хучилттай авто зам.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “8” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “375,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “30,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “-” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “60” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “137,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “82,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар тайлбар хийв.

66.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-9.3.1.3, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойбалсан хот-Буйр нуур-Баянхошуу боомт чиглэлийн 210 км хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “420,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “12,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

67.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-9.3.13, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойбалсан хотоос Баян-Уул сум хүртэлх 195 км хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “390,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “130,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад

Бодлогын үндэслэлд “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээнд “Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “323,196.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “96,958.80” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат саналаа тайлбарлаж үг хэлэв.

69.Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын төвөөс Даян боомт чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын явц” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “289,258.9” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “86,77.6” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

70.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.2, ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замаас Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн авто замын их засварын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “24,174.01” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “24,174.01” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн санал нь хуулийн шаардлага хангаагүй тул санал хураалт явуулаагүй болно.

71.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.3.11” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөх Баавгайн Үүр” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “7,286.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,286.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Арц суурь хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлтийн ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “67,005.0” гэж, Тухайн жилд шаардагдаж санхүүжилт сая.төг “20,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Гадаадын зээл” гэж, Үндсэн хариуцагч “Сангийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн санал нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй учраас санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал тайлбар хийв.

73.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.2.1 дэх дэд заалтад “Бодлогын үндэслэл” “АХ-8.1.8, МУХТЖҮЧ-5.7.2.1, ЗГҮАХ-3.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Ханх-Мондын боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөл, шинэчлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “25,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн санал зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдээгүй тул санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал тайлбар хийв.

74.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.1 дэх дэд заалтын “Гэр хорооллын айл өрхийн бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Зорилтот түвшин “1” гэснийг “5” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

75.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.3.1.2 дахь дэд заалтын “Онги-Цагаанбургастай” төслийн бэлэн байдлын хангалт” гэсэн Шалгуур үзүүлэлтийн “Нийт санхүүжилтийн дүн сая төгрөг “0” гэснийг “44,490.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг “30,230.0” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12

Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй

76.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.2 дахь дэд заалтын Бодлогын үндэслэл “АХ-5.1.3, МУХТЖҮЧ-7.2.2.2, ЗГҮАХ-4.1.5.2” гэснийг “АХ-5.1.3, МУХТЖҮЧ-5.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх” гэснийг “Хиймэл оюун ухааны тоног төхөөрөмжийн нэмэлт сайжруулалт” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “0” гэснийг, “3,700.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг “1,500.0” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

77.Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.5, МУХТЖҮЧ-7.2.3.1, ЗГҮАХ-4.2.1.14” гэж, Төсөл, арга хэмжээ “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн, тогтвортой ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор цахим баазыг өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Үйл ажиллагааны хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Улсын ерөнхий прокурорын газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

78.Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.5, МУХТЖҮЧ-7.2.3.1, ЗГҮАХ-4.2.1.14” гэж, Төсөл, арга хэмжээ “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн, тогтвортой ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор цахим баазыг өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Үйл ажиллагааны хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “30,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “10,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Улсын ерөнхий прокурорын газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

79.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.1.2.5 дахь дэд заалтад

Бодлогын үндэслэл “АХ-4.2.45, МУХТЖҮЧ-5.4.1.2, ЗГҮАХ-3.3.5, 3.3.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл; /Сүхбаатар Дарьганга сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “60,200.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “30,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	11
Бүгд:	23

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

80.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 10.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4, МУХТЖҮЧ-10.1.1.1, ЗГҮАХ-3.3.7.1, 3.3.7.3, 3.3.7.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн түншлэлийн гэрээ” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	14
Бүгд:	23

39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

81.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 13.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.1.15, 1.1.19, МУХТЖҮЧ-3.1.1.2, ЗГҮАХ-3.3.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүүхдийн ордон барих /Увс, Улаангом сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “11,974.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,991.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	12
Бүгд:	23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

82.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр “Засаглал /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, Үр дүн “Хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээлэл олон нийтэд нээлттэй болсон байх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төсөв, санхүүжилтийн эх

үүсвэр, тендер, гүйцэтгэгч, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн тайлангаа нээлттэй цахим системд улирал тутам байршуулсан төсөл, арга хэмжээний эзлэх хувь” гэж, Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа “ТХЗ 16.6” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “2027 онд батлагдсан төсөл, арга хэмжээний мэдээллийг улирал тутам байршуулсан байх” гэж, Мэдээллийн эх сурвалж “Цахим хяналтын системийн тайлан”, гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Цахим системийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, аудит” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Улирал тутам” гэж, Хариуцах байгууллага “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	14
Бүгд:	23

39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц тайлбар хийв.

83.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авилгын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд авлигын эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийсэн байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Авлигын урьдчилсан үнэлгээ хийсэн 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний эзлэх хувь” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 16.5, ТХЗ 16.6” гэж, “Хэмжих нэгж” “Хувь” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд холбогдох төсөл, арга хэмжээнд үнэлгээ хийсэн байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Авлигатай тэмцэх газрын тайлан, Үндэсний аудитын газрын тайлан”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Эрсдэлийн үнэлгээ, аудит, хяналт-шинжилгээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” “Хагас жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Авлигатай тэмцэх газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	13
Бүгд:	23

43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

84.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авилгын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “Тендер худалдан авах ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй болсон байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендерийн урилга, үнэлгээний дүн, шалгарсан гүйцэтгэгч, гэрээний дүн, гүйцэтгэлийн мэдээллээ байршуулсан худалдан авах ажиллагааны эзлэх хувь” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 16.6” гэж, “Хэмжих нэгж” “Хувь” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд мэдээллийг бүрэн байршуулсан байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Системийн тайлан, аудит” гэж, “Мэдээлэл цуглуулах

давтамж” “Улирал тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Сангийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

85.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЭЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авлигын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “Орон нутгийн төсөл, арга хэмжээнд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, саналын тэмдэглэл хавсаргасан орон нутгийн төсөл, арга хэмжээний эзлэх хувь” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 16.7, ТХЗ 11.3” гэж, “Хэмжих нэгж” “Хувь” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд холбогдох төсөл, арга хэмжээнд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Аймаг, нийслэлийн Засаг даргын тайлан”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Тайлан, саналын бүртгэл, хэлэлцүүлгийн тэмдэглэл” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” “Хагас жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

86.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЭЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авлигын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “Агаар, ус, хөрс, хүлэмжийн үзүүлэлтийг тогтмол хэмжиж, тайлагнадаг болсон байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Агаар, ус, хөрс, хүлэмжийн үзүүлэлтээр жил бүр шинэчилж нийтэлсэн тайлангийн тоо” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 6.3, ТХЗ 11.6, ТХЗ 13.2, ТХЗ 15.3” гэж, “Хэмжих нэгж” “Тоо” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд 1-ээс доошгүй тайлан нийтэлсэн байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Байгаль орчны мэдээллийн сан, Үндэсний статистикийн хороо”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Статистик мэдээлэл, байгаль орчны хэмжилт, хяналт-шинжилгээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

87.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЭЗ/ хөтөлбөрийн нэр “71801 Сургуулийн өмнөх боловсрол”, Үр дүн “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” үр дүнгийн хүрээнд

Шалгуур үзүүлэлт “Багшийн үндсэн цалин /Улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно/” гэж, Тогтвортой хөгжлийн зорилго “4.с.1” гэж, Хэмжих нэгж “Индекс” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “2,726.9” гэж, Зорилтот түвшин “2027” “2026 оны түвшнээс дээгүүр” гэж, Мэдээллийн эх сурвалж “Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жил тутам” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

88.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЭЗ/ хөтөлбөрийн нэр “71802 Ерөнхий боловсрол”, Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэсэн үр дүнгийн Суурь түвшин 1484 гэснийг 2769.9 гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Найруулгын санал:

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их хурлын гишүүн Г.Лувсанжамцаас Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газарт хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Даваасүрэн, мөн албаны ахлах мэргэжилтэн С.Төмөрбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын

газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Нийслэлийн байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхбаяр, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирал Б.Амгалан, мөн газрын Тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн захирал Л.Эвшинхорлоо, мөн хэлтсийн ахлах эдийн засагч Э.Гонгор, эдийн засагч И.Өрнүүн, Худалдаа хөгжлийн банкны Ногоон санхүүжилтийн албаны дарга Д.Нямсүрэн, Хаан банкны Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, ногоон банкны газрын захирал Б.Болортуяа, Хас банкны Эко банкны газрын захирал Г.Туул, Төрийн банкны Тогтвортой хөгжлийн албаны ахлах менежер А.Энх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

Асуулгын хариуг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Даваасүрэн танилцуулав.

Асуулгын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Г.Лувсанжамц нарын тавьсан асуутад Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Даваасүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Нийслэлийн байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхбаяр, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирал Б.Амгалан, Худалдаа хөгжлийн банкны Ногоон санхүүжилтийн албаны дарга Д.Нямсүрэн, Хаан банкны Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, ногоон банкны газрын захирал Б.Болортуяа, Хас банкны Эко банкны газрын захирал Г.Туул, Төрийн банкны Тогтвортой хөгжлийн албаны ахлах менежер А.Энх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Очирбат, М.Энхцэцэг нар үг хэлэв.

Асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Улсын Их хурлын гишүүн Г.Лувсанжамцаас Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газарт хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 19 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 6 цаг 05 минут үргэлжилж, 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхимд 13 цаг 28 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Заяабал: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны ирц 53.1 хувь болсон тул хуралдаанаа нээе хуралдаанд ирсэн гишүүдийгээ танилцуулъя.

Чинбаатарын Анар гишүүн, Ренчинболдын Батболд гишүүн, Отгоншарын Батнайрамдал, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Шинэбаярын Бямбасүрэн, Жамбалын Ганбаатар, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандухай, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гэсэн 19 гишүүн хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна аа.

Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 59.4 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг байгаа.

2.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, гурав дахь хэлэлцүүлэг байгаа.

3.Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцаас Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга болон Монголбанкны ерөнхийлөгчид тавьсан асуулгын хариуг сонсохоор байгаа.

4.Инновац болон Цахим бодлогын хөгжлийн дэд хорооноос байгуулсан үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг сонсохоор байгаа.

4 асуудал хэлэлцэх асуудлын товд орсон байгаа.

Гэхдээ эндээс 4 дэх асуудал нь 7 хоногийн тов дараалалд багтсан боловч Дэд хорооны ажлын хэсгийн санал дүгнэлтийг дэд хорооны хуралдаанаар хэлэлцэж

амжаагүй санал, дүгнэлтээ Байнгын хороонд ирүүлээгүй тул өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлууллаа.

Ингээд эхний 3 асуудлаар асуудал тов дараалалд үлдэж байна аа. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Ингээд 3 асуудал хэлэлцэхээр байгаа. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудлын тов дарааллаа тогтлоо. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг.

Нэг.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсэг нь аль вэ? Ажлын хэсэг. Энхжаргалын Сундуй “Төв тусгал” сургалт судалгааны төвийн судлаач, Жанчивсэнгээгийн Дамбаасүрэн нь Өмгөөллийн Гранд Лекс партнерс компанийн өмгөөлөгч ийм 2 хүн хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хууль хүчин төгөлдөр болох огноог тодорхой болгох тухай санал гарч дэмжигдсэнийг төсөлд тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд бас хүргүүлсэн байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-д заасны дагуу гишүүд асуулт асуух боломжтой.

Асуух асуулттай гишүүд байна уу? Асуух асуулт гиш олголоо. Хүн нь тийм асуух суулттай гишүүд байхгүй байна.

Ингээд БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд манай гишүүдээс хэн танилцуулах вэ? Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн гишүүн танилцуулна аа.

Дараагийн асуудалдаа орцгооё оо.

Хоёр.“Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Гишүүд маань бас хуралдааныхаа танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна. Ялангуяа энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой санал гаргасан эрхэм гишүүдийг манай Эдийн засгийн байнгын хороонд хүрэлцэн ирэхийг хүсэж байна аа.

Ингээд Монгол Улсын хөгжлийн 2027 оны жилийн төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ. Төслийн эцсийн хувилбарыг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц танилцуулна аа.

Гишүүний микрофоныг нээнэ үү. Лувсанжамц гишүүний микрофоныг нээе.

Б.Заяабал: Байнгын хорооны эрхэм дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулах үед хуралдаан даргалагчаас зарчмын зөрүүтэй саналуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгч төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Улсын Их Хурлын даргын 2026 оны 194 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэнээр чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулагдсан 43 саналыг холбогдох хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар дахин санал хураах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдээгүй саналуудыг дахин хэлэлцэх санал хураах шаардлагагүй гэж үзсэн болно оо.

Энэ хүрээнд чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулагдсан 43 саналыг нэг бүрчлэн хэлэлцэж 12 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж санал хураалгах, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан 76 зарчмын зөрөөтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Мөн нэгдсэн хуралдаанд даргалагчаас хуульд нийцүүлж гүйцээн боловсруулах чиглэл өгч Байнгын хорооны 3 дахь хэлэлцүүлэгт шилжүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудыг тухайн саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүдэд нь танилцуулахад 115 саналыг хураалгах шаардлагагүй гэж үзсэн байна аа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Заяабал: Лувсанжамц гишүүнд, ажлын хэсгийн ахлагчид баярлалаа. Одоо ажлын хэсгийг танилцуулъя аа. Сайд байхгүй байна. Дэд сайд байна. Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Бат-Ирээдүйн

Анар Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Анар дарга ирсэн үү. Сангийн яамныхан байна уу? Анар даргыг дуудаарай. Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД. ТНБД нар яагаад ирээгүй байна. ТНБД нарыг дуудаарай ажлын хэсэг. Лханаажавын Энэ Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД ирсэн байна уу? Мөнхтүшиг дарга, Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны ТНБД. Энэ ажлын хэсэгт орсон гишүүдийг яагаад дуудаагүй юм. Энэ чинь байхгүй байна шүү дээ. Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД байна уу? Ядаж энэ гишүүдийн гаргасан саналтай холбоотой 3 дахь хэлэлцүүлэг болж байгаа учраас гишүүдийн гарсан саналууд тодорхой байгаа шүү дээ. Энэ гарсан саналтай холбоотой энэ хариуцсан гол одоо яамны ТНБД нар ирсэн баймаар байна аа. Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ирсэн байна уу? Намсрайн Баярмагнай ЗТЯ-ны ТНБД, Төмөрүяагийн Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны ТНБД, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Мягмарнаран дарга байна уу? Мягмарнаран дарга байна. Батмөнхийн Ерэн-Өлзий ЭХЯ-ны ТНБД, Намжилын Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД ирсэн байна. Баттулгын Батбямба ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Аюулгүй байдал дээр байгаа юм уу? Тогоогийн Гантогтох Засгийн газрын Хүний нөөцийн газрын дарга, Болдын Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Батсуурийн Даваадалай Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал ирээгүй юу? Одоо тэгээд яах юм энэ чинь байгаа байхгүй хүмүүсийг. Энэ ТНБД нарыг дууд ажлын хэсэг Батболдоо. Ялангуяа энэ гишүүдийн 3 дахь шатны ийм хэлэлцүүлэг болж байна шүү дээ. Гишүүдийн гаргасан саналууд нь тодорхой байгаа шүү дээ. Яг ямар ямар чиглэлээр, ямар ямар салбарын саналууд гаргасан нь тодорхой байгаа шүү дээ. Тэгээд гишүүд энэ чинь бас асуулт асууна энэ чинь бас хууль тогтоомжид нийцсэн үү үгүй юу гэдэг дээр тодруулгууд авна. Энэ чинь яамных нь хүмүүс тодорхой байх хэрэгтэй байна шүү дээ. Тэгээд уул нь энэ Их Хурлын ажил явагдаж байгаа уул нь салбарын сайд нар нь ирэх ёстой. Өнөөдөр бас Засгийн газар хуралдаж байгаа учраас бас сайд нар нь биш ТНБД нар нь ирэх байх гэдэг ийм хүлээлттэй байгаа. Тэгээд ТНБД нар нь ч ирэхээ байсан байна шүү дээ. Яамдын ТНБД нарыг хурдан орж ир гэж хэлье.

Тэр хүртэл манай энэ Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хурал цаашаа үргэлжлэх боломжгүй байж байна шүү дээ. Сая нэр дуудсан Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД орж ирлээ. Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД орж ирлээ. ЭХЯ-ны ТНБД Батмөнхийн Ерэн-Өлзий дарга орж ирлээ. Засгийн газраас энэ ажлын хэсэг гэж орсон нэрүүдийг бүгдийг нь дуудах ёстой юм байна. Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга Энхманлай дарга байна уу? Цэвэлмаагийн Ихбаяр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга байна. Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа эдийн засаг, хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Насангийн Отгонбаяр ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Милчисчойгийн Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн

бодлогын газрын дарга, Батсүхийн Бадамжав Боловсролын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Цэндийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Юрагийн Отгонбилиг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Жамбалын Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандонойн Баянзул ЗТЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Бираагийн Урьболд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төлөвлөлтийн газрын дарга, Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Бямбасүрэнгийн Туяа ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга. Зиаханы Райынбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Болорчулуун дарга орж ирсэн үү? Орж ирсэн байна. Доржийн Энхтөр ХЗДХЯ-ны Хууль эрх зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга, Ёндонжамцын Энхтуяа ЭХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Басангийн Мижидмаа Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Галиндэвийн Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Ийм Засгийн газраас одоо өгсөн ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг уншиж танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу гишүүд асуулт асуух боломжтой. Ингээд тогтоолын төслийн эцсийн хувилбараас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. 4 гишүүн нэрс өгсөн байна. 4 гишүүн нь Баатархүү гишүүнээр тасаллаа.

Ингээд дарааллын дагуу Эрдэнэбат гишүүний микрофоныг олгоё.

С.Эрдэнэбат: Ажлын хэсэг маань энэний өмнөх юун дээр бас нэлээн ажилласан юм байна аа. Дахиад ажлын хэсгээс үндсэндээ бараг 62 санал л орж ирж байх шиг байна. Бусад нь бол Их Хурлын гишүүдийн санал байна. Гишүүдийн санал дотроос яах вэ давхацсан саналууд бас зарим нь яваад байна. Төсвийн үр дагаврын хувьд ч гэсэн зарим нь бол нэлээн зөрөөтэй. Энийг бас одоо нэгтгэх тал дээр гишүүдтэй ер нь ярилцсан уу гэж бас хэлмээр байна.

Хоёрдугаарт бас энэ дээр тухайн орон нутгийн шинж чанартай орон нутаг болон 5 жилийн үндсэн чиглэлийн одоо юунд бол тусаагүй энэ тэр гэдэг зарим одоо саналууд, гишүүдийн санал дээр хэр зэрэг олон байгаа вэ гэдгийг бас хэлмээр байна. Асуумаар байна тийм.

Б.Заяабал: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Боловсруулсан ажлын хэсгийн ахлагч Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Өнгөрсөн 7 хоногт нэгдсэн чуулганаар 203 санал хэтэрхий их байгаа. Зарчим барьж ажиллаагүй байна гэсэн шаардлагын дагуу ажлын хэсэг

өнгөрсөн хугацаанд ажиллалаа. Олон санал гаргасан бүх гишүүдтэй биечилж уулзсан бөгөөд зарим төслүүд тухайн нэг тойрог дээр 2 гишүүний гаргасан санал бас давхардсан саналууд байгаа. Тэгэхлээр тухайн саналыг татаж авах боломжтой эсэх хуульд нийцээгүй зүйлүүдийг санал хураалгах шаардлагагүй юм байна гэдэг агуулгаар нь нэлээн ярилцсан. Тэр дүнгээсээ бид нар 203-аас 115 санал дээр бол санал хураалгах шаардлагагүй гээд 88 санал орж ирж байгаа. Ажлын хэсгийн хуралдаан дээр дэмжигдсэн нь бол эндээс 12 санал байгаа. Тэгэхээр 12 саналыг бол 5 жилийн үндсэн чиглэлд 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна гэсэн үүднээс оруулсан бөгөөд 12 саналын эхний 5 санал бол төсөв мөнгөгүй саналууд буюу Их Хурлын тогтоолын төслийн саналууд байгаа. Гишүүдийн гаргасан саналууд дээр бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бас туссан байгаа учраас жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийлж байсан учраас дээрээс нь нэмээд 5 жилийн үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралт буюу шалгуур үзүүлэлтүүдийг ахиулахад нөлөө үзүүлэх боломжтой гэсэн төслүүдийг бол үлдээсэн байгаа. Нэмж тайлбарыг Эдийн засгийн хөгжлийн яамнаас өгөх үү?

Б.Заяабал: Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе. Нэмж хариулт өгье.

Б.Мөнгөнсүх: Эдийн, засаг хөгжлийн яамны Нэгдсэн бодлогын газрын дарга Мөнгөнсүх гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хугацаанд 203 санал нэг бүр дээр ажиллаж хуульд нийцсэн эсэх талаар бол нэг бүрчлэн одоо шалгаж холбогдох материалуудыг бүрдүүлэн ажилласан. Мөн түүнчлэн энэ бодлогын баримт бичгийн бодлогын уялдаануудыг нэг бүрчлэн шалган тодорхойлж жилийн хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, үндсэн чиглэлд нийцэж байгаа эсэхийг шалган боловсруулж ажлын хэсэг дээр тухай бүрд нь мэдээллээр хангаж ингэж ажилласан байгаа.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүний нэмэлт нэг минут өгье.

С.Эрдэнэбат: Нийтдээ ер нь төсвийн хувьд нь аваад үзэхээр хэд болов оо. Энэний өмнө чинь 4 их наяд билүү хэд байлаа одоо хэд болсон бэ гэдгийг тодруулж асуумаар байна. Одоо нийт төсвийн хүрээнд. Зарим саналуудыг нь харж байхаар одоо нийт төсөвт өртгийг нь ирэх жил бүтэнгээр нь энэ тэр тавьчихсан юмнууд бас харагдаад байна, 300, 400 тэрбумаар нь. Тэгэхээр энэ зарим одоо гишүүд яг тийм бодитой биш төсвийн нийт дүнд асар их нөлөө үзүүлж байгаа. Энэ чиглэлээр нь гишүүдтэй ярьж үзсэн үү? Иухайлбал одоо зарим хүмүүс нь бол яг энийг бодоод магадгүй энэ том төсөв байгаа учраас 3, 4 хуваагаад тавья гэдэг дээрээ Засгийн газартайгаа холбогдох сайд нартайгаа ярилцаад оруулж ирж байгаа санал байгаа. Зарим нь бол одоо ерөөсөө 2027 онд тэр чигээр нь бүгдийг нь хэрэгжүүлнэ гээд. 300, 400 тэрбумыг ганцхан төсөл шүү дээ одоо. Тухайлбал замын төсөл гэдэг ч юм уу. Энэ тал дээр нь та хэд нэг ажиллаж үзэв үү яав. Нийт төсөв нь хэд болж байгаа вэ?

Б.Заяабал: Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Өмнөх 203 санал дээр бол 4 их наяд төгрөг гараад явчихсан байсан. Тэгээд 203 саналаас 115-ыг нь хасаад нийт санхүүжилт нь 2.3 их наяд төгрөгийн санхүүжилт хэрэгтэй. Харин ажлын хэсгийн саналаар орж ирж байгаа саналууд дээр бол нийтдээ 441 тэрбум төгрөг байгаа. Гэхдээ та бүхэн тогтоолын

төсөл дээр оруулсан 3 саналыг хараасай гэж хүсэж байна. 3 дээр байгаа жилийн төлөвлөгөөнд туссан төсөл арга хэмжээний үр нөлөөг үнэлэх хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлалыг улсын төсөвтэй цуг намар өргөн барих ёстой гэсэн тогтоолын төсөл оруулсан.

Дээрээс нь 4 дүгээр заалт дээр байгаа жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төслийг боловсруулахдаа шалгуур үзүүлэлтүүдээ бас уялдуулж орж ирэх ёстой. 3 дугаар заалт дээр байгаа эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлэн өндөр өгөөжтэй төсөл арга хэмжээг тэргүүн ээлжид гэж оруулсан учраас энэ жишгийнхээ дагуу Сангийн яам боловсруулаад саналаа гаргах юм бол зохистой хэмжээний хөрөнгө оруулалтууд нь.

Б.Заяабал: Нэмэлт нэг минут авах уу? Ажлын хэсгээс нэмж хариулах юм байна уу? Эдийн засаг хөгжлийн яам. Эрдэнэбат гишүүний асуулт дууслаа.

Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд та бүхэнд хүргэе.

2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг нь батлах гэж бас Их Хурал дээр нэлээн их ажлууд болж байсан. Энэний хүрээнд бол 88 төсөл арга хэмжээг бол яг ач холбогдлоор нь үнэлээд тэдгээр 88 төсөл арга хэмжээг хэрэгжүүлбэ гээд баталсан байж байгаа. Тэгээд байж байгаад бид нар чинь жил болгонд нь жилийн төлөвлөгөө гээд өнөөдөр бас хэлэлцээд сууж байгаа юм. Тэгээд энэ маань болохоороо өөрөө нөгөө ач холбогдлоор нь эрэмбэлээд гаргасан нөгөө дуусдаггүй олон жил явдаг ажлууд биш чухлынхан эрэмбийнхээ дарааллаараа төслүүдээ дуусгая гэдэг зарчмаа бас буцаагаад бид нар ухраад байгаа юм. Өнгөрсөн 7 хоногт 204 санал одоо гишүүд гаргаад явсан. Энэ 4 их наядаар энэ төлөвлөгөөгөө бол нэмэгдүүлэх санал байсан. Буцаад багасгаад ирье гээд ажлын хэсгээс багасгаж оруулж ирж байгаа нь болохоороо 2 их наяд болгоод оруулж ирж байгаа юм байна. Гэхдээ яг энэ 2 их наяд ч гэсэн яг тодорхой байдлаараа бид нар төлөвлөгөөгөө худлаа гаргаад ирж байна гэсэн үг шүү дээ. Буцаагаад нэг жилийн төлөвлөгөөгөө хийчхээд дараа нь үр дүнгээ хэмжих болоод ирэхээр яагаад тэр ажлууд хийгдээгүй вэ гэхээр Засгийн газар анхнаасаа бид нар оруулж ирээгүй юм энэ гишүүдийн санал байсан юм гэдэг л үгээр хаацайлч байгаа. Энэ сүүлийн 2 жил давтагдсан ахиад энийг бид нар 3 дахь жилдээ хийх гээд байгаа юм. Тэгэхээр ингээд нөгөө төлөвлөгөөгөө анхнаасаа буруу баталж өгчхөөд бид нар гүйцэтгэл дээр нь хяналт тавих боломжгүй байдлаар үүсээд байгаа юм аа. Тэгээд энд гишүүдээсээ бас ингээд хүсмээр байгаа юм нь яг зарчимтайгаар бид бүхэн баталсан төлөвлөгөөнийхөө дагуу явах ёстой шүү дээ. Тэгээд холбогдох яамдуудаас асуумаар байгаа юм. Өнөөдөр бид нар энэ хэлэлцэх гээд байгаа зарчмын зөрүүтэй саналууд 2 их наядаар энэ төлөвлөгөөг нэмэгдүүлэх юм байна. Тэгэх яг санхүүгийн нөөц боломж нь байгаа юм уу?

Хэрвээ бид нар энийг дэмжээд явуулчихлаа гээд тэгэхэд үнэхээр гүйцэтгэл дээрээ нэг жилийн дараа энэ нь гарч ирж чадах юм уу? Тэрэн дээр нь та бүхэн бас яг мэргэжлийн хүмүүсүүд нь хариулаад өгөөч.

Б.Заяабал: Эдийн засаг хөгжлийн яамны дэд сайд 3 номерын микрофон өгье.

С.Даваасүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя аа.

Эдийн засгийн хөгжлийн яамны хувьд бол Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу төсвийн 36 ерөнхийлөн захирагчаас энэ оны эхэнд 669 төслийг хүлээж авсан. Үүний дүн нь бол 22.3 их наяд. Энэ дээр сүүлийн үндсэндээ 4 5 сарын хугацаанд ажиллаад 124 төсөл, 186 арга хэмжээндээ нийтдээ 15.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж оруулж ирсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр бол 2.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг хийх боломжтой. Үлдсэн хэсэг нь болохоор гадаадын зээл, дотоод хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэлээр гээд ингээд хийгдэхээр байгаа. Сая ярьж байгаа 203 төслийн хувьд бол төсвийн одоо хөгжлийн төлөвлөгөөний төслийг өргөн барьснаас хойш гишүүдээс гаргасан санал одоо 203 төсөл дээр нийтдээ 4 их наяд. Тэгээд энэ хэсэг бол ажлууд нь хийгдээд хамгийн сүүлд одоо ажлын хэсэг дээр гарахдаа 13 төслийг одоо санал болгож байгаа юм байна гэж бол бид ойлгож байгаа. Тэндээс 8 нь болохоороо 413.6 тэрбум төгрөгийн одоо санхүүжилттэй 5 нь болохоор одоо санхүүжилт шаардагдахгүй ийм төслүүд тусгагдаж орж ирж байгаа юм байна гэсэн ийм мэдээлэлтэй байна.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: Энэ нөгөө ажлын хэсгээс орж ирсэн дүнг нь та сая хэлж байх шиг байна. Энэ дээр нэмээд ахиад гишүүдийн саналууд байж байгаа. Тэгээд нийт зарчмын зөрүүтэй санал нь бол 82 санал байх шиг байна шүү дээ. 86 юм уу 88 саналын дүн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дүнийг яг үнэхээр санхүүжүүлэх боломж манай улсын эдийн засагт байгаа юм уу? Тэгэхээр энийгээ яг гишүүдэд ойлгогдохоор бас хэлэх хэрэгтэй байна л даа. Яагаад гэхээр мэргэжлийн яамдууд нь та бүхэн хэлэхгүй болохоор чинь энд ингээд бид нар мөрөөдлийн жагсаалтыг батлаад явуулчихдаг тэр нөгөө мөрөөдлийн жагсаалтаа буцаад хянах боломжгүй байдал үүсээд байгаа юм аа. Тэгэхээр хуурамчаар ажил хийсэн болж өөрөө өөрсдийгөө хуурах гээд байх шаардлагагүйгээр яг бодитойгоор хийх ажлуудаа бид бүхэн гаргаж тавиад тэрэн дээрээ гүйцэтгэл хэд байсан юм бэ гэдгээ хэмжээд явчихдаг энэ зарчим руугаа ормоор байгаа юм. Тэгэхээр тэрийг яг тодорхой хэлээд өгч болох уу?

Б.Заяабал: 3 номерын ажлын хэсгийн микрофон.

С.Даваасүрэн: Эдийн засаг хөгжлийн яамны хувьд бол яг энэ одоо хугацаанд төсвийн хүрээ, 2028, 2029 оны төсвийн төсөөлөл мөн 2027 оны хөгжлийн төлөвлөгөөг өргөн бариад байгаа. Тэгэхээр Засгийн газрын хувьд ирэх оны одоо төсөв дээр төсвийн хүрээн дээр нэг ч шинэ хөрөнгө оруулалт хийх боломжгүй байгаа. Энд өнөөдөр энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2.2 их наядын хувьд бол өмнөх жилүүдэд явж байсан одоо үргэлжлүүлж явж байгаа хөрөнгө оруулалт л явж байгаа. Санхүүжүүлэх нь 2.3 их наядыг одоо шинээр санхүүжүүлэх ийм орон зай бол байхгүй байгаа. Цэнгүүн гишүүнд нэмэлт тодруулга шаардлагатай учраас дахиад нэг минут өгье.

С.Цэнгүүн: Тэгэхээр сая Эдийн засгийн яамнаас хариулж байгаа мэдээн дээр би зөв ойлгосон уу гэдгийг тодруулж асуух гэсэн юм. Энэ 88 төслийг Их Хурлын гишүүд дэмжиж явуулаад тэгээд төлөвлөгөө дээрээ оруулж гаргасан ч гэсэн бодит амьдрал дээр одоо намар буцаагаад бид нар төсвөө ярилцах үед тэр төсвийг яг

батлаад хэрэгжүүлээд явах чадамж Засгийн газарт маань байхгүй гэсэн үг. Тэгэхээр бид нар худлаа төлөвлөгөө батлах гээд байна гэсэн үг. Тийм үү?

Энэ ингээд Улсын Их Хурлын гишүүд маань бас анхаармаар байна л даа. Дөнгөж сая яг ингээд мэргэжлийн хүмүүсүүд нь бас ингээд хэлж байна. Бид нар ингээд ийм мөргө мөрөөдлийн жагсаалт ингэж тавилаа ч гэсэн энэ зүйлүүдийг санхүүжүүлэх боломж нь угаасаа байхгүй юм байна. Тэгэхээр энийг одоо батлаад өгөөч батлаад явах хэрэгтэй гээд гуйх ч байдаг юм уу ингээд манай тойргийн ийм асуудал байгаа гэж бид бүхэн хэлж байгаа ч гэсэн тэр нь өөрөө бодит амьдрал дээр хэрэгжихгүй юм байна гэдгийг бид нар ингээд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байгаа юм аа. Тэгэхээр төслүүдийнх хан ач холбогдол, эрэмбэ Засгийн газрын тэр.

Б.Заяабал: Нэмэлт хариулт байна уу? Сангийн яам Анар дарга. 5 номерын микрофон.

Б.Анар: Цэнгүүн. Гишүүний асуултад хариулъя Анар энэ жилийн батлагдсан төсвийн хувьд бол 32.9 их наядын одоо нийт зардлын дээд хязгаар гээд батлаад өгчихсөн байгаа. Энийгээ аваад задлаад үзэх юм бол дотроо 75 хувь нь урсгал, үлдсэн нь бол орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалт гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслийн санхүүжилтүүд бол байгаад байгаа юм. Одоо өргөн барьчихсан байгаа Төсвийн хүрээний мэдэгдлийн тоогоо харах юм бол бид нар өргөн барьсан байгаа төсвийн хүрээний мэдэгдлээр нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ бол 32 их наяд буюу одоо 2.6 их наядын ингээд нэмэгдүүлж орж ирсэн төсвийн хүрээ өргөн барьчихсан байгаа.

Сангийн яамнаас хийж байгаа тооцооллоор энэ жил нэмэгдсэн байгаа боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчид дээрээс нь бусад салбарын ажилчдын цалингийн нэмэгдэл, тэтгэврийн хэмжээг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх зардлуудыг нийлүүлээд үзэхэд хамгийн багадаа 3-аас.

Б.Заяабал: Нэмэлт 1 минут хариултаа бүрэн өгөөдөхье. 5 номер.

Б.Анар: 3-аас 3.5 их наядын урсгал зардлын зөвхөн одоо зардлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар баригдсан байгаа төсвийн хүрээний мэдэгдэлдээ багтаагаад зөвхөн тодорхой хэмжээгээр урсгал зардлуудыг нэмэгдүүлж орж ирнэ гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр энэ нь юу гэсэн үг вэ гэхээр хөрөнгө оруулалтын зардлыг бол одоо шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын зардлыг бол ирэх оны төсөв дээр оруулж ирэх орон зай байхгүй гэсэн үг. Шилжиж байгаа хөрөнгө оруулалт дээр тодорхой үргэлжилж байгаа ажлууд явна. Гадаадын зээл тусламжийн төслүүдийн ашиглалтыг бол нэмэгдүүлээд явах ийм л бололцоо байгаа. Одоо энэ дотор байгаа ороод ирчихсэн 88 санал бол миний ойлгож байгаагаар урсгал зардал дээр бол ойролцоогоор 500 орчим тэрбумыг бол нэмэгдүүлэхээр байгаад байгаа юм. Энэ нь цалин хөлснөөс гадна одоо бусад төрлийн одоо хүүхдийн хоол ч гэдэг юм уу урсгал зардал дээр суудаг зардлуудыг 500 орчим тэрбумаар нэмэгдүүлэх ийм саналууд байна.

Дээрээс нь шинээр орж ирж байгаа хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд байна. Тэгээд яг бодит байдал дээр бол төсөв дээр ийм орон зай Батболд гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

3 асуулт байна. Нэгдүгээрт нь гишүүдийн оруулж ирж байгаа саналыг энэ нь хууль зөрчсөн байна энэ нь хуулийн шаардлага хангахгүй байна гэж яг ийм дүгнэлт гаргаад байгаа хэн нь тэгж дүгнэлт гаргаад энэнээс хасчихсан юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь энэ 2.2 их наядаар нэмэгдэж орж ирээд байна шүү дээ. Одоо энэ ажлын хэсгийн боловсруулсан санал. Тэгэхээр энэ дээр одоо 2027 онд шинээр эхлэх гэдэг юм уу тийм төсөл арга хэмжээнийх нь одоо төсөв нь хэд байгаа бол? Энийг та хэд харсан уу?

Тэгээд 3 дугаарт нь бол нэг зүйл хэлмээр байгаа юм. Бид нар энэ Төсвийн тухай хууль Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль ч байдаг юм уу энэ хоёрыгоо 1 эргэж харж үзэхгүй бол ингээд жилийн төлөвлөгөө дээр бөөн асуудал болоод байдаг. Хөгжлийн одоо ирэх жилийнхээ хөгжлийн төлөвлөгөөнд тусаагүй төсөл арга хэмжээ бол одоо төсөв дээр тусах боломжгүй болчих гээд байдаг. Тийм заалтууд байгаад байгаа. Тэгэхээр энэн дээр ер нь Эдийн засаг хөгжлийн яам юу гэж бодож байгаа юм? Энэ 2 хуулийн энэ заалтуудыг өөрчлөхгүй бол бид нар ингээд ирэх жилийн төлөвлөгөө ярихаараа л нэг төсөв шиг юм яриад байдаг. Энийг нэг болиулах арга хэмжээ авах уу, яах ёстой юм энийг ер нь.

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагчаар ажилласан Лувсанжамц гишүүний микрофоныг нээе. Дараа ажлын хэсэг бас бэлдэж байгаарай.

Г.Лувсанжамц: Батболд гишүүний 1 дүгээр асуулт 3 дугаар асуултад хариулъя.

Эхний асуултын хувьд 4.3 их наяд төгрөг байсныг нь 2.3 их наяд төгрөг болгож бууруулаад ажлын хэсэг дээр бол нийтдээ 411 тэрбум төгрөгийн л одоо санхүүжилт шаардлагатай 12 саналыг үлдээсэн. 12-оос 8 нь бол тогтоолын төсөл болон шалгуур үзүүлэлт бэлтгэл ажил зэрэг төсөв мөнгө шаардлагагүй ажлууд байгаа. Бусад саналууд нь бол орон даяар одоо хэрэгжиж байгаа үйл ажиллагаануудын төсвийн одоо боломжийг нэмэгдүүлж өгье өө гэсэн саналтай байгаа.

Үлдсэн гишүүдийн гаргасан 76 саналын хувьд бол зураг төсөл ТЭЗҮ-тэй байгаа эсэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна уу үгүй юу гэдгийг нь бол зарчмын шаардлага болгож тавиад оруулж ирсэн. Гэхдээ нийтдээ 203 саналаас 115 нь шаардлага хангахгүй юм байна энэ саналуудыг санал хураах боломжгүй гээд ажлын хэсэг дээр бол хэлэлцээгүй үлдээсэн байгаа. Тэгэхлээр зарчмаа бариад ажилласан гэсэн үг.

Гурав дахь асуултын хувьд бол хөгжлийн төлөвлөгөө яг төсөвтэйгөө адилхан болчхоод байгаа асуудал бол байгаа дээр яг санал нэг байна аа. Их Хурлын даргын 523 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийг би ахалж ажиллаж байгаа. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болон дагах хуулиудаар Төсвийн хууль зэргийг хөндөхөөр ажлын хэсэг дээрээ ажиллаад явж байна. Одоогийн үзэл баримтлалын хүрээнд бол хөгжлийн төлөвлөгөө дээр төсвийн хөрөнгө оруулалтыг ерөөсөө тусгахгүй гэсэн зарчмыг баримталж байгаа. Зөвхөн төр хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл тусламж мөн 5 жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг хангах хүрээнд хэрэгжүүлэх арга замуудыг тавина

уу гэхээс биш төсөл арга хэмжээг бол хэзээ ч тавихгүй гэсэн тийм байдлаар үзэл баримтлалыг боловсруулаад явж байгаа. Тэгэхээр энэ хуулиа 126 гишүүнээрээ хэрвээ дэмжээд баталж чадах юм бол цаашдаа ирэх жилээс хөгжлийн төлөвлөгөө дээр төсөв батлах гэж байгаа юм шиг ийм хэлэлцүүлгүүд бол өрнөхгүй гэсэн зүйлийг хэлмээр байна аа.

Б.Заяабал: Бодлогын яамны санал хариулт сонсьё. 3 номерын микрофон.

С.Даваасүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгээс гарч байгаа дүгнэлт болон Төсвийн тухай хууль, Хөгжлийн төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль дээр бас хуулийн тэр зохих заалтуудыг өөрчлөх ажлууд бол бас энэ ажлын хэсгээс гарсан. Тэгээд Лувсанжамц гишүүн бол үүнд тодорхой хариуллаа. Одоогийн байдлаар бол яг ажлын хэсгээс дэмжигчид орж ирсэн 12 ийм төсөл бол байна. Тэгээд 12 төслийн дүнгийн тухай бол сая хэллээ 413.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай. Энэ нь болохоор 7 төсөл нь ийм санхүүжилт шаардлагатай бөгөөд 5 нь санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжихээр байгаа. Үлдсэн одоо сонгогдсон 88 төслөөс ингээд 12 нь ийм дүнтэй байгаа бол үлдсэн 76-аас үндсэнд үндсэндээ 52 нь болохоор нэмэлт санхүүжилт шаардагдахгүй гэсэн ийм тооцоолол бол гарсан байгаа. Шинээр эхлэх бөгөөд шинээр одоо санхүүжилт байхгүй гэсэн ийм дүн гарсан байгаа.

Б.Заяабал: Батболд гишүүн нэмэлт тодруулга.

Р.Батболд: Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн тэр 6.2. дээр өөрчлөлт орж байгаа гэж Лувсанжамц гишүүн хэлж байх шиг байна.

Тэгэхээр яг тэрийг өөрчлөх шаардлагатай байна гэж. Тэгээд ер нь нэг санал хэлмээр байгаа юм, Эдийн засаг хөгжлийн яам. Энэ зүгээр энэ төсөл арга хэмжээг ингээд задлалгүйгээр нэргүйгээр байдаг юм уу одоо салбар салбараар нь тэчнээн төгрөгийн санхүүжилт, тэчнээн, төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ гэдэг юм уу тийм байдлаар оруулж ирээд төлөвлөгөөгөө батлуулаад явж байсан нь дээр юм шиг надад санагдаад байгаа юм. Одоо эрчим хүчний салбарт тэдэн төгрөг боловсролдоо тэд, эрүүл мэнддээ тэд ч гэдэг юм уу. Дэд бүтэцдээ тэдэн төгрөг гэдэг юм уу зүгээр ингээд нэг багц оруулж ирээд тэрийгээ одоо бид нар нийт дүнгээр нь батлуулж явчхаад зүгээр доторх тэр зардлын задаргаагаа төсөв дээрээ харин яаж тарааж байршуулах ёстой юм? Тэгж явж байхгүй болохоор энэ чинь ерөөсөө ингээд нэрээрээ явахаар ингээд бөөн задаргаатай болчихоод балраад байдаг. Тэгээд одоо.

Б.Заяабал: Дахиад нэг минут. Батболд гишүүний минут нэг минутыг нэмж өгье.

Р.Батболд: Одоо ингээд энд дэмжигдээд хурлаар дэмжигдээд 2.2 их наяд орчихоор та хэд одоо яах юм. Тэрийгээ нэг хариулж өгөөч. Одоо нөгөө урсгал зардал танай сайд чинь одоо та нар байж байж наадхаа болиулах гээд байсан гээд л загнах байх даа.

Б.Заяабал: 4 номер. ажлын хэсгийн 4 номерыг өгье.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яам Мөнгөнсүх гишүүний асуултад хариулъя аа. Нийтдээ 88 санал одоо орж ирж байгаа. Энэний нийт дүн нь 2.2 их

наяд байгаа. Ажлын хэсэг дээр яригдаад энэ нь 88-аас 12-ыг нь дэмжсэн байгаа. Үүнээс санхүүжилт шаардлагатай нь бол 8 төсөл арга хэмжээ байгаа. Энэ 8 төсөл арга хэмжээний нийт дүн нь бол 413 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа.

Б.Заяабал: Лувсанжамц гишүүн ажлын хэсгийн ахлагч нэмж тайлбар өгье.

Г.Лувсанжамц: Тийм. Батболд гишүүнтэй бас санал нэг байна аа.

Тогтоолын төсөл дээр оруулж байгаа хамгийн эхний санал байгаа ажлын хэсгээс оруулж байгаа энэ болохлоор жилийн төлөвлөгөөнд туссан төсөл арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал гэдэг зүйлийг үнэлгээний үзүүлэлтийг нь боловсруулаад намрын чуулгандаа багтаж өргөн барь гэж байгаа юм. Энэ бол Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яаманд өгч байгаа даалгавар гэсэн үг. Одоо яг бид нарт олон төслүүд энэ 88 төслүүдийг аль нь үр нөлөө үзүүлэх юм, үзүүлэхгүй юм бэ гэхлээр яг нэгдсэн аргачлал нь байхгүй байгаа учраас энийгээ боловсруулаад ир гэж байгаа юм.

Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам өөрсдөө энэ 88 саналууд болон Засгийн газраас өргөн барьсан төсөл арга хэмжээг ч гэсэн үнэлээд аль нь хэрэгжихэд илүү үр өгөөжтэй байх юм, аль нь үр өгөөж нь бага байх юм гэдэг тэрүүгээр нь эрэмбэлээд буюу 3 дугаар санал дээр байгаа эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлэн гэсэн энэ 2 зүйлийг хэрэгжүүлэх даалгаврыг өгч байгаа учраас намрын чуулгандаа энэ зүйлийг Засгийн газраас хүлээгээд сууна гэж бодож байна.

Б.Заяабал: Баярлалаа. Баатархүү гишүүний микрофон өгье.

Ц.Баатархүү: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Нэгдүгээрт яах вэ энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгаа гэдэг нь бол харагдаж байгаа. Төсөв дээр тавиулахын тулд хөгжлийн бодлого төлөвлөгөөний хуулийн хүрээнд гээд энэ төлөвлөлт дээр санал оруулаад уралдаад байгаа гэдгийг та бүхэн бүгдээрээ ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр Засгийн газар өөрөө энэ дээрээ хариуцлагатай баймаар байна. 2027 оныг одоо ямар жил болгож зарлаж байгаа юм. Тэргүүлэх жил нь юу юм. Нэн тэргүүний зорилгууд нь юу юм бэ гэдгээ хэлээд энэ жилийн төсөв хөгжлийн төлөвлөгөөнд ийм ийм тэргүүлэх зорилтуудын хүрээнд гишүүд ингээд саналаа өг өө гэж хэлэхгүй бол гишүүн болгон тойргийнхоо саналыг өгнө шүү дээ. Энэ гишүүдийн буруу биш. Цаана нь байгаа сонгогчид бол ийм зүйлийг өг өө гээд албан бичгээр өгөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр 1 дүгээрт энэ хуулийг өөрчилье гэж байгаа.

Хоёрдугаарт нь энэ Эдийн засаг хөгжлийн яамныхан нэн хариуцлагагүй байна аа. Шулуухан хэлье. Одоо ингээд энэ лоббитой нь ингээд төслөө оруулдаг ийм байдлаар улс орон хөгжихгүй ээ. Хэн ажлын хэсэгт ойрхон байгаа нь ингээд саналаа хавчуулаад байх юм бол энэ улс оронд зөв зүйтэй газраа хөрөнгө оруулалт явахгүй. Та бүхэн яах ёстой юм бэ гэхээр энэ дэлгэц дээр шударгаар энд сургууль барья гэвэл энд үнэхээр сургуулийн хүртээмж байхгүй байна гэдгийг харуул л даа.

Энэ зайлшгүй юм гэдгийг харуулах юм бол гишүүд ойлгоод шууд дэмжинэ. Үнэхээр энэ Увс аймгийн малчин сумд сургууль хэрэгтэй гэвэл бид нар дэмжээд л явна. Ийм байдлаар одоо нийслэл бол төсвөө баталдаг байсан. 2012-2016 оны хооронд. Төлөөлөгч болгон лобби хийх энэ байдлыг нь бид нар хязгаарласан. Дэлгэц дээр шууд датаг нь өглөө. Уучлаарай энэ хороон дээр чинь цэцэрлэг хангалттай юм байна аа. Цэцэрлэг барих бол одоохондоо шаардлагагүй юм байна гээд яв л даа. Ийм байдал руу оруулж болохгүй юм уу гэдэг ийм асуултыг асууя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

С.Даваасүрэн: Гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т бол заасан байгаа. Санхүүжилтийн эх үүсвэрээ тодорхойлсон шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг бас тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ зураг төсөв нь батлагдсан, тухайн жилдээ хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг эрэмбэлнэ гээд.

Тэгэхээр яг энэ шаардлагынхаа дагуу төсвийн 36 ерөнхийлөн захирагчдаас ирэх онд одоо хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийн жагсаалтыг жагсаалт болгоноор нь Эдийн засаг, хөгжлийн яам энэ оны 1 дүгээр сард авсан. Тэгэхээр одоо төсвийн ерөнхийлөн захирагч болгон энэ дээр эрэмбэлтээ хийсэн гэсэн үг. Энэ хийсэн эрэмбэлтээс нийтдээ манайд 669 одоо төсөл хөтөлбөр арга хэмжээний санал ирсэн. Энэ 669 одоо хөтөлбөрийн саналаас саналын дүн нь бол 22.3 их наяд байсан. Үүн дээр Эдийн засаг, хөгжлийн яам эргээд одоо тэр эрэмбэтэй нь холбоотойгоор буцаж төсвийн ерөнхийлөн захирагчид ажлын хэсэгтэй нь бүгдээрэнтэй нь уулзаж ярилцаад үүнээсээ 310-ыг сонгож авсан. Үүнд нь 124 төсөл, 186 арга хэмжээг. Одоо энийг хийх хугацаандаа бид нар 4, 5 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Бусад холбогдох бүх яамдтай нь одоо уулзаж ярилцаад үүн дээр 15.3 их наяд төгрөгийн 310 төслийг 2027 онд санхүүжүүлэх боломжтой юм байна гээд.

Үүнээс 2.2 их наяд нь улсын төсвөөс санхүүжих боломжтой. Бусад нь гадаад зээл, дотоодын хөрөнгө оруулалт, гадаад хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн одоо түншлэл гадаадын тусламжаар хийгдэх боломжтой юм гэсэн. Энэ оажлуудыг хийж оруулж ирсэн юм аа.

Таны асуусан 2 дугаар асуултын хувьд бол ирэх онд Засгийн газраас эрчим хүчний салбар, эрүүл мэнд, хүний хөгжлийн одоо чиглэлээр явуулах үйл ажиллагааг нэлээд онцолж байгаа бөгөөд Засгийн газрын зарласан 4 чөлөөлөлтийн хүрээнд, тэр дундаа эдийн засгийн чөлөөлөлт эрх зүйн боломж чөлөөлөлт, ногоон хөгжил мөн авлигалын эсрэг чөлөөлөлт гэсэн энэ одоо арга хэмжээнд энэ бодлогын хөтөлбөрөө 2027 оны бодлогын хөтөлбөрөө чиглүүлж багцалж оруулж ирсэн байгаа байгаа.

Б.Заяабал: Баатархүү гишүүнд нэг минутад нэмж өгье.

Ц.Баатархүү: Энэ Эдийн засгийн байнгын хорооноосоо одоо ер нь эхлээд энэ хууль энэ тэрээ энэ эрэмбэлэлтээ хийгээд эхэлье гэж бодож байна. Бас шинэ удирдлагатай болсон. Одоо үнэхээр энэ чөлөөлье гэж байгаа бол нэг ч аймаг, дүүрэг, суман дээр энэ төр захиргааны байшин барилга баримааргүй байна. Үнэхээр төрийг цомхон болгоё гэвэл. Энэ Засгийн газрын бодлогоо дагаж энэ

эрэмбэлэлт чинь явах хэрэгтэй шүү дээ. Үнэхээр энэ эрчим хүчний чиглэлд реформ хийе гэвэл жишээ нь Очирбат гишүүний санаачилж байгаа энэ сэргээгдэх эрчим хүчний төслүүд чинь орох ёстой. Энэ гаалийн шинэчлэл чинь орох ёстой. Энд бол хатуу болон зөөлөн дэд бүтцийн шинэчлэлүүд орох ёстой. Тэр олон программ хангамж биш юм гэхэд тэр программ хангамжийн цаана чинь маш олон ийм хатуу дэд бүтцүүд байгаа шүү дээ. Дата төвөөс авхуулаад. Тэгээд энэ дээр чинь ингээд манай цахим яамныхан энэ тэр оролцоод үнэхээр энэ Тендерийн хууль муулиа ингээд сайн зохион байгуулаад ингээд чөлөөлөлт явуулъя гэдэг энэ үйлдэл чинь энд байх.

Б.Заяабал: Санал хэлсэн үү гишүүн ээ? Санал хэлсэн байна. Батнайрамдал гишүүний микрофоныг.

О.Батнайрамдал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Гэхдээ ажлын хэсгээс орж ирсэн саналууд бол миний харж байгаагаар бол нэлээн цэгцлээд ороод ирчихсэн байна шүү дээ. Анх бол энэ чинь 203 зарчмын зөрүүтэй санал 4.3 их наяд байсан. Энийг бүр наян наймхан болгоод оруулаад ирсэн байна шүү дээ. Тэгээд ер нь зарчмуудаа нэмж тусгаад нэг ёсондоо засгаас тэр зарчим нь орж ирэхгүй болохоор ажлын хэсэг дээрээ зарчмаа тусгаж байгаад 88 зарчмын зөрүүтэй санал орж ирсэн гэж харж байна л даа. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргах Үндсэн хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар олгосон бүрэн эрхтэй шүү дээ. Бид нар Улсын Их Хурлын тогтоол байна уу, Улсын Их Хурал дээр орж байгаа хууль байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргах бүрэн эрхтэй шүү.

Тэгэхээр нэг гишүүд хамаа замбараагүй санал гаргаж ирчхээд тэгээд энэ нь болохгүй байгаа даа гэж бас яримааргүй байгаа юм. Хамгийн гол нь 2027 оны хөгжлийн төлөвлөгөө энэ 2027 онд орж ирэх төсөв 2-ын ялгааг нь өөрсдөө аягүй ойлгомжтой гаргаж ирэх хэрэгтэй.

Хөгжлийн төлөвлөгөө гэдэг бол илүү том зургаар гаргасан зарчмаа тусгасан. Сая Баатархүү гишүүн бас хэлээд байна л даа. Яг ингээд эрэмбэ тогтоосон ийм зүйл яг гарч ирэхгүй. Яг төсөв шиг адилхан форматтай документ яг төсөв шиг ингэж орж ирээд байхаар чинь энэ чинь бас бид нарт бас яг л адилхан л авч үзэхээр л харагдаад байна шүү дээ. Тэгэхээр 1 ойлгомжтой зүйл бол тэр хууль дээр бол заавал өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай байна.

Хоёрдугаарт ажлын хэсэг миний харж байгаагаар бол энэ чинь бас нэлээн саналыг хасаад зарчмаа тусгаад л оруулаад ирчихсэн байна шүү дээ. Тийм учраас одоо бүгдээрээ энэ дээрээ санал хураалтаа явуулаад тэгээд дараа жил хуулийн өөрчлөлт орохоор бүүр ойлгомжтой болох ёстой л гэж харж байна.

Б.Заяабал: Баярлалаа. Үг хэллээ. Батнайрамдал гишүүн үг хэллээ.

Би нэг асуулт бас асууя. Энэ Их Хурлын гишүүд маань жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр санал гаргаад байгаа юм. Би бол бодохдоо энэ бол яг Монгол Улсын нөгөө хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.10-д нийцүүлээд саналуудаа гаргаж байна гэж ингэж үзэж байгаа. Тухайлбал миний хувьд гаргасан саналууд бүгдээрээ л яг энэ хуульд нийцэж байгаа. Ийм санал гаргасан 6.10.1 дээр

6.10.2 дахийг одоо жишээлбэл хангасан, өөрөөр хэлбэл 6.10.1 дээр энэ Засгийн газрын бодлого чиглэлд нийцсэн байх тусгагдсан байх ёстой.

6.10.2 дээр энэ санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлсон шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг одоо тооцсон ТЭЗҮ зураг төсөв нь батлагдсан байх ёстой гээд. Яг энэний чинь дагуу батлагдчихсан бүүр магадлал нь хийгдчихсэн ийм төслүүдийг жишээлбэл би бас санал болгож оруулсан.

Тэгээд энэ дээрээ би яг энэнтэй холбоотой би асуух гээд байгаа юм. Эдийн засаг хөгжлийн яам, Сангийн яамнаас.

Жил болгон энэ төсөв дээр ТЭЗҮ зураг төсөв хийхээр мөнгө тавигддаг. Тэгээд яг энэний чинь дагуу төслүүдээ шалгаруулаад та нар өөрсдөө шалгаруулаад яг ийм ийм төслүүд хөгжлийн бодлоготойгоо нийлүүлээд ТЭЗҮ зураг төсвөө хийгддэг гэж үзэж байгаа. Тэрний чинь дагуу магадлал нь хийгддэг гэж үзэж байгаа. Тэгээд магадлал нь ч Төсвийн тухай хуулиараа билүү энэ чинь Барилгын хуулиараа 2 жилийн хугацаанд магадлал нь хүчинтэй байдаг. Ингээд 3 дахь жил рүүгээ болохоор магадлал нь хүчингүй болчихдог. Одоо тийм ажлууд аягүй олон байна л даа. Тэгээд энэ дээр чинь та нарт жишээлбэл тодорхой тооцоолол байхгүй байгаа юм уу? Хэчнээн ажлын зураг төсөв нь хийгдчихсэн хэчнээн ажил байгаа юм. Магадлал нь орчихсон хэчнээн ажил байгаа юм. Тэрний хэд нь энд тавигдаж байгаа юм. Одоо магадлал нь хийгдчихсэн 3 дахь жил нь өнгөрчихсөн хэчнээн ажлуудыг та нар санхүүжүүлэхгүй энэ төсөвтөө энэ хөгжлийн хөтөлбөртөө оруулж ирэхгүй үлдээж байгаа хэчнээн ажил байгаа юм бэ. Хэрэвзээ та нар ингээд зураг төсөв хийгдээд магадлан хийгдээд энийгээ төсөвт тавьдаггүй юм бол жилийн төлөвлөгөөнд оруулж ирдэггүй юм бол тэгвэл та нар анхнаасаа яах гэж энийг хийгээд байгаа юм бэ.

Төсвийн мөнгийг яагаад ингээд үр дүнгүй ажилд зориулаад байгаа юм бэ гэсэн ийм асуултад хариулт авмаар байна аа. Ажлын хэсэг хэдэн номер вэ?

Ажлын хэсгийн 3 номероос эхэлье. Дараа нь Сангийн яам бас хариулаарай.

С.Даваасүрэн: Тэгэхээр 2027 оны одоо хувьд ТЭЗҮ эх үүсвэрийн шаардлагатай эсэхэд манай ажлын хэсгийнхэн бэлдэж байгаарай. Зүгээр Улсын Их Хурлын гишүүдээс 2027 оны төлөвлөгөөнд бол нийтдээ 11 төсөл арга хэмжээнд 608 тэрбум төгрөгийн 2024 оны төлөвлөгөөнд бол тусгагдсан байдаг. Энэ арга хэмжээний үнэлгээг 2024 оны байдлаар авч үзэхэд бол нийтдээ нэг 28 хувийн л хэрэгжилттэй гарсан байгаа юм. Харин 2025 оны хувьд бол нийтдээ нэг 13 төсөл арга хэмжээний 125 тэрбум төгрөгийн санхүүжилттэй гээд тусгагдсан байдаг. Тэгээд үүний бас нэг хэрэгжилтийн үр дүн нь бол нэг 57 хувьтай гарсан. Яагаад ингээд энэ хэрэгжилтийн үр дүн өмнөх оноосоо ийм илүү өндөр гарав гээд ингээд үзэхээр 2024 оны хувьд бол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө нь 10 сард Улсын Их Хурлаар хэлэлцэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл төсвийн одоо төсвийг өргөн барьсны дараагаар хэлэлцэгдсэн учраас тэнд байсан саналууд нь тусгагдаад эндээсээ давхцал үүсээд гарсан учраас одоо хэрэгжилтийн үр дүн нь 57 хувьтай гэж гарч байгаа.

Харин 2026 оны хувьд бол нийтдээ нэг 40 төсөл арга хэмжээнд 1 их наяд гаруй төгрөгийн одоо санхүүжилтийг гишүүдээс олж нэмээд тусгасан байдаг юм байна лээ. Тэрний үр дүн бол ирэх 2027 онд бол хэрэгжилтийн үйл явцыг нь бол гаргах боломжтой. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр болохоороо нэг 1 их наяд 1.3

их наяд төгрөгийн одоо санхүүжилт хийгдэхээр тусгагдсан байгаа. ТЭЗҮ-ийн хувьд бол Сангийн яамнаас хариулья.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номерын микрофон нээж өгье.

Б.Анар: Сангийн яам Анар. Заябал гишүүний асуултад хариулья. 2023, 2024, 2025 оны хувьд бол ТЭЗҮ зураг төсөв боловсруулах энэ зардлын төсөв бол Эдийн засгийн хөгжлийн сайдын багц дээр бол бөөн дүнгээрээ бол тавигдаад явсан. 2023 онд бол нийтдээ 40 тэрбум. Үүгээр бол нийтдээ 133 төсөл арга хэмжээг төлөвлөөд яг гэрээ байгуулж чадсан нь бол 46 төсөл арга хэмжээ. Нийтдээ 32.5 тэрбумын гүйцэтгэлтэй. 2024 онд бол нийтдээ бас 40 тэрбум тавигдсанаас 78 төсөл арга хэмжээ төлөвлөөд яг гэрээ байгуулж чадсан нь 62, гүйцэтгэл нь бол 29.8 тэрбум гарсан. 2025 онд бол 20 тэрбум төгрөг тавигдаад 40 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс гэрээ байгуулж амжсан нь бол гэрээ байгуулсан нь бол 19, гүйцэтгэл нь бол ингээд 7.4 тэрбум төгрөг бол гарсан ийм гүйцэтгэлтэй бол байгаад байгаа юм.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгээд удахгүй бас 2025 оны төсвийн одоо гүйцэтгэл орж ирнэ. Тэр үед бас манай гишүүд бас нэлээдгүй анхаарал хандуулах нь зөв байх гэж ингэж бодож байгаа. Саяын асуудал бол чухал асуудал байгаа. Энэнтэй бас жилийн төлөвлөгөөтэй бас их уялдаатай асуудал байгаа гэсэн ийм саналаа хэлье ээ.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг байхгүй юм байна дэгээрээ. Одоо гишүүд асууж дууссан. Одоо хуульд нийцүүлж гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгийн зүгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье ээ.

Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Ингээд ажлын хэсгийн оруулж ирсэн санал.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх;

“3/Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Г.Лувсанжамц, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, Н.Наранбаатар, М.Нарантуяа-Нара, Г. Очирбат, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ч.Ундрал, Г.Уянгахишиг /Цаашид ажлын хэсэг/.

Санал хураалт.

78.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх;

4/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсвийн төслийг боловсруулахдаа бүрэн тусгасан байх; Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтын “төсөл, арга хэмжээг” гэснийг дараа “эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлэн өндөр үр өгөөжтэй төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжид” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

5/“Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулж бүс нутгийн түвшинд хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт манлайлан, хүний эрхийн салбарын хамтын нийгэмлэг, үндэсний хүний эрхийн байгууллагууд /NHRI/, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, судалгааны зангилаа төв болон хөгжиж, аялал жуулчлал шинэ урсгалыг бий болгож, эерэг үр дүн гарна.” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

69.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-6.4.7, 6.4.9, 6.4.11, 6.4.16, МУХТЖҮЧ-6.2.1.1, ЗГҮАХ-3.4.2.1, 3.4.2.2”, Төсөл, арга хэмжээ “Айл өрхийн сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид зориулсан ногоон зээлийн хүүгийн татаас олгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл нэвтрүүлсэн айл өрхийн тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5,000” гэж, Зорилтот түвшин “38,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “300,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

69.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.8 дахь дэд заалтын “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ” гэснийг “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3,

МУХТЖҮЧ-1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1” гэснийг “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.2.1, 2.3.1.1” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.3 дахь дэд заалтын “Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах ажиллагаанд хүнгүй техник хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Суурь он “2025” гэснийг “2024” гэж, Суурь түвшин “102” гэснийг “10” гэж, Зорилтот түвшин “112” гэснийг “20” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэснийг “3,300.0” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Хүний эрхийн боловсрол, судалгаа шинжилгээний бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5, 5.1.8”, “МУХТЖҮЧ-7.6.1”, “ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “900.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “900.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гадаад харилцааны яам” гэж, Хамтран хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “6-9 дүгээр ангийн нийт 263808 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээлэх хоног 180 нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 3500 төгрөг/” гэж, Шалгуур үзүүлэлт “6-9 дүгээр ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “228,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “228,300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2 дахь заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.20, 2.1.25, МУХТЖҮЧ-1.1.2.3, ЗГҮАХ-2.2.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн сурагчдын Монгол хэлний

чадварыг сайжруулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Бага ангийн сурагчдын эх хэлний чадавхыг сайжруулах “Эрдмийн түлхүүр” төсөл хэрэгжүүлэх” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “341,000” гэж, Зорилтот түвшин “341,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,820.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,820.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11 дэх санал уншихаас өмнө яамдуудын Төрийн нарийн бичгийн дарга нар үлдээд бусад хүмүүс явж байж болно гэсэн ийм саналыг гишүүд гаргаж байгаа учраас ажлын хэсэг зохион байгуулалтад орохыг хүсье.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.14, 2.1.26, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад шим тэжээллэг хоолны үйлчилгээг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Бага ангийн нэг суралцагчийн сургуулийн хоолны үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Төгрөг” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “2500/3400 төгрөг” гэж, Зорилтот түвшин “3500/4000 төгрөг” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “65,448.4” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “65,448.4” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.14, 2.1.26, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад шим тэжээллэг хоолны үйлчилгээг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Дотуур байрны нэг хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын санхүүжилтийн хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Төгрөг” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “6000/6300 төгрөг” гэж, Зорилтот түвшин “8000/8300 төгрөг” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “7,342.5” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,342.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналуудаар санал хураалт явуулна. Саналын томъёоллыг уншиж танилцуулна.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.8”, “МУХТЖҮЧ-6.2.2.1”, “ЗГҮАХ-3.3.3.6, 3.3.3.9, 3.3.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур

үзүүлэлт “Хөтөлбөрт хамрагдсан өрх” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “298,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “89,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат.

Очирбат гишүүн саналаа тайлбарлах үг өгье. Очирбат гишүүний микрофоныг нээе.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ.

Эдийн засгийн байнгын хорооны Их Хурлын гишүүд маань яг Монгол Улсын 2027 оны хөгжлийг ямар байдалтай байх вэ гэдгийг одоо өнөөдөр хэлэлцээд бид нар яриад сууж байна. Тэгээд одоогийн яг Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд Учрал маань яг энэ сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой төсөл хөтөлбөрүүдийг бол тууштай дэмжиж ер нь цаашдаа Монгол Улсын хөгжил бол энэ дэд бүтцийн салбар руугаа явах ёстой. Тэгж байж эдийн засгаа эргэлтэд оруулж солонгоруулна гэсэн ийм байр суурьтай байгаа. Яг энэнтэй холбоотой Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл үндсэн 4 зорилттой. 4 зорилтын 3 дээр ногоон хөгжлийн чөлөөлөлт гэж байгаа. Ногоон хөгжлийн чөлөөлөлтөө дотор нь арваад арга хэмжээ байгаа. Тэрний 2 дээр айл өрхийн нарны хавтан бага оврын нарны эх үүсвэрийг нэмэгдүүлэх гээд бүүр заагаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр бид нар Монгол Улсын сая 564м² талбай дээр 3.5 сая иргэн байгаа. Иргэд маань газраа өмчилчихсэн байдаг. Тэгэхээр иргэд маань оролцоод ААН-үүд маань оролцоод төр бодлогоор Монгол Улс энэ эрчим хүчний тусгаар тогтнолоо олсон ийм улс болоход бол бэлэн байдалд орчихсон байгаа.

Тэгэхээр 2027 оны хөгжлийн төлөвлөгөөн дээр энэ саналыг маань Улсын Их Хурлын эрхэм гишүүд маань дэмжиж өгөөрэй. Өрх бүр 20квт эрчим хүч үйлдвэрлэх юм бол эхний ээлжид 3 мянга гэдэг нь 21 аймгийн 9 дүүрэгт хэрэгжүүл гээд тухайн аймгууд маань сумаа сонгоод дүүргүүд маань алслагдсан хороодуудаа сонгоод ингээд жишиг ийм нарны энергийг өөртөө эрчим хүчээ хангаад илүүгээ төвд шилжүүлээд бас ийм орлого олох олох бололцоотой ийм хувилбарыг бас дэвшүүлсэн байгаа.

Тэгээд гишүүддээ дэмжиж өгөөрэй гэж хүсье. Та бүхэндээ маш их баярлалаа.

Б.Заяабал: Ажлын хэсэг бас энэ гишүүдийн гаргаж байгаа тайлбартай холбоотой нэмэлт одоо тодруулга шаардлагатай бол бас гараа өргөөд яваарай. Ингээд Очирбат гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

73.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх;

5/“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, гүйцэтгэгч, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн тайлан, аудитын дүгнэлтийг олон нийтэд нээлттэй цахим системээр улирал тутам мэдээлэж байх; Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Гишүүний саналаар санал хураалт явуулъя.

47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Буулгаж дахин барих цэцэрлэг 74 дүгээр цэцэрлэг Чингэлтэй дүүрэг 10-р хороо, Далан давхрын урд талд” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “буулгаж дахин барилгажуулах цэцэрлэг /56 дугаар цэцэрлэг/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас 3 номерын микрофоныг нээе.

С.Даваасүрэн: Энэ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйл дээр байгаа мөн Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолоор яамдын одоо бүтэц зохион байгуулалт, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай гээд Засгийн газрын тогтоолоор баталсан. Яг энэ хүрээнд одоо саяын ярьж байгаа асуудал бол Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны чиг үүрэгт бас хамаарагдахгүй байгаа. Өмнөх одоо санал хураасан асуудал ч гэсэн. Чиг үүргийн хувьд бол энэ Боловсролын яаманд л харьяалагдах байх.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүн санал хэлэх үү? Гаргасан саналтайгаа холбоотой. Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Тэгэхээр гишүүд юу юм байна? Тэгвэл 16, 17 дугаар саналууд дээр сая үндсэн хариуцагч нь Боловсролын яам гэдэг өөрчлөлттэйгөөр санал хураалт явуулж өгнө үү.

Б.Заяабал: Санал гаргасан гишүүн Батнайрамдал гишүүний одоо саналын дагуу уг саналыг санал хураалтыг явуулъя

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Саяын дэмжигдсэн саналыг Батнайрамдал гишүүний саналын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам биш Боловсролын яам гэдэг томьёоллоор санал хураасан байгаа гэдгийг хэлье.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Буулгаж дахин барилгажуулах цэцэрлэг /70 дугаар цэцэрлэг/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Ж.Дэлгэржаргал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал.

15, 16, 17 дугаар саналууд нэр томьёоны хувьд ч гэсэн ер нь бол хууль дээр тавигдаж байгаа барилгууд бол буулгаж шинээр одоо 70 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр барих гэж нэгд явдаг.

Хоёрт нь бол энэ 3 санал гурвуулаа зураг төсөвгүй байгаа. Одоо бид нарын мэдээллийн сан дээр зураг төсөв бүртгэгдээгүй. Тэгээд төсөвт өртөг нь бүгдээрээ 6.5 гээд яг ижил дүн байгаа байхгүй юу. Хөрөнгө оруулалтын ажил бол хаана баригдах ямар хүчин чадал байхаасаа хамаараад төсөвт өртгүүд бүгд ялгаатай байдаг.

Тэгэхээр 6.5, 6.5 гээд тэрбумаар өртгүүд нь ижил байгаа нэг маягийн зураг юм руу бид нарын одоо мэдээллийн сан дээр бол зураг төсөв байхгүй байгаа. Та энийг уншаарай.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүн би нэг Дэгийн тухай хуулиас хуралдаантай холбоотой нэг холбогдох заалт уншаадахъя.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт дээр хуралдаан даргалагч горимын саналаар нэг удаа санал хураалт явуулна аа. Хуралдааны хэлэлцэх асуудалд ороогүй асуудлаар мөн тухайн санал нь хуулиар тогтоосон журмыг зөрчиж байгаа бол санал хураалт явуулахыг хориглоно гэж заасан байна аа. Энэтэй холбоотой сая ажлын хэсгээс гаргасан тайлбартай холбоотой та хууль журамд нийцэж байгаа эсэх талаар та дахиад нэмэлт тайлбар өгөөч.

Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Сая саналууд дээр бол энэ бүгд дээр нь зураг төсвийг бид нар ажлын хэсэг дээрээ ч гэсэн бүгдийг нь чеклэсэн шүү дээ. Зураг төсөвгүй юмнууд бүгдээрээ хасагдчихсан. Миний зураг төсөв бас зарим дээр нь шалгаж амжаагүй байсан зарчмын зөрүүтэй саналууд бүгд хасагдчихсан. Тэгэхээр зураг төсөвтэй гэсэн саналуудаа бид нар энэ дээр ингэж оруулж ирсэн шүү дээ. Тэгэхээр Сангийн яаманд ямар архив байгааг мэдэхгүй. Гэхдээ ямар ч байсан бид нар энэ дээр зураг төсөв гэдэг наад захын шаардлага шүү дээ. Тэд нарыгаа бүгдийг нь чекэлж оруулж ирсэн гишүүдийн саналууд шүү. Баярлалаа.

Б.Заяабал: Хууль тогтоомжид санал гаргасан гишүүн Батнайрамдал гишүүнээс хууль тогтоомжид нийцэж байгаа гэсэн учраас уг саналаар санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

18.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12”, “МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Малчин сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “13,316.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,438.7” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар дэмжигдлээ. Баярлалаа гишүүд ээ.

19.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.1, ЗГҮАХ-2.2.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын 45 дугаар сургуулийн барилга буулгаж шинээр барих 960 суудалтай” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилга угсралт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “28,158.8” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “18,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал. Асуулт асуух дэг байхгүй юм байна.

Санал хураалт.

43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “10-12 дугаар ангийн нийт 134491 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээлэх хоног 185 нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 4000 төгрөг/” гэж, Шалгуур үзүүлэлт “10-12 дугаар ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “128,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах

санхүүжилт сая.төг “128,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.5 гэж, Төсөл арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Шинээр барьж эхлүүлэх сургууль” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “200,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “80,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах.

Ж.Галбадрах: Энэ ийм учиртай юм байгаа юм байна. Би нэмэх санал гээд бичээд оруулсан байхад өөрчлөх гэдэг дээр рруулж ирээд энэ төсөл маань өөрчлөх хэлбэрээр бичигдсэн байгаа юм. Энэ бол цоо шинээр эхлүүлэх сургууль гээд. Энэ жил 2027 оны төсөвт шинэ сургууль эхлэхгүй байгаа. Ийм учраас бид нар 108 сургууль, 95 цэцэрлэг барина гэдэг дээр ерөөсөө ямар ч шинээр сургууль тавигдаагүй учраас энийг шинээр эхлүүлэх 5 сургуулийг эхлүүлэх гэдгээр 10 сургууль явах гэдгээр нэг 200 тэрбум төгрөг тавьсан юм байгаа юм аа.

Тэгээд энэ зөвхөн улсын төсөв биш дотоодын хөрөнгө оруулалтыг бас оруулсан. Ийм төсөв дээр энэ жилдээ нэг 80 тэрбум гээд. Тэгэхгүй бол бид нар нөгөө 40 хүүхдээс доош барина гэсэн зорилтоосоо ухраад байгаа. Ерөөсөө энэ жилд шинээр эхлүүлэх төсөв тавигдсангүй бас АХБ-ны зээл хөнгөлөлттэй зээл бас орж ирж байгаа. Энийг ингээд тооцож оруулж ирсэн юм байгаа юм аа. Ингэхээр та бүхнийгээ дэмжиж өгөхийг хүсье ээ. Шинэ сургуулийн юм орж ирж байгаа. Түүнээс өмнө энд томьёолсон санал нь бол нэмэх гэдгийг маань өөрчлөх гээд бүүр багасгаад биччихсэн байгаа. Тэгэхээр бүүр цоо шинээр томьёолол оруулж ирсэн байгаа юм.

Б.Заяабал: Галбадрах гишүүний гаргасан саналын дагуух шинэ томьёоллыг дахиж уншиж өгье өө.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад бодлогын үндэслэл “АХ-2.1.26” гэж МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15 гэж Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Шинээр барьж эхлэх сургууль гэж”, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь он “2025” гэж, суурь түвшин “5” гэж, зорилтот түвшин “10” гэж, нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “80 тэрбум” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, дотоодын хөрөнгө оруулалт гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Галбадрах. Ийм шинэ томьёоллоор найруулж байна. Энэтэй холбоотой ажлын хэсгээс нэмэлт тодруулга. 4 дүгээр микрофон, Эдийн засаг, хөгжлийн яам.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яам Мөнгөнсүх нэмэлт мэдээлэл өгье өө. Төсөлд орж ирж байгаа 53 сургууль гэдэг бол боловсролын жилийн хүрээнд гаргасан хөтөлбөр, 108 сургууль, 95 цэцэрлэг гэдэг одоо тэр төлөвлөгөөний дагуу явж байгаад төслүүдийг яг хаана байх байршил нэг бүрээр нь тодорхой гаргаж ирсэн. Шинээр нэмж сургууль барих энэ санал дээр хаана ямар сургууль, яаж баригдах вэ, ямар зураг төсөл, ямар өртгөөр баригдах вэ гэх зэрэг мэдээллүүд хуулийн дагуу тодорхой байх шаардлагатай болно оо.

Б.Заяабал: Хуулийн шаардлага хангаагүй. Зураг төсөв хаана баригдах нь тодорхойгүй гэсэн. Тэр яамны мэргэжлийн яамнаас сая бол шаардлага хангаагүй хуулийн шаардлага хангаагүй төсөл гэсэн санал тайлбар өгч байна л даа. Та нэмэлт нэг тайлбар өгөх үү? Нэмэлт нэг тайлбар өгье.

Ж.Галбадрах: 53 төсөл хөтөлбөр маань үргэлжилж байгаа төсөл хөтөлбөрүүд байж байгаа. Бид нар шинээр 108 төсөл баригдана гээд Сангийн яамтай бол бид нар яриад одоо нэг 86 үлдчихээд байгаа. 86-аасаа бид нар энэ цааш нь барихгүй бол ерөөсөө энэ нөгөө хүүхдийн эрх зөрчигдөөд байгаа 40-өөс дээш давсан гэдэг маань ерөөсөө багасахгүй болчихоод байгаа. Ийм учраас шинэ төсөл эхлүүлэх гэдэг утгаар нь оруулж ирсэн юм байгаа юм шүү. Байршлыг бол нийслэл дээр 33 газар бол чөлөөлчихөөд байгаа. Тэгээд энд 43 газар чөлөөлснийг одоо Лука гишүүн бид нар бол одоо байршил байршлаар нь мэдэж байгаа. Тэгээд АХБ-ан дээр 10 сургуулиар ер нь юу маань багасчихсан байгаа.

Б.Заяабал: Нэмэлт яг хууль тогтоомжид нийцэж байна уу үгүй юу гэдэг дээр дахиад нэг нэмэлт тайлбар өгөөдөх дөө. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний санал дээр нэмэлт тайлбар өгье. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дээр бол яг тодорхой шаардлагууд нь бол байгаа. Тэгээд энэ дээр нөгөө бүхэл дүнгээр яг ингээд бүхэл тоо тавихаар илүү нөгөө тодорхой болгох шаардлага байна. Хэрвээ яг бид нар одоо 108 сургууль бол энэ жилийнхээ хэрэгжиж байгаа төслүүдийг оруулахаар хэрэгцээ нь 86 болчихсон байгаа. Яг энэ 86-аасаа төслүүд явна гэвэл эх үүсвэрүүдээ нэмж тавих шаардлагатай.

Хэрвээ улсын төсөв энийгээ яг төсөв дээрээ тодорхой болгох ч юм уу. Тэгэхээр дүн тавьж байгаа учраас яг хэдэн төсөл хаана ямар одоо хүчин чадалтай гээд тодорхой болгох асуудал бол хуулийн шаардлага бол байгаа. Тэгэхээр эх үүсвэрээ бас бүх эх үүсвэрийн хүрээнд гэвэл нийслэл, магадгүй нийслэл дээр яг чөлөөлсөн газрууд дээрээ төсөл хэрэгжүүлнэ гэвэл орон нутгийн төсвийг нэмэх хэрэгтэй. Улсын төсөв дээр бол одоо яг энэ хүрээнд хаана гэдэг нь бол тодорхойгүй л байгаад байна л даа байршил нь.

Б.Заяабал: Энэ хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу тухайн санал нь хуулиар тогтоосон журмыг зөрчиж байгаа тул санал хураалт явуулахыг хориглоно оо гэсний дагуу ажлын хэсгийн гаргасан. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.2 дахь заасны дагуу уг санал нь шаардлага хангахгүй байгаа учраас санал хураалт явуулах боломжгүй юм байна аа.

Дараагийн санал руугаа оръё 22 дахь санал.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн дутагдлыг бууруулах” гэсэн төсөл, арга хэмжээний, зорилтот түвшин “1100” гэснийг “0” нэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэснийг “50,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “-” гэснийг “20,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв гэснийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Галбадрах. Галбадрах гишүүний микрофоныг өгье. Саналтай холбоотой.

Ж.Галбадрах: Энэ бол багшийн дутагдлыг бууруулах гэгчхээд ерөөсөө мөнгө тавиагүй байгаа. Бид нар өнөөдөр 2700 багш дутагдалтай байгааг 1100 багш болгоно гэж заасан мөртөө зорилтот түвшинд тавиад 1 төгрөгийн ч төсөв тавиагүй байгаад байгаа учраас энэ дээр бид нар багшаа хөгжүүлэхэд би Эдийн засгийн яаманд бол үндэслэлүүдийг нь бол бичиж бичгээр бол өгч байсан. Ийм учраас энэ саналыг дэмжээд энэ жилдээ бол 20 тэрбум төгрөгийн тэгэхдээ зөвхөн улсын төсөв биш гадаад дотоодын хөрөнгө оруулалт гэснээр орж ирж байгаа. Энийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна аа.

Б.Заяабал: Хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг нээе. Эдийн засаг хөгжлийн яам.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг хөгжлийн яам Мөнгөнсүх нэмэлт мэдээлэл өгье өө. Төслийг боловсруулах хугацаанд Галбадрах гишүүнтэй бид бүхэн нэлээн хамтарч ажиллаж мэдээллүүдийг бол солилцож ажилласан. Яг саналын томъёоллын тухайд бол улсын төсөв гэснийг гадаад дотоодын хөрөнгө оруулалт гэж тусгасан байгаа. Тэгээд энэ бол одоо хэрвээ багшийн урамшуулал юм уу цалин нэмэлт одоо ийм хэлбэрээр зохион байгуулагдахаар бол гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжгүй. Томъёоллын хувьд бол боломжгүй гэж үзэж байгаа.

Б.Заяабал: Галаа гишүүнд нэмэлт тайлбар хийх эрх олгоё. Галбадрах гишүүний микрофоныг нээе.

Ж.Галбадрах: Би яагаад гадаад, дотоод ингээд нэмэхэд одоо бид нар чинь хром букийн үйлдвэр барина, компьютер нэмж авна гээд ингээд гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар гээд зөндөө орсон байна. Багшийн маш их дутагдалд орчхоод байхад нэг ч төгрөгийн төсөв тавиагүй байгаа шүү. Тэгэхээр энэ дээр 20 тэрбум төгрөг энэ жилдээ, 3 жилдээ нэг 50 тэрбум төгрөг тавиад байгаа үндэслэлийг нь бол бичиж өгсөн байсан. Тэгээд улсын төсөв гэсэн байсан бол болох байсан юм уу? Зөвхөн улсын төсөв гэсэн бол болох байсан уу? Би энэ бас энэ юуны дагуу ажлын хэсгээс бас ингээд боловсруулсан саналын төсөл байгаа юм байна. Энийг бас дахиж найруулсан саналын төслийг уншиж өгье өө.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтад бодлогын үндэслэл “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн дутагдлыг бууруулах” гэсэн төсөл, арга хэмжээний, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэснийг “50,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт гэснийг “20,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Галбадрах гэсэн ийм шинэ томъёоллоор бас томъёолсон байна. Үүнтэй холбоотой ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Б.Мөнгөнсүх: Тийм. Хамгийн гол нь нөгөө нэг хэрэгжүүлэх одоо арга зам томьёолол дээр бид бүхэн жаахан буруу тусгагдсан гэж ингэж үзсэн.

Б.Заяабал: 4 номер микрофон. Ажлын хэсэг тайлбар өгөөдөх дөө.

Б.Мөнгөнсүх: Ажлын хэсэг дээр яг энэ тайлбарыг бас хэлсэн байгаа. Хамгийн гол нь хэрэгжүүлэх арга зам нь хэрвээ одоо нэмэлт багшид ямарваа нэгэн байдлаар одоо урамшуулал гэдэг юм уу, нэмэлт цалин гэдэг юм уу ийм зүйл өгөх тохиолдолд бол гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хийх боломжтой эсэх нь бол тодорхойгүй байна.

Дээрээс нь бол зорилтот түвшин 1100 гэснийг 0 гэж томьёолсон нь бол бас тодорхойгүй байна аа.

Б.Заяабал: Ингээд 22 дугаар санал. Ажлын хэсгийн гаргасан тайлбарын дагуу хуралдааны дэгийн тухай хуулийн 13.2-ын дагуу нийцээгүй учраас санал хураалт явуулах боломжгүй юм байна аа.

23.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1, 2.1.9” гэж, Төсөл, арга хэмжээ “Залуу зохион бүтээгчдийн ордон шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Барилга” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,110.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,110.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү.

Баатархүү гишүүн саналтайгаа холбоотой нэмэлт тайлбар байгаа юу? Ажлын хэсэг 3 дугаар микрофон. Эдийн засаг хөгжлийн яам.

С.Даваасүрэн: Тэгэхээр ажлын хэсэг дээр бол эхний 12 санал бол дэмжигдээд тэгээд үлдсэн 13 дахь саналаас эхлээд ажлын хэсэг дээр дэмжигдээгүй саналууд бол явж байгаа гэдгийг энд нэмэлт тайлбар болгож хэлье ээ.

Б.Заяабал: Тэрийг мэдэж байгаа. Тэгээд л ажлын хэсэг хамгийн гол нь энэ хууль тогтоомжид нийцэж байгаа юу гэдэг дээр л нэмэлт тайлбар байгаа бол гараа өргөөрэй гэсэн шүү дээ. Ингээд 23 дахь саналын дагуу санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.3.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.13”, “МУХТЖҮЧ-1.1.3.3”, “ЗГҮАХ-2.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын Нийслэлийн дүүргүүдэд барих нэг маягийн зураг төсөлтэй байгууламж бэлтгэл ажлыг хангах” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын явц” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагчид “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Соёл, спорт аялал

жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Санал гаргасан гишүүн байхгүй байна. Уг саналтай холбоотой ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Эдийн засаг, хөгжлийн яам.

Б.Мөнгөнсүх: Энэ санал ТЭЗҮ зураг төсөв нь тодорхойгүй байгаа.

Б.Заяабал: Санхүүжилтийн хувь нь бас.

24 дүгээр санал сая ажлын хэсгийн гаргасан нэмэлт тайлбарын дагуу аваад үзэхэд одоо хууль тогтоомжид нийцээгүй байгаа тул уг 24 дэх саналаар санал хураах боломжгүй юм байна аа.

25.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “1.2.1.6.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрээр асрах, сувилах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.7, ЗГҮАХ-2.3.4, 2.3.2.2, 2.3.2.8” гэж, Төсөл, арга хэмжээ “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрээр асрах, сувилах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Гэрээр асрах үйлчилгээ авч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “5000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “20,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “20,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж, Хамтран хариуцагч “Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

Эрдэнэбат гишүүн саналтайгаа холбоотой нэмэлт тайлбар.

С.Эрдэнэбат: Удахгүй. Энэ ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй гэрээр асрах үйлчилгээ гээд 7 тэрбум төгрөг энэ жил тавигдсан юм байна лээ. Тэгээд энэ жил байгууллагуудынхаа чадавхыг бий болгоод маш их хэрэгцээтэй үйлчилгээ байна. Ирэх жил бол одоо нэмэх шаардлагатай гээд яамдтай нь бол одоо зөвшилцсөн ярьсан. Төсвийг нь жоохон нэмээд ингээд тавьж байгаа асуудал байж байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Эдийн засаг, хөгжлийн яам.

Б.Мөнгөнсүх: Өргөн барьсан төлөвлөгөөний төслийн 1.2.1.6.1-д анхан шатны сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх ахмад настны үйлчилгээний чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, эрүүл насжилтын аяныг хэрэгжүүлэх зэргээр ингээд арга хэмжээг бол тусгасан. Тэгэхээр ахмад настны тусламж үйлчилгээтэй холбоотой энэ санал нь бол 1 дүгээрт давхардаж байгаа гэж ингэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь бол санхүүжүүлэх төсвийн боломж байхгүй гэж үзэж байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагч Лувсанжамц гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Хэдүүлээ нэг зарчим ярьсан даа. Ингээд гишүүд санал гаргахлаар төсвийн орон зай байхгүй гэдэг зүйл чинь болохгүй шүү дээ. Төсөв хэлэлцээгүй төсөв хэлэлцээгүй байгаа шүү дээ. Тэгээд юуны төлөө Их Хурлын

тогтоол дээрээ бид нар урд талд нь тэргүүн ээлжид хэрэгжүүлэхээр эрэмбэлнэ, үр ашгийн нөлөөг нь хэмжилтийг нь гаргана энэ тэр гэж ярьж байгаад одоо энэ хөгжлийн төлөвлөгөөнд туссан зүйлүүдийгээ бид нар дахиад эрэмбэлэх ёстой. Тэгээд тогтоолын төсөл дээр нь тэр агуулгыг тусгаж байгаа. Тэгэхээр ингээд орон зай байхгүй, орон зай байхгүй гэж гишүүдийн гаргасан саналыг ингээд татаад байх юм бол тэгвэл Их Хурлаар яах юм. Одоо больё. Засгийн газар нь ингээд өөрсдөө сайхан ажлаа хийгээд яв. Юун төлөө Их Хурлын тогтоолын төсөл дээр хамгийн урд байгаа 3 заалтыг оруулж байгаа билээ? Тийм тайлбар хэлж болохгүй гэж хэлээд байгаа шүү дээ.

Б.Заяабал: Энэ санал. 25 дугаар санал хууль тогтоомжид бол зөрчсөн юм байхгүй юм байна. Саяын тайлбар бас ажлын хэсгээс бас гишүүдийн гаргасан саналыг бас хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Хууль тогтоомжид нийцсэн санал байгаа учраас уг санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ

26.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтад “Урьдчилан сэргийлэх эрт, илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1, 2.3.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрт илрүүлгийн арга хэмжээний хүрээнд бүрдсэн хүн амын эрүүл мэндийн өгөгдөлд эпидемиологийн, өртөг-үр ашгийн шинжилгээ хийж бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,750.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,750.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв /батлагдсан урсгал зардал” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа.

Ганмаа гишүүн гаргасан саналтайгаа холбоотой тайлбар хэлнэ. Ганмаа гишүүний микрофоныг нээе.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Бид нар энэ 3 санал би гаргасан байгаа. Энэ 3 саналыг ер нь цөмөөрөө одоо яг эрүүл мэндийн одоо салбарын 2027 онд салбарын бодлого болгоно гэж зарлаад тэгээд яг үнэндээ бодлогын асуудлууд энд огт орж ирээгүй юм байгаа юм. Тэгэхээр энэ хамгийн бага мөнгөөр хамгийн үр ашигтай байдлаар эрүүл мэндийн бодлогыг одоо энэ нэг жилийн хугацаанд засаж янзлаад тэгээд дараа дараагийн одоо бүүр маш их зардлыг хэмнэх боломжтой гээд та хэд энийг зардал гэж битгий хараарай. Яг системийн шинэчлэлийн хөрөнгө оруулалт гэдэг талаас нь хараарай гэж гуйж байна. Урт хугацаандаа ер нь энэ бол зардал бууруулах премент буюу урьдчилан сэргийлэх энэ арга болно. Хэд хэдэн байдлаар оруулж байгаа. Нэг нь яг одоо эмнэлгийн тусламж үйлчилгээний модель буюу одоо бид нар 2021 онд эрүүл мэндийн санхүүжилтийн моделийг хийгээд угсраад явж байгаа ч гэсэн яг тэрүүндээ тааруулж эмнэлгийн тус тусламж үйлчилгээгээ тааруулж чадаагүйтэй холбоотой 1 дүгээрт.

Хоёрдугаарт ирсэн жил болгон сайд болгон өөр өөрийнхөө бодлогыг хийж байсан ч гэсэн эрүүл мэндийн тогтолцооны өөрийн бүрэлдэхүүн 6 хэсэгт нь хамтаар

нь уялдаатай засваруудыг огт хийж байгаагүйтэй холбоотой салангид эсвэл зөвхөн мөнгө нэмээд л яваад байдаг, эсвэл гэнэтийн одоо ЭМДҮЗ-ийн тогтоолоор шийдвэрүүдээ гаргаад яваад байдагтай холбоотойгоор энэ 6 бүрэлдэхүүн хэсэг хамтдаа нийлж байж энд нь ажилладаг юм. Үр ашигтай болдог юм. Бодлого нь ойлгомжтой болдог юм. Энэ нь шалгуур үзүүлэлтээр тодорхойлдог юм гэдэг. Энэ ойлголтыг яг 5 жилийн төлөвлөгөөнд манай баг суугаад бүтэн боловсруулаад энийг бол батлуулчихсан байгаа. Одоо энийг энэ загвараа 2027 оныхоо жилдээ эхний байдлаар энэ 3-ыг нь хийе л гэсэн ийм санал юм байгаа юм. Эхнийх нь тэр. 2 дахь нь тэр үр ашигтай гээд яг сая намайг орж ирэхэд уншиж байсан энэ асуудал маань бид нар одоо маш гоё нэртэй олон хөтөлбөр хэрэгжүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн эрүүл зүрх, эрүүл шүд, эрүүл монгол элэг, бүтэн Монгол, умайн хавдаргүй Монгол. Одоо тэгээд сүүлдээ 90, 60, 90 энэ тэр гээд эдгээр тоонуудыг бид нар хэзээ ч бөөнд нь нэгтгэж аваад эрэмбэлээд одоо орчин нь ямар байгаа юм, дараа нь хэд болох юм тэр нь хамгийн сайн үр дүнд орох нь аль вэ гэдгээ үзэхгүй бол зөвхөн элэг бүтэн дээр гэхэд л одоо гадаад дотоодын судлаачдын бичсэн юмнууд зөндөө байгаа. Одоо Монгол Улсын эмч эмнэлгийн ажилчдын хэдэн жилдээ авдаг цалинг нэг хөтөлбөрт өгчихсөн мөртөө үр дүн нь тодорхой биш гэдэг юмнууд явагдаад байгаа байхгүй юу. Энийг яг олон улсын түвшинд ч Монголдоо ч адилхан ижил одоо нэр томъёолол дээр нь аваачаад эрэмбэлээд тогтоох.

Гурав дахь нь тэр уламжлалт гэдэг бол угаасаа одоо энэ нөгөө Ерөнхийлөгчийн оруулж ирсэн энэ шинэчилсэн тогтоолын хүрээнд бид нар хийх ёстой зайлшгүй загвар. Тэгэхдээ энийг бид нар яг одоо орчин үеийнхээ анагаах ухаантай нэгтгэж нэгдмэл байдлаар явахгүй бол тус тусдаа салангидаар яваад байх юм бол бас л ерөөсөө хүндээ хүмүүст хүрэхгүй.

Дээрээс нь Монголын яг соёл заншил уламжлал тэр Америкийн Веллнес центр гэдэг шиг эдгээр байдлаар явуулах юм бол олон улсад хүргэхэд бас их амар болох юм. Баярлалаа.

Б.Заяабал: 26 дугаар саналтай холбоотой хуулийн шаардлага хангаж байгаа эсэх дээр Эдийн Засаг, хөгжлийн яам 3 дугаар микрофон.

С.Даваасүрэн: Энэ дээр бол яах вэ төсвийн хүрээний хувьд бол яах вэ эрт илрүүлгийн ямарваа нэгэн үйл ажиллагаа тусгагдаагүй учраас тодорхой нэмж хэлэх санал алга аа.

Б.Заяабал: 26 дугаар санал дээр санал хураалт явуулъя.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

27.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтад Бодлогын үндэслэл “МУХТЖҮЧ-1.2.1.11, ЗГҮАХ-2.3.2.5,” гэж, Төсөл, арга хэмжээ “Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан, аялал жуулчлалын чиглэлтэй интеграцчилсан үйлчилгээний хөгжлийн загварыг нэвтрүүлэх.” гэж, Шалгуур үзүүлэлт “интеграцчилсан үйлчилгээний жишиг загвар” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Үр дүнгийн үзүүлэлт Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “4,600.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв /батлагдсан урсгал зардал” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж, Хамтран хариуцагч “Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганмаа. Ганмаа гишүүн сая тайлбараа хэлсэн. Уг санал хууль хуулийн шаардлага хангаж байгаа эсэх талаар Эдийн засаг, хөгжлийн яам 3 дугаар микрофон ажлын хэсэг.

С.Даваасүрэн: Энэ дээр нэг л асуудал байгаа. Юу вэ гэхээр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.6.10.2 дахь заалт дээр санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байх шаардлагатай. Мөн хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилсан тооцсон гэдэг. Тэгээд хариуцах эзэнтэй, ТЭЗҮ зураг төсөв батлагдсан гэсэн. Энэ шаардлага дээр болохоор одоо тодорхойгүй зүйл байна л гэж харж байгаа.

Б.Заяабал: Ингээд 27 дугаар сандал дээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

39.1 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй

28.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалтын “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах эмнэлэг, эрүүл мэндийн барилгуудыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах” гэснийг “Аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв, байгуулах” гэж, Зорилтот түвшин “100” гэснийг “20” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа.

Ганмаа гишүүн саналтайгаа холбоотой тайлбар байна уу? Уг санал хууль шаардлага хангаж байгаа юу? Ажлын хэсэг 3 номерын микрофон. 28 дахь санал. 4 номер ажлын хэсэг.

Б.Мөнгөнсүх: Энэ төлөвлөгөөний төсөлд байгаа санал бөгөөд техникийн засвар оруулж байгаа санал юм.

Б.Заяабал: Ойлголоо. 28 дахь асуудал дээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

39.1 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын Байнгын хорооны гишүүдийг, Улсын Их Хурлын гишүүдийг бас хуралдаандаа ирэхийг урья.

Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 10.11 дээр тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүйгээр хуралдааныг орхиж гарсан эсвэл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэсэн ийм бас хуралдааны дэгийн тухай хууль байгаа. Ингээд гишүүдийг бас хүрэлцэн ирэхийг урьж байна. Гишүүдийн ирц бас хангалтгүй буурсан байгаа учраас хуралдааныг 15 минут түр завсарлуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны хурлын завсарлагааны цаг дууссан тул хурлаа эхэлье. Улсын Их Хурлын эрхэм гишүүд хуралдааны танхимд хүрэлцэн ирнэ үү.

Эдийн засгийн байнгын хорооны хурлаа үргэлжлүүлье.

29 дүгээр санал дээр явж байсан. Ингээд 29 дүгээр саналыг уншиж санал хураалтаа явуулъя

29.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.11, 2.2.12, МУХТЖҮЧ-1.2.1.3, ЗГҮАХ-2.3.2.1, 2.3.2.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг хүн төвтэй, нэгдмэл загварт шилжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Үр дүнгийн үзүүлэлтэд суурь он “2025” гэж, суурь түвшин “0” гэж, зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,430.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,430.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Ганмаа гишүүн тайлбар хэлье.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

30.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.14, 2.2.11, 2.2.27, МУХТЖҮЧ-1.2.1.3, ЗГҮАХ-2.3.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум 20 ортой Эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,365.29” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “9,365.29” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр. Батбаяр гишүүн байхгүй байна.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

31.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.6.10, МУХТЖҮЧ-1.2.1.5, ЗГҮАХ-2.3.2.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын төвийн тоног төхөөрөмж” гэж, Шалгуур үзүүлэлт “-” гэж, Хэмжих нэгж “-” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “5,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “5,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Ажлын хэсгээс хууль, тогтоол зөрчигдсөнтэй холбоотой гар өргөж санал хэл гэсэн. Гар өргөөгүй учраас санал хураалт явуулъя.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

Горимын санал Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Сая техник ажиллаагүй тул саяын саналыг дахин хураалгаж өгөх горимын саналыг гаргаж байна, хүчингүй болгож.

Б.Заяабал: Батсүмбэрэл гишүүний гаргасан горимын саналын дагуу сая хураасан саналыг хүчингүй болгохоор санал хураалтыг явуулъя аа.

56.5 хувийн саналаар уг горимын санал дэмжигдсэн учраас өмнөх 31 дүгээр саналыг санал хураалтыг дахин явуулъя аа.

Санал хураалт 56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

32.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.6.10, МУХТЖҮЧ-1.2.1.5, ЗГҮАХ-2.3.2.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Дүүргийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгад шаардлагатай тоног төхөөрөмж /мэдээлэл технологи, эмнэлгийн тоног төхөөрөмж, Хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулах, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлт “ - ” гэж, Хэмжих нэгж “ - ” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “20,218.8” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “10,218.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

33.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.3.3, МУХТЖҮЧ-2.1.4.1, ЗГҮАХ-2.1.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан өрх” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “1259” Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү.

Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

34.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.1-1.5, МУХТЖҮЧ-3.1.2.1, ЗГҮАХ-3.3.6.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум “Угсаатны зүйн музей”-н барилга” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “35,391.65” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “12,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь.

Санал хураалт явуулъя.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

35.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.2.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, МУХТЖҮЧ-4.2.4.2, ЗГҮАХ-2.1.1.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Ахмадын хөгжлийн төвийн барилгын өргөтгөл /Сүхбаатар, Баруун-Урт сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,200.4” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,100.2” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд.

Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

36.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.2.1, 2.3, 2.3.1, 2.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Гэр бүлийн боловсрол, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үндэсний нөлөөллийн хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Нөлөөллийн ажилд хамрагдсан хүний тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв, бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Соёлын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа.

Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

37.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.4.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.2.1, 2.3, 2.3.1, 2.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Олон хүүхэдтэй болон залуу гэр бүлийг дэмжих бодлогын арга хэмжээг боловсронгуй болгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дэмжлэгт хамрагдсан олон хүүхэдтэй болон залуу гэр бүлийн хувь” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “20” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам, Монгол банк” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа.

Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

38.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.4.4 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.2.1, 2.3, 2.3.1, 2.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Эцэг, эхийн боловсрол, хүүхэд хамгааллын сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Сургалтад хамрагдсан эцэг, эхийн тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “700.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, Хамтран хариуцагч “Боловсролын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа.

Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

39.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.3.3, МУХТЖҮЧ-4.4.1.1, 4.2.4.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Түр хамгаалах байр төрөлжүүлэн зохион байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Төрөлжүүлсэн хамгаалах байр” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “21” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “20,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “20,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч” “Аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа.

Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

40.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.3.3, МУХТЖҮЧ-4.4.1.1, 4.2.4.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвсгөл аймаг, Бүрэнтогтох суманд хүүхдийн хөгжил, амралт-сургалтын “Найрамдал-2” цогцолбор байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Баригдсан хүүхдийн зуслангийн хүчин чадал” гэж, Хэмжих нэгж “Ор” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “5,443.1” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,443.1” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Даваасүрэн: Яамнаас асуусан тийм. Тэгээд яаман дээр бол зураг төсөл нь яг байхгүй. Бид нар тодруулсан яаман дээр бол нөгөө нэг яг зураг төсөл нь эцэслэгдэж ирээгүй байна гэсэн тийм мэдээлэл өгсөн байгаа.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга үүрийнтуяа гишүүн. Санал гаргасан гишүүний микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Одоогоос 2 сарын өмнө би яам руу, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Сангийн яаманд албан бичгээр зураг төсвийг нь

хавсаргаад албан бичгээр явуулсан байгаа. Зураг төсөв нь гарчихсан, магадлал хийгдчихсэн. Бүх бичиг баримт нь бүрэн байгаа.

Б.Заяабал: Ингээд хууль тогтоомжид нийцсэн гэж үзэж санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ

41.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.2.4 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “4.2.4.7.Цагдаагийн байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлнэ” гэж, Бодлогын үндэслэл “АХ-7.4.13, МУХТЖҮЧ-4.2.5.4, ЗГҮАХ-4.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Заамар сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,975.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,975.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

42.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.17, 8.3.35, МУХТЖҮЧ-4.3.1.3, ЗГҮАХ-3.3.4.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах иж бүрэн судалгаа хийдэг хүнсний хүрээлэнгийн лаборатори шинээр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “44,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “44,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Гадаадын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

43.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.3”, “МУХТЖҮЧ 4.4.1”, “ЗГҮАХ 2.4.3.3” гэж, Төсөл, арга хэмжээ “1000 айлын орон сууцны хороолол”-ын гадна ус хангамж, ариутгах татуурга, гадна холбоо /Дорнод, Хэрлэн сум/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,790.6” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,895.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” Хамтран хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, МУХТЖҮЧ-4.4.1.3, ЗГҮАХ-2.4.1.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Бүх сумдад Төрийн албан хаагчдад зориулсан 10-15 айлын орон сууц барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ашиглалтад орсон орон сууцны тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “400” гэж, Нийт санхүүжилтийн сая.төг “6,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон өгье. Эдийн засаг, хөгжлийн яам.

С.Даваасүрэн: Тэгэхээр тогтоолын төслийн энэ 2 дугаар хавсралтаар батлагдах Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийн 4.4.1.3.3-д төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр нэг ба 2 дугаар үе шатыг аймаг сумдад нөгөө хэрэгжүүлэх гэдэг байдлаар тусгагдчихсан байгаа. Энэ асуудал бол.

Б.Заяабал: Товч тодруулга Эрдэнэбат гишүүнд өгье.

С.Эрдэнэбат: Энэ юу шүү. Та хэдийн суманд одоо энэ хаана ямар суманд байр бариад байгаа юм? Би энийг юу гэж оруулсан бэ гэхээр өөрсдөө зах хязгаар нутагт багш нар, эмч нар, төрийн албан хаагч нар очихгүй учраас эхний ээлжид одоо өөрийнх нь орон нутагт тохирсон ийм байдлаар хэрэгжүүл гэж байгаа юм. Тэр нийт төрийн албан хаагчийн чинь асуудал бол биш шүү. Яг ний нуугүй хэлэхэд төрийн алба дээр сум дээр очоод та нар орон сууц барья гэсэн нэг ширхэг одоо барилга байгаа юм уу, үгүй юм уу би л лав олж хараагүй.

Б.Заяабал: Ингээд шаардлага хангаж байна гэж санал гаргасан гишүүн санал гаргасан тул 44 дүгээр саналаар санал хураалт явуулъя.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

45.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь заалтад “4.4.4.3.6.Хүннү хотын ногоон нуур, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Эдийн засаг, хөгжлийн яам.

С.Даваасүрэн: Тэгэхээр яг энэ саналын хувьд бол ТЭЗҮ, зураг төсөв нь бол байхгүй юм байна.

Дээрээс нь Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудлын нислэгийн хамгаалалтын бүсийн дэглэмийн дагуу нөгөө нуур цөөрөм байгуулах боломжгүй гэсэн ийм 2 үндэслэл байгаа юм байна аа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн тайлбарын дагуу хуулийн шаардлага хангаагүй гэж үзэж санал хураахгүйгээр шийдвэрлэлээ.

46.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, МУХТЖҮЧ-4.4.1.3, ЗГҮАХ-1.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн бие даасан дулааны эх үүсгэврийн барилга байгууламж /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 10 хороо/” гэж, Шалгуур үзүүлэлт “Дэд бүтцийн ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “-” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,386.5” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “9,386.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Санал хураалт. 47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй ээ.

Дараагийн санал руу явахаас өмнө бас зарим гишүүд сая бас гараад явчихлаа. Энэтэй холбоотой бас Дэгийн тухай хуулийн 10.1-ийг уншиж танилцуулъя. Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүйгээр хуралдааныг орхиж гарсан эсхүл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэсэн ийм дэгийн тухай хуулийн заалт байна. Бас Дэгийн тухай хуулийг уншиж танилцуулъя аа.

Ингээд 47 дугаар санал руугаа оръё оо.

47.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, МУХТЖҮЧ-4.4.1.3, ЗГҮАХ-1.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 10 дугаар хороо, Далан давхрын урд талд/” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “-” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “11,010.7” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “11,010.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

48.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.3.14, 3.23, МУХТЖҮЧ-4.3.2, ЗГҮАХ-4.4.4.4, 4.4.4.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Уул аймаг Шарын гол сум гал түймэр унтраах аврах 55-р ангийн өргөтгөлийн барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж,

Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “822” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “822” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Шадар сайдын Ажлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/” гэж нэмэх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.4.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.3, МУХТЖҮЧ-4.4.4.1, ЗГҮАХ-1.1.4.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Баянчандмань сумын Дархан-Эрдэнэтийн зам дээр гүүрэн зам тавих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, “Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,100.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.14”, “МУХТЖҮЧ-5.1.1.1”, “ЗГҮАХ-3.3.1.13” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, Шалгуур үзүүлэлт “Нүүрснээс үйлдвэрлэх шатахуун, хийн түлшний дотоодын хэрэглээнд эзлэх хувь хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “75,645.70” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,564.57” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагчид “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Даваасүрэн: Тэгэхээр энэ төслийн хувьд бол төсөв зураг нь ингээд гарсан хэдий боловч нөгөө хуучирсан сүүлийн 2 жилийн хугацаанд хийгдсэн магадланаар баталгаажсан төсөвтэй байх ёстой гэдэг шаардлагыг бас хангаагүй.

Дээр нь улсын улсын төсвөөр үйлдвэр барих ийм боломжгүй гэсэн ийм 2 шаардлагыг бол хангахгүй байгаа.

Б.Заяабал: Магадлан бол яг хуулийн шаардлагад бас тооцогдохгүй байх аа. Энэ улсын ТЭЗҮ нь хийгдчихсэн байгаа бол Хөгжлийн тухай хуульд нийцэж байгаа учраас санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

30.4 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

51.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтын “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Хүрэн нүүрснээс хагас кокс эрчим хүч үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээг бүхэлд нь хасах. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Санал хураалт.

34.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

52.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.14 МУХТЖҮЧ-5.1.1.1, ЗГҮАХ-1.3.4.1” гэж, Төсөл, арга хэмжээ “5.1.1.1.8 Улаанбаатар хот, зарим аймгийн төвүүдийн ахуйн хэрэглэгчдийг хагас коксожсон байгаль орчны бохирдлыг бууруулах түлшээр хангах нүүрс пиролизын үйлдвэрийг байгуулна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “240 тэрбум” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир.

Санал хураалт.

34.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

53.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.20, МУХТЖҮЧ-5.1.2.1, ЗГҮАХ-3.3.4.31” гэж, Төсөл, арга хэмжээ “Малчдын оролцоонд суурилсан, мал бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бүхий малын түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөөгийн хүн амын амьжиргааг дэмжих зорилгоор “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” төслийн техник эдийн засгийн үндэслэл, иж бүрэн зураг төсөл боловсруулна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Баримт бичиг боловсруулах” гэж, Хэмжих нэгж “Техник, эдийн засгийн үндэслэл” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “3,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар.

Ажлын хэсэг Эдийн засаг, хөгжлийн яам 3 номерын микрофон өгье.

С.Даваасүрэнд: Энэ тухайн саналын хувьд бол ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зардал улсын хөгжлийн төлөвлөгөөнд бол хуулийн дагуу тусгагдахгүй байгаа.

Б.Заяабал: Хууль тогтоомжид нийцээгүй учраас уг санал хураалтыг хураалгахгүйгээр шийдлээ.

54.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.4.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Жаргалант-Шинэ Идэр-Мөрөн авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “334,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “334,000.0”

гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж, Хамтран хариуцагч “Хөвсгөл аймаг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Бат-Эрдэнэ гишүүн саналаа тайлбарлая. Санал гаргагчид микрофон өгье. Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье. Та хуруугаа уншуулсан уу?

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Манай Хөвсгөлийн Жаргалант, Шинэ-Идэр, Мөрөн, Босоо тэнхлэгийн авто зам. 22 жил яригдаж байгаа юм. Тэгээд одоо харахаар гишүүдийн тоо, зааланд байгаа гишүүдийн тоо хүрэхгүй унахаар байна л даа. Дэмжихээр байсан ч гишүүдийнх нь тоо хүрэхгүй байна. 68 дээр Мөнхбаатар гишүүн бас энэ саналыг гаргачихсан байгаа юм. Одоо нэг санал одоо адилхан гэсэн үг. Тэгэхээр би харин тийм санал нь одоо хаашдаа хүрэхээ больчихож байгаа юм чинь Мөнхбаатар гишүүнийхийг үлдээгээд 68 хүртэл одоо гишүүд нь бүрдээсэй л гэж залбирахаас. Тэгээд өөрийнхөө саналыг татаад 68 дээр нэгтгэж санал хураалгахаар. Мөнхбаатар гишүүнийхээр санал хураалгахаар болгоё.

Б.Заяабал: Эцсийн хэлэлцүүлэг дээр саналаа татах санал байхгүй учраас хуралдаан даргалагчийн хувьд энэ саналыг санал хураахаас татгалзаад дараагийн төсөл рүү орёё.

55.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.4.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвөгч гүүр” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “3,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж, Хамтран хариуцагч “Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сум” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Санал гаргагч микрофоныг өгье. Саналтай холбоотой тайлбар хийе.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Уул нь одоо гишүүд маань байж байгаад ядаж үнэлэмжээрээ өөрсдийнхөө бодлоороо өгчихвөл сайн байдаг. Тэгээд зааланд байгаа гишүүд нь бүгдээрээ санал өгөөд ч унах гээд байна шүү дээ. Завсарлаж болох юм уу? Хуралдаан даргалагчаас 10 минутын нөгөө хууль өргөн барих гээд бас 5 гишүүн явчихсан байгаа юм байна. Түр 10 минут хүлээлгэх боломж байгаа юу.

Саналаа тайлбарлаж хэлэхэд бол манай Хөвсгөл аймаг ялангуяа энэ миний гаргасан саналтай холбоотой асуудал бол гүүр. Хөвсгөл аймгийн хувьд бол уул уснаас бүрдсэн.

Дээрээс нь гол гүүр нь урсчихсан. Одоо энэ гүүр байхгүйгээс улбаатай 100 гаруй километр газар тойрч бүх нийгмийн үйлчилгээ очиж байгаа. Энэ гүүр байвал дөчин тавхан километр болж байгаа юм. Цаг алдахгүй нийгмийн хөгжил хоцрохгүй. Аливаа одоо эрүүл мэнд болон бусад хөгжлүүд цаг хугацаандаа хүрэх ийм бүрэн дүүрэн боломжтой байгаа юм аа. Тэгээд одоо тэгээд жоохон харамсалтай байна. Эдийн засгийн байнгын хорооны гишүүд маань уул нь бүрдээд санал өгчхөөсэй л гэж би хүсэж байна. Энд бүтэн 3 сум дамнасан ийм том асуудал учраас тэгээд ялангуяа энэ нийгмийн хөгжилтэй холбоотой асуудал учраас энийг дэмжээд өгөөсэй

гэж одоо Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээсээ аминчлан хүсэж байгаа юм аа.

Тэгэхээр одоо түр завсарлуулах боломж байгаа болов уу дарга аа?

Б.Заяабал: Ажлын албанаас Их Хурлын манай Байнгын хорооны 3 гишүүн яг одоо бас Их Хурлын дарга дээр хуулийн төслийг өргөн барьж байгаа юм байна. Энэтэй холбоотой 15 минутын завсарлага өгье өө. Ингээд 15 минутын дараа эргэж хуралдъя.

Завсарлагааны хугацаа дууссан учраас Эдийн засгийн байнгын хорооныхоо хуралдааныг үргэлжлүүлье ээ.

Байнгын хорооны гишүүд танхимдаа ирэхийг урья.

Байнгын хорооны хурал завсарлаад эхэлсэн байгаа. Улс эх орны хөгжлийн төлөвлөгөө чухал асуудал яригдаж байгаа учраас ирцэд орсон гишүүд маань хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна аа. Чинбаатарын Анар гишүүн, Цэндийн Баатархүү гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Мэндбаярын Мандухай гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн нарыг байнгын хорооны хуралдаан ирэхийг урьж байна аа. 5 минут харъя тэгээд хуралдаанаа эхэлье.

Цэндийн Баатархүү гишүүн. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн нар хүрэлцэн ирлээ. Хуралдаанаа үргэлжлүүлье.

55 дугаар төслийг саналыг уншиж танилцуулсан байгаа. Энэтэй холбоотой 55 дугаар санал гаргасан Бат-Эрдэнэ гишүүн үг хэлсэн. Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 55, 56 дугаар санал дээр хамтран хариуцагч гээд сумын нэр орсныг хасаж өгөөч үндсэн хариуцагчаар явна гэж хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Заяабал: Бат-Эрдэнэ гишүүний найруулгатай санал хураалт. Бат-Эрдэнэ гишүүний гаргасан найруулгатайгаар санал хураая.

55 дугаар санал.

Санал хураалт. Горимын санал Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Санал хураалтад сая төхөөрөмж ажилласангүй. Тэгээд энэ санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

Б.Заяабал: Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар саяын одоо санал хураалтыг хүчингүй болсонд тооцсон санал хураалт явуулъя.

52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд 55 дугаар саналыг дахиж унших уу? Би шаардлагагүй юу? 55 дугаар саналыг Бат-Эрдэнэ гишүүний гаргасан саналыг дахин санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

56.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.4.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ /Булган аймаг, Сэлэнгэ сум- Орхон аймаг, Баян-Өндөр сум/ “40 км хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “57,776.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “57,776.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Эдийн засаг, хөгжлийн яам. Энэ санал дээр нөгөө 40 км авто хатуу хучилттай авто зам гэж байгаа. Тэгэхээр энэ төсөл нь илүү тодорхой биш өөрөөр хэлбэл хаанаас хаа хүрсэн зам бэ гэдэг нь тэгэхээр нэгэнт ийм тодорхой биш байгаа учраас ТЭЗҮ зургийг нь бас тухайлан шалгах боломж бас байхгүй байгаад байгаа юм.

Б.Заяабал: Хууль тогтоомжид нийцээгүй байвал бас санал хураалтыг зохион байгуулахгүй, санал хураалт явуулахгүй байх ийм дэгтэй байгаа. Ингээд хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ гишүүнд үг өгье. Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Үгүй сайн ойлгосонгүй. Энэ чинь ТЭЗҮ нь очоод аягүй удаж байгаа. Булган аймгийн Сэлэнгэ сумаас Эрдэнэт хот руу явж байгаа зам 40км зам. Маш ойлгомжтой зураг төсөл ТЭЗҮ-тэй зам шүү дээ. Тэгээд сая би та бүхнээс бас 15 минут завсарлаж байх хугацаанд очиж тодруулсан шүү дээ. Та нар дээр яг бүх юм нь бүрэн байгаа юу яасан ийсэн гэсэн бүх юм асуудалгүй гэж сая хэлсэн шүү дээ надад.

Санал хураалт явуулчих.

Б.Заяабал: Гишүүн төсөл арга хэмжээнийхээ байршлыг тодорхой хэлээд өг.

Б.Бат-Эрдэнэ: Булган аймгийн Сэлэнгэ сумаас Орхон аймаг руу холбогдож байгаа зам. Орхон аймгийн Говил баг руу холбогдож байгаа зам гэсэн үг.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон. Эдийн засаг хөгжлийн яам.

С.Даваасүрэн: Тэгэхээрээ саналын томъёоллын хувьд бол дахиж өөрчлөх нь зүйтэй байх. Яг одоо байршлаа тодорхойлж. Тэгээд энэ саналын томъёолол дээр бол 40км хатуу хучилттай авто зам гэсэн томъёолол байгаа.

Б.Заяабал: Санал гаргасан гишүүний одоо найруулгын саналаар 56 дугаар саналыг санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

57.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.39, МУХТЖҮЧ-5.6.1.3, ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “5.6.1.3.3 Багануурын уурхайг түшиглэн 300МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “-” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “-”, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр хувийн хэвшил” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир.

Нэг номерын микрофон ажлын хэсэг.

Х.Бекболат: Эрчим хүчний яам. Багануурын ДЦС-ын хувьд бол 700мвт-ын концессын хүчин төгөлдөр гэрээтэй байгаа. Гэрээ цуцлагдаагүй тохиолдолд бол шинээр төсөл хөтөлбөр эрхлүүлэх боломжгүй. 300мвт-ын хувьд ТЭЗҮ, зураг төсөвгүй байгаа.

Б.Заяабал: ТЭЗҮ, зураг төсөл байхгүй, хуульд нийцээгүй гэсэн учраас санал хураалт явуулахаас татгалзаж байна.

58.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, МУХТЖҮЧ-5.6.1.1, ЗГҮАХ-1.1.2.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 15,19, 20-р хороо/” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “3,600.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Даваасүрэн: Тэгэхээр СБД-ийн 15, 16 дугаар хорооны хувьд энэ төсөл нэлээн чухал төсөл. Гэхдээ яг энэ 15, 16 дугаар хорооны хувьд бол зураг төсөл нь бол хийгдээгүй байна. Тэгэхээр ЭХЯ-ны бас ажлын хэсэг энэ дээр тайлбар хийнэ.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Б.Ерэн-Өлзий: Гэр хорооллын хүчдэлийн уналт энэ бол хийгдэх ёстой уул нь ажлууд байж байгаа.

Б.Заяабал: Уг саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал гишүүний микрофоныг өгье. Хуулийн шаардлага хангасан эсэх талаар тодорхой тайлбар өгнө үү?

О.Батнайрамдал: Харин тийм. Энэ 15, 19 гэгчихсэн байна. Энэ 19, 20 дугаар хороо шүү. Тэгээд зураг төсвийг нь би өөрийн биеэр 2 долоо хоногийн өмнө газар дээр нь очиж шалгасан байгаа. Яам мэдээллээ зөв өгнө шүү. Ийм чухал асуулт явж байхад худал хариулсан шүү. Би наадах дээр чинь та нар дээр албан албан тоот явуулна. Би яагаад гэвэл яг өөрийнхөө гараар очиж үзсэн. 19 дүгээр хороон дээр очиж би өөрөө харсан байхгүй юу. Зураг төсөв байгаа бүр батлагдчихсан. Улаанбаатар цахилгаан станцын одоо зураг төсөв батлагдчихсан байгаа. Та бүхэн дэмжиж өгнө үү. Тэгэхээр энийг редакцын засвар 15, 19, 20 дугаар хороо гэж нэмж өгнө үү гэж.

Б.Заяабал: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал гишүүний одоо найруулгаар уг санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

59.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.35”, “МУХТЖҮЧ 5.6.1.1”, “ЗГҮАХ 3.3.3.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Хавирга хилийн боомтын өргөтгөлийн цахилгаан хангамж Хавирга 35 Кв ЦДАШ, 35/10 кВ-ын 2/1600 кВА чадлын “Хавирга” дэд станц 35/10 кВ-ын “Хэрлэн” дэд станцын өргөтгөл /Дорнод/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,402.7” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “5,201.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

60.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.39”, “МУХТЖҮЧ-5.6.1.3”, “ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорноговь аймгийн Айраг сумын 8 МВт хүчин чадалтай дулааны зуух барих, шугам сүлжээ өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “8,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “8,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагчид “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон өгье.

С.Даваасүрэн: Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.2 дахь хэсэг дээр энэ зураг төсөл хийгдээгүй. Тэгээд нөгөө төлөвлөгөөний зураг төсөл ТЭЗҮ байхгүй зөвхөн хариуцах эзний тодорхойлолт гарсан байгаа.

Б.Заяабал: Уг төслийн шаардлага хангаагүй гэж ажлын хэсгээс дүгнэсэн учраас шаардлага хангаагүй учраас санал хураалт явуулахгүй ээ.

61.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-1.3.3.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 92.13 км авто зам барих /Орхон, Дархан-Уул, Төв/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “150,034.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “11,139.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Санал хураалт.

52.3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

62.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 87.9 км” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “45” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

63.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойр-Мандалговь-Арвайхээрийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “230.98 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “105.0 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

64.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Ховд-Улиастайг холбох хатуу хучилттай авто замын үргэлжлэл, Донойн хөндий-Сархайрхан-Дөргөн чиглэлийн 335.9 км хатуу хучилттай авто зам.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “8” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “375,000.0” гэж,

Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “30,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

65.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг - Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “-” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “60” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “137,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “82,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам. Саяын нөгөө 64 дээр бас хэлсэн. 64 дээр бол нөгөө эдийн засгийн одоо үндэслэл тооцоолол бүхий зураг нь бол одоогоор бэлэн болоогүй юм байна. 65 дээр бол энэ нөгөө нэг зургийн хувьд шинэчлэх шаардлагатай байгаа юм байна.

Б.Заяабал: Энэ 65 дугаар сандал чинь үргэлжилж байгаа зам юм биш үү? Зураг төсвийг нь шинэчилнэ гэж одоо юу яриад байна? Эхэлчихсэн замын зураг төсөв шинэчилнэ гэж юу яриад байгаа юм? Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Арцуурын боомтын зам бол нийтдээ 159км зам. 2025 онд эхлүүлсэн нь бол бид нар эхний 20-оос 30км эхлүүлсэн. Тэр нь бол шилжихээр явж байгаа. Тэгэхээр энэ саналын томъёолол болохлоор тэр ажлынх нь үлдэгдлийг нь одоо шинээр тусгаж явна гэсэн үг. Тэр тохиолдолд зураг төсвөө бол шинэчлэх шаардлагатай.

Төсвийн хуулийн 29 дээр бол сүүлийн 2 жилийн зураг төсөв магадлалтай байх хуулийн шаардлага байгаа. Тэгэхээр 2027 онд тусгагдах ажлууд. 2025, 2026 оны зураг төсөвтэй байх ёстой.

Б.Заяабал: Үргэлжилж байгаа замд тэгээд 2 ТЭЗҮ-ийн одоо зураг зайлшгүй шаардлагатай болдог юм уу? Энийгээ дахиад тодорхой хэлж өгөөч.

Ж.Дэлгэржаргал: Одоо яг хууль дээр бол Арц суурь боомтын замын нийтдээ энэ урт нь 159км зам. Тэрнийх нь эхний одоо бараг 40км-ийг нь эхлүүлчихсэн. Тэр нь ингээд үргэлжлээд шилжихээр явна гэсэн үг 2027 он дээр. Өөрөөр хэлбэл 40км-ийнх нь л төсөв нь явж байгаа гэсэн үг. Энэ саналын томъёолол бол 159-өөс 40 гэхээр чинь цаана нь 110км-ийнх нь төсвийг шинээр тавих гэж байна гэсэн үг. Тэгэхээр 1 зураг төсөв дээр ч гэсэн зам бол ингээд нэг салгаж шинэчилж болдог гэсэн үг. Үлдэгдэл одоо километр дээрээ хуулийн шаардлагаараа зураг төсвөө шинэчилнэ гэсэн үг.

Б.Заяабал: Би бас асуулт асууж болох юм байна. Ажлын хэсгээс би дахиад асууя.

Энэ чинь анхнаасаа зураг нь 159 км-ээр анхнаасаа зураг нь хийгдчихсэн байгаа. Тэрний та нар 40км-ийг нь таслаад ингээд төсөвт тавиад явж байгаа юм байна аа. Үлдэгдэл 110 км-ийг нь та нар төсөвт тавиагүй байгаа учраас энэ хооронд энэ зураг нь одоо шинэчлэх шаардлагатай болчихсон юм байна гэж ойлголоо шүү дээ. Анхны 40 км замыг та нар 159 км-ийн анхны хийсэн зураг төсвөөр нь явуулчихсан юм байна. Тэгээд дахиад зураг төсөв шинэчлэх шаардлагатай гэдэг чинь тэгээд би сайн ойлгохгүй л байгаад байна л даа.

Одоо яг энэ дээр ажлын хэсгийг яг энэ дээр хууль тогтоомж зөрчсөн гэж үзэж байгаа юм уу? Зөрчөөгүй гэж үзэж байгаа юм уу. Яг зөрчсөн, зөрчөөгүй ганцхан үг хэлээдэх дээ.

5 номерын микрофон өгье.

Ж.Дэлгэржаргал: Одоо яг замуудын хувьд бол барилгыг бодвол тасдаж тавьдаг. Яагаад гэвэл бид нар урт нийт одоо 100км-ээр ч юм уу тавих боломжгүй учраас тастаад явж байгаа. Тэгэхээр одоо Арцсуурийн энэ саналын томъёоллоор бол 2027 оны төсөв дээр энэ төсөл өөрөө тэр одоо замын үлдэгдэл яг боломжит шинэ төсөл шиг сууна. Шинэ төслөөрөө суух тохиолдолд үндсэн тэр зургийнхаа километрийг шинэчилсэн зураг төсөвтэй байх ёстой. Энэ Төсвийн тухай хуулийн 29.4 дээр сүүлийн 2 жилийн магадлалын зураг төсөвтэй байна гэдэгт яг ингээд замыг нь харах юм бол одоо зураг төсөвтэй байгаа. Гэхдээ хуулийн шаардлагаараа шинэчлэх ёстой төсвөө шинэчилнэ гэсэн үг.

Б.Заяабал: Тэгээд энэ ажлын хэсэг яг зөрчсөн гэж үзэх юм уу зөрчсөн гэж үзэж байгаа бол би санал хураалт явуулахаа болилоо. Зөрчөөгүй гэвэл би санал хураалт явууллаа. Би бол 159 км замын одоо ажлын зураг төсөв ТЭЗҮ явагдчихсан тэндээсээ таслаад 40 явуулчихсан гэж үзээд энийг боломжийн юм байна гэж үзээд байна шүү дээ.

Ж.Дэлгэржаргал: Энэ дээр дарга яг Төсвийн хуулийн шаардлагыг хангах юм бол 2 жил гэдгээ хангахгүй. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль буюу жилийн төлөвлөгөө бол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа барьж байгаа. Тэрний 6-гийн ын 10.2 буюу ТЭЗҮ, зураг төсөв гэдэг шаардлагаа хангаж байгаа гэсэн үг.

Б.Заяабал: Ингээд хуулиараа жилийн төлөвлөгөө ярьж байгаа учраас хөгжлийн бодлого төлөвлөлтийн 6.10.2-т нийцэж байгаа учраас уг санал хураалтыг явуулъя аа. Гишүүдийг санал хураалтад явуулъя.

47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй ээ.

66.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-9.3.1.3, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойбалсан хот-Буйр нуур-Баянхошуу боомт чиглэлийн 210 км хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “420,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “12,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл

хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд.

Санал хураалт.

Би сая энэ зарчмын зөрүүтэй санал уншиж байгаад харин яачихлаа, дарж амжсангүй хугацаа хоцорчихлоо.

Тийм учраас горимын санал би гаргаж болох юм болов уу? Би горимын санал гаргаж байна аа. Тийм учраас өмнөх санал хураалтыг хүчингүй болгож дахиж санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна аа. Санал хураалт явуулъя.

Санал дэмжигдсэнгүй ээ.

67.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-9.3.13, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойбалсан хотоос Баян-Уул сум хүртэлх 195 км хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “390,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “130,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэлд “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээнд “Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “323,196.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “96,958.80” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Нэмэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батэ-Эрдэнэ 54 дүгээр саналыг Бат-Эрдэнэ гишүүн 68 дугаар саналтай нэгтгэх санал гаргаж оруулж ирсэн байгаа. Мөн Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат нарын санал байна аа. Эрдэнэбат гишүүн санал гаргагч Эрдэнэбат гишүүн үг хэлнэ. Эрдэнэбат гишүүний микрофон. Энэ юу бол зөвхөн Мөрөн, Жаргалын асуудал биш. Архангай, Завхан, баруун аймгуудын бас нэлээн олон аймгуудыг эдийн засаг аялал жуулчлалын хууль маш чухал зам байгаа юм. Тийм учраас би бол одоо энэ санал дээр бол аймаг нь ч гэсэн ганцхан энэ замыг бол дэмжиж өгөөч гэдэг чухал санал. Тэгээд 3-ын гурван гишүүн одоо нийлээд бас гаргаж байна гэж хэлж болно. Тийм учраас та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье 22 жил одоо болж байгаа ийм зам юм, аялал жуулчлалын. Мөрөн, Жаргалан, Архангайн, Завханы сумууд нийлээд орж ирэх ийм зам байгаа.

Б.Заяабал: Санал хураалт явуулъя.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэн байна

69.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын төвөөс Даян боомт чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын явц” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “289,258.9” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “86,77.6” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл.

Санал хураалт явуулъя.

47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй ээ.

70.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.2, ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан- Улаанбаатар чиглэлийн авто замаас Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн авто замын их засварын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “24,174.01” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “24,174.01” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд.

Ажлын хэсгийн 5 номерын микрофон өгье.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам Дэлгэржаргал.

Нэгдүгээрт орон нутгийн төсвийг бол бид нар энд шууд одоо яг тухайн төсөл арга хэмжээг нь зааж бол шийдэх боломжгүй. Иргэдийн хурлын өөрийнх нь бүрэн эрх байгаа.

Хоёрт нь Нэгжийн тухай хуулийн 20 дээр зам засварын асуудал бол орон нутгийн чиг үүрэгт хамаарагддаг.

Б.Заяабал: Ингээд энэ санал нь сая ажлын хэсгийн тайлбарын дагуу хууль тогтоомж зөрчигдөж байна гэж ингэж үзэж байгаа учраас энэ санал хураалтыг явуулахыг татгалзаж байна аа.

71.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.3.11” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөх Баавгайн Үүр” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “7,286.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,286.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” Хамтран хариуцагч “Хөвсгал аймаг” гэж нэмэх.

Хөвсгөл аймаг гэж байж болохгүй байх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэд үг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хамтран хариуцагч Хөвсгөл аймаг гэдгийг хасах найруулгын санал гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүний найруулгын саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

72.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Арц суурь хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлтийн ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “67,005.0” гэж, Тухайн жилд шаардагдаж санхүүжилт сая.төг “20,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Гадаадын зээл” гэж, Үндсэн хариуцагч “Сангийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг хөгжлийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин.

Ажлын хэсгээс санал байна уу? 5 номер ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам Дэлгэржаргал.

Одоо яг боомтын 5 боомтын бүтээн байгуулалт бол гадаад зээл дээр батлагдаад явж байгаа. Тэрэн дээр Арц суур бол байхгүй. Тэгэхээр энэ агуулга нь бол шинэ гадаад зээл болж явна гэсэн үг. Одоо явж байгаа АХБ-ан дээр бол Бичигт, Хавирга, Цагааннуур, Булган, Цагаандэлэг бол явж байгаа. Тэгэхээр яах вэ одоо яг энэ агуулгаар бол шинэ хэлэлцээр л явна гэсэн үг. Одоо байгаа зээлийн хүрээнд бол байхгүй. Санхүүжилт, эх үүсвэр тодорхой л байх хэрэгтэй л гэж бодож байна.

Б.Заяабал: Эх үүсвэрийн асуудал нь шийдэгдээгүй учраас ажлын хэсгийн саналын дагуу 72 дахь саналыг санал хураалт явуулахаас татгалзаж байна аа.

73.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.2.1 дэх дэд заалтад “Бодлогын үндэслэл” “АХ-8.1.8, МУХТЖҮЧ-5.7.2.1, ЗГҮАХ-3.3.2” гэж, Төсөл, арга хэмжээ “Ханх-Мондын боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөл, шинэчлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “25,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар.

Ажлын хэсгийн 5 дугаар микрофон өгье. Сангийн яам.

Ж.Дэлгэржаргал: Энэ 73 дугаар санал мөн адил. Энэ боомтын бүтээн байгуулалтууд бол нөгөө эх үүсвэр нь тодорхой явж байгаа. Тэгээд энэ боомтын хувьд бол бас зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй байгаа. Бэлэн биш эрэмбийнхээ хувьд ч

гэсэн яг энэ боомтын бүтээн байгуулалт нэлээн хойшоо байгаа. Одоо эхний боомтууд нь яг саяын 5 боомт л эх үүсвэртэй хэрэгжээд явж байгаа.

Б.Заяабал: Зураг төсөв ТЭЗҮ хийгдээгүй учраас 73 дахь саналыг санал хураахаас татгалзаж шийдвэрлэж байна аа.

74.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.1 дэх дэд заалтын “Гэр хорооллын айл өрхийн бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Зорилтот түвшин “1” гэснийг “5” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

75.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.3.1.2 дахь дэд заалтын “Онги-Цагаанбургастай” төслийн бэлэн байдлын хангалт” гэсэн Шалгуур үзүүлэлтийн “Нийт санхүүжилтийн дүн сая төгрөг “0” гэснийг “44,490.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг “30,230.0” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам. Тэгэхээр энэ хийгдэж явж байгаа ажил. Тэгээд хийгдэж явж байгаа ажил дээр энэ нэмэлт төсөл тавигдсан. Ийм санал байна л даа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон нэмэлт. Та нар яг ажлын хэсэг энэ хуулиа яг саяын энэ хуулийн дагуу зөрчсөн, зөрчөөгүй гэдэг дээр тодорхой хариулт өгмөөр байна аа. Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Дэлгэржаргал: Энэ хөрөнгө оруулалт бол энэ жил шинээр эхэлсэн 30 тэрбум нь ирэх оных нь үлдэгдэл гэсэн үг явж байгаа. Эдийн засгийн яам нөгөө хуулийн шаардлагынхаа дагуу өөрөөр хэлбэл хөгжлийн төлөвлөгөө, өөрөө ТЭЗҮ, зураг, төсөвтэй төслүүд байдаг учраас ТЭЗҮ боловсруулах ажлууд угаасаа дутах шаардлагагүй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл энүүгээрээ одоо жилийн төлөвлөгөө дээр энэ тусгагдсан тусгагдаагүй манай төсөв дээрээ шилжих ажлаараа үргэлжлээд явна гэсэн үг. Агуулгын хувьд. Хууль бол зөрчөөгүй.

Б.Заяабал: Үргэлжилж явах ажил юм байна. Тэгэхдээ хууль зөрчигдөөгүй учраас баталгаажуулах шаардлага л үүсэж байгаа юм байна тийм үү?

Санал хураалт явуулъя.

Хууль зөрчөөгүй учраас 75 дугаар санал.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй ээ.

Тэгэхдээ энэ сая ажлын хэсгийн тайлбарын дагуу энэ үргэлжлээд явах ажил гэж ингэж ойлгуулж тайлбарласан.

76.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.2 дахь дэд заалтын Бодлогын үндэслэл “АХ-5.1.3, МУХТЖҮЧ-7.2.2.2, ЗГҮАХ-4.1.5.2” гэснийг “АХ-5.1.3, МУХТЖҮЧ-5.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх” гэснийг “Хиймэл оюун ухааны тоног төхөөрөмжийн нэмэлт сайжруулалт” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “0” гэснийг, “3,700.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг 1,500.0” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж.

Санал хураалт явуулъя.

52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

77.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.5, МУХТЖҮЧ-7.2.3.1, ЗГҮАХ-4.2.1.14” гэж, Төсөл, арга хэмжээ “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн, тогтвортой ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор цахим баазыг өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Үйл ажиллагааны хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,000.0” гэж, Тухайн жилд шаардагдаж санхүүжилт сая.төг “6000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Улсын ерөнхий прокурорын газар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа.

Адил агуулгатай санал байгаа тул 77, 78 дугаар саналыг уншаад нэг санал хураалт явуулах юм байна.

78.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.5, МУХТЖҮЧ-7.2.3.1, ЗГҮАХ-4.2.1.14” гэж, Төсөл, арга хэмжээ “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн, тогтвортой ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор цахим баазыг өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Үйл ажиллагааны хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “30,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “10,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Улсын ерөнхий прокурорын газар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн. Ийм хоёр гишүүний адил санал байгаа юм байна.

Эхлээд 77 дугаар саналаар санал хураалт явуулах юм байна.

Санал хураалт.

43.5 хувиар дэмжигдсэнгүй.

Адил агуулгатай санал учраас 78 дахь саналаар санал хураалт явуулъя.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй ээ.

79.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.1.2.5 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.45, МУХТЖҮЧ-5.4.1.2, ЗГҮАХ-3.3.5, 3.3.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл; /Сүхбаатар Дарьганга сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “60,200.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “30,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, У.Отгонбаяр, Л.Соронзонболд.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

80.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 10.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4, МУХТЖҮЧ-10.1.1.1, ЗГҮАХ-3.3.7.1, 3.3.7.3, 3.3.7.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн түншлэлийн гэрээ” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар.

Санал хураалт явуулъя.

39.1 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

81.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 13.1.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-1.1.15, 1.1.19, МУХТЖҮЧ-3.1.1.2, ЗГҮАХ-3.3.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүүхдийн ордон барих /Увс, Улаангом сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “11,974.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,991.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал.

Санал хураалт.

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

82.Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр “Засаглал /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, Үр дүн “Хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээлэл олон нийтэд нээлттэй болсон байх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төсөв, санхүүжилтийн эх үүсвэр, тендер, гүйцэтгэгч, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн тайлангаа нээлттэй цахим системд улирал тутам байршуулсан төсөл, арга хэмжээний эзлэх хувь” гэж, Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа “ТХЗ 16.6” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин

“2027 онд батлагдсан төсөл, арга хэмжээний мэдээллийг улирал тутам байршуулсан байх” гэж, Мэдээллийн эх сурвалж “Цахим хяналтын системийн тайлан”, гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Цахим системийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, аудит” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Улирал тутам” гэж, Хариуцах байгууллага “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Ажлын хэсгийн ахлагч Лувсанжамц гишүүнд микрофон өгье.

Г.Лувсанжамц: Тийм. Эрхэм гишүүд ээ энэ 3 дугаар хавсралт буюу төсөв мөнгөтэй ямар ч хамааралгүй. Шалгуур үзүүлэлтээ зөв болгоё гэж байгаа. Дээрээс нь нэмээд төрийн мэдээллийг ил тод болгоё гэсэн зарчмын зөрүүтэй саналууд орж ирсэн байгаа учраас үлдсэн саналуудыг та бүхэн маань дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Б.Заяабал: Санал хураалт явуулъя.

Санал хураалт.

39.1 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй

83.Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авилгын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд авлигын эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийсэн байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Авлигын урьдчилсан үнэлгээ хийсэн 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний эзлэх хувь” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 16.5, ТХЗ 16.6” гэж, “Хэмжих нэгж” “Хувь” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд холбогдох төсөл, арга хэмжээнд үнэлгээ хийсэн байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Авлигатай тэмцэх газрын тайлан, Үндэсний аудитын газрын тайлан”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Эрсдэлийн үнэлгээ, аудит, хяналт-шинжилгээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” “Хагас жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Авлигатай тэмцэх газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Санал хураалт.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

84.Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авилгын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “Тендер худалдан авах ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй болсон байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендерийн урилга, үнэлгээний дүн, шалгарсан гүйцэтгэгч, гэрээний дүн, гүйцэтгэлийн мэдээллээ байршуулсан худалдан авах ажиллагааны эзлэх хувь” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 16.6” гэж, “Хэмжих нэгж” “Хувь” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд мэдээллийг бүрэн байршуулсан байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Системийн тайлан, аудит” гэж, “Мэдээлэл цуглуулах

давтамж” “Улирал тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Сангийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Санал хураалт явуулъя.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

85.Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авлигын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “Орон нутгийн төсөл, арга хэмжээнд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, саналын тэмдэглэл хавсаргасан орон нутгийн төсөл, арга хэмжээний эзлэх хувь” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 16.7, ТХЗ 11.3” гэж, “Хэмжих нэгж” “Хувь” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд холбогдох төсөл, арга хэмжээнд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Аймаг, нийслэлийн Засаг даргын тайлан”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Тайлан, саналын бүртгэл, хэлэлцүүлгийн тэмдэглэл” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” “Хагас жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Санал хураалт.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

86.Төслийн 3 дугаар хавсралтын “Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” “Авлигын эсрэг үйл ажиллагаа /холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч/ холбогдох хөтөлбөрийн нэршилтэй уялдуулан тусгах” гэж, “Үр дүн” “Агаар, ус, хөрс, хүлэмжийн үзүүлэлтийг тогтмол хэмжиж, тайлагнадаг болсон байх” гэж, “Шалгуур үзүүлэлт” “Агаар, ус, хөрс, хүлэмжийн үзүүлэлтээр жил бүр шинэчилж нийтэлсэн тайлангийн тоо” гэж, “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” “ТХЗ 6.3, ТХЗ 11.6, ТХЗ 13.2, ТХЗ 15.3” гэж, “Хэмжих нэгж” “Тоо” гэж, “Суурь он” “2026” гэж, “Суурь түвшин” “0” гэж, “Зорилтот түвшин” “2027 онд 1-ээс доошгүй тайлан нийтэлсэн байх” гэж, “Мэдээллийн эх сурвалж” “Байгаль орчны мэдээллийн сан, Үндэсний статистикийн хороо”, гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” “Статистик мэдээлэл, байгаль орчны хэмжилт, хяналт-шинжилгээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Санал хураалт.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

87.Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71801 Сургуулийн өмнөх боловсрол”, Үр дүн “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” үр дүнгийн хүрээнд Шалгуур үзүүлэлт “Багшийн үндсэн цалин /Улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно/” гэж, Тогтвортой хөгжлийн зорилго “4.с.1” гэж, Хэмжих нэгж “Индекс” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “2,726.9” гэж, Зорилтот түвшин-2027 “2026 оны түвшнээс дээгүүр” гэж, Мэдээллийн эх сурвалж “Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, Мэдээлэл

цуглуулах давтамж “Жил тутам” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Санал хураалт.

43.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

88.Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71802 Ерөнхий боловсрол”, Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэсэн үр дүнгийн Суурь түвшин 1484 гэснийг 2769.9 гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Найруулгын санал байгаа юм аа. Энэ их чухал санал байгаа. Найруулгын санал дээр санал хураахаар байгаа.

Ингээд найруулгын саналыг уншиж танилцуулъя.

Найруулгын санал:

1.Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг гэсэн ийм санал байна.

Санал хураалт явуулъя гишүүд ээ.

Санал хураалт.

52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараа нэг асуудал байгаа.

Тогтоолын тогтоолын төслийн зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц уншиж танилцуулна аа.

18.10 цаг

Гурав.Улсын Их хурлын гишүүн Г.Лувсанжамцаас Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газарт хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Дараагийн асуудлыг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамцаас Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Монголбанкны ерөнхийлөгч тавьсан асуулгын хариуг хэлэлцэж эхэлье ээ.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын хэсгийн албаны дарга Санжаагийн Даваасүрэнг асуулгын хариуг танилцуулахыг урьж байна. Ажлын хэсгийн Даваасүрэн байна уу? Ажлын хэсгийн албаны дарга Даваасүрэн байна уу? Даваасүрэн гишүүн 5 номерын микрофон дээр суучих. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе. 5 номерын микрофон.

С.Даваасүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцаас Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар.

Асуулга нэг.

Тогтоолд тусгасан Засгийн газрын хэрэгжүүлэх 17 арга хэмжээнээс өнөөдрийн байдлаар бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд байгаа болон бодит ахиц гараагүй арга хэмжээнүүдийг ялган тодорхойлж арга хэмжээ тус бүрийг хариуцсан байгууллага, хэрэгжилтийн үе шат, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын төсөв, бодит үр дүн гэсэн агуулга бүхий нэгдсэн хүснэгт тайлан мэдээллийн хүрээнд тушаал шинэчлэн батлах тухай Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн А700 дугаар тушаалын хавсралтаар агаар орчны бохирдлыг бууруулах хөдөлмөрийн төсөл арга хэмжээний зардлаас ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэхээр 700 сая төгрөгийг тусган баталсан бөгөөд хөрөнгө гаргах тухай тус яамны ТНБД-ын 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 329 дүгээр тушаалаар Төрийн банк болон Хас банканд гэрээний үндсэн дээр тус бүр 300 сая нийт 600 сая төгрөгийг хүүгийн татаас олгохоор шийдвэрлэж 2025 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Сангийн яамны санхүүжилттэй холбоотой хүсэлтийг хүргүүлсэн.

Тогтоолд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээллийг 2 дугаар хүснэгтээр хавсаргав.

Асуулга 2.

Тогтоолд заасны дагуу ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ногоон зээлийн санхүүжилт, ногоон барилгын шалгуур, эрчим хүчний хэмнэлтийн стандарт, хэмжих, хянах, тайлагнах тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газраас тодорхой хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулах үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомж болон салбарын яамдаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн тогтоолууд батлагдсан эсэх, хэрэгжилтийн явц талаарх бодит мэдээлэл мөн боловсруулалтын шатад байгаа эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдээлэл Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн бодит хугацаа, уг баримт бичгүүд бодлогын хувьд ямар өөрчлөлт үр нөлөө үзүүлэхээр тооцоолсон талаарх төлөвлөгөө бүхий тайлан мэдээллийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газраас татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэн амьдран суух зориулалтын ногоон орон сууц худалдан авах, барихад мөн гэр хорооллын орон сууцын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж дулаалгын материалд цахилгаан болон хийн халаагуур, дулаан насос худалдан авахад 15 сая хүртэлх албан

татварын хөнгөлөлт эдлүүлэхээр ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн. Уг хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг дараах агуулгыг тусгасан. Үүнд:

23.3.Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авах, барих, орон сууцын нөхцөл сайжруулахад зарцуулсан төлбөрийн баримтаар нотлогдсон дараах зардалтай тэнцэх хэмжээний орлогод ногдох 15 сая төгрөг хүртэлх албан татварын хөнгөлөлтийн тухай татвар төлөгчид нэг удаа эдлүүлнэ.

23.3.1.эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын стандарт хангасан орон сууц худалдан авах барихад зарцуулсан хөрөнгө,

23.3.2-т гэр хорооллын орон сууцын дулаан алдагдлыг бууруулах эрчим хүчний хэмнэлт бий болох. Нар, салхи, газрын гүний дулааны бо болон бусад сэргийлэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур дулааны насос худалдан авах авсан зардал зэрэг болно. Мөн Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яамнаас уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс сэргийлэх эрсдэлт эмзэг байдлын үнэлгээнд үндэслэн дасан зохицох арга хэмжээг төлөвлөх шаардагдах санхүүжилтийг олон талын эх үүсвэрээс шийдвэрлэх ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх уур амьсгалын санхүүжилтийн олон улсын механизмыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилготой анхдагч хуулийн төслийг Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран боловсруулж байна.

Энэхүү уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийн төсөлд ногоон санхүүжилтийн эх үүсвэр, ногоон санхүүжилтийн хэрэгсэл, хөшүүрэг, санхүүжилтийн ил тод байдал зэрэг тогтолцоотой холбоотой зохицуулалтыг тусгаад байна.

Асуулга 3.

Ногоон санхүүжилтийг бодит эдийн засгийн механизм болгон хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хамрагдсан банк санхүүгийн байгууллагуудын талаар. Мөн ногоон зээлд хамрагдсан иргэн ААН-үүд тэдний хамаарах салбар, бүс нутгийн байршил олгогдсон зээлийн нийт хэмжээ түүнчлэн ногоон зээлийн хүүгийн бодлого бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж хэрэгжиж дундаж хүү өмнөх үетэй харьцуулахыг хэрхэн өөрчлөгдсөн улсын төсвөөс хүүгийн татаас дэмжлэг хэлбэрээр хэдий хэмжээний санхүүжилт олгосон 2026 онд олгох зээлийн талаар бодит тоон үзүүлэлт бүхий нэгдсэн мэдээллийн хүрээнд:

Тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцын Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас агаар орчны бохирдлыг бууруулах, дулаалга ногоон барилга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бүтээгдэхүүний санхүүжилтийг дэмжих зорилгоор тушаалд шинэчлэн батлах тухай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн А700 дугаар тушаалын хавсралтаар ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний жагсаалт зээлийн хүүгийн хувь хэмжээг баталж иргэнд 14 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилийн 6 хувь, ААНБ-д 15 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилийн 8 хувийн хөнгөлөлт олгох ажлыг Төрийн банк, Хаан банк, Хас банктай

хамтран хэрэгжүүлэх нийт 600 сая төгрөгийг хүүгийн хөнгөлөлт зарцуулахаар гэрээ байгуулсан байна аа.

Асуулга 4.

Эрчим хүчний хэмнэлт дулаалгын бодлогоор хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хамрагдсан нийт өрхийн тоо энэ жилд хэчнээн килокалори дулаан мегаватт цахилгаан хэмнэж байгаа. Үүний үр дүнд агаар бохирдлын түвшинд бодитоор өөрчлөлт гарсан талаарх тоон үзүүлэлт тооцоолол бүхий судалгаанд тулгуурласан мэдээлэл байгаа эсэх, эрчим хүчний хэмнэлт дулаалгын бодлогын хүрээнд нийтийн орон сууцын дулаалгыг дэмжих зорилгоор 2022 оноос Европын холбооны байгууллагын 18 сая евро болон БХБЯ хуучнаар 8 сая евро, НЗДТГ 6.5 сая еврогийн санхүүжилтээр ХБНГУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын орон сууцын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам хариуцан ажиллаж байна.

Эрчим хүчний яам уг төслийн хэрэгжилтийн шатад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр оролцож байна. Мөн барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлт дулаалгын бодлогын хүрээнд Засгийн газрын 2025 оны 91 дүгээр.

Б.Заяабал: 5 дугаар микрофоныг нэмье.

С.Даваасүрэн: Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоолоор баталсан Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг шинэчлэхэд холбогдох арга хэмжээг нэмж тусгуулан батлуулаад байна аа. Дулаалга хийгдэж байгаа орон сууцын бүх барилгад дулааны тоолуур суурилуулснаар хэмнэж буй дулааныг тооцоолох нөхцөл бүрдсэн. БХБ-ын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн А257, А252 дугаартай тушаалаар баталсан барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журмын хүрээнд хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 855 барилгын зураг төсөл орон тооны бус экспертизээр хянагдаж эрчим хүчний гэрчилгээ олгогдсон байна. Агаарын бохирдлын түвшинд бодитоор өөрчлөлт гарсан талаарх тоон үзүүлэлт, тооцоо бүхий судалгаанд тулгуурласан мэдээллийг гаргах зорилгоор хэмжилтийн хийн тооллогын цахим системийг хөгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд барилгын салбарын хэмжээний хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох цахим системийн 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах 5 дүүргийн хүлэмжийн хийний хэмжээ 2024 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

Хан-Уул дүүрэг 3.38, Баянзүрх 0.5 хувь, Баянгол 2.74, Сүхбаатар 3.1, Чингэлтэй 0.92 хувь. Харин Сонгинохайрхан дүүрэг 1.26 хувиар буурсан үзүүлэлттэй байна аа. Хүлэмжийн хийн ялгарал нь тухайн дүүргийн хүн амын тоо, орон сууц, олон нийтийн барилгын тооноос хамаарч ялгаатай тооцоологдож байна.

Цаашид тооллогын системийг улам хөгжүүлж инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбоогүй барилга байгууламжийг бүртгэх хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох аргачлалыг батлуулах ажлууд үе шаттайгаар хийгдэж байна аа. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд төвлөрсөн дулаан хангамж холбогдсон нийт 1013 блок барилга буюу 181.2 килокалори цахилгаан дулааны ачаалалтай барилгыг 100 хувь дулаалах урьдчилан тооцоо хийсэн.

Дээрх барилгуудыг бүрэн дулаацсанаар төвлөрсөн дулаан хангамж, системийн ачааллыг бууруулах, улмаар дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэх боломжтой гэж тооцож байна. Урьдчилсан тооцоогоор барилгуудыг дулаалснаар 61.1 кил калорийг хэмнэх боломжтой байна. Үүнийг тусад нь задалж үзвэл Амгалан дулааны станц 16.6 кил калори цахилгаан, дулааны 2 дугаар станц 1.9 кил калори цахилгаан, дулааны 3, 5 кил калори цахилгаан, дулааны 4 36.7 кил калори дулааны ачилт буурах боломжтой бөгөөд уг тооцооллыг дулааны эх үүсвэрын сүлжээгээр тооцоолсон болно.

Одоогийн буй нөхцөл байдалтай харьцуулахад нэг барилгаас 40 хүртэл хувийн дулааны хэмнэлт бий болгох зорилгоор зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж уг даалгаврын дагуу нэг маягийн зураг төсөл боловсруулсан бөгөөд төслийн хүрээнд 2025 онд 45 блок барилгад дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дулааны хэмнэлт бий болгоход дараах 2 үзүүлэлт маш чухал нөлөө үзүүлж байна. Үүнд:

1.Халаалтын системд нэг өөрчлөлт хийж хэмнэлтээ барьж үлдэх оролдлого хийгээгүй бөгөөд үнэ, тариф задгай байгаа тул дулаан алдагдлаа бууруулсан ч үнэлэгдэхгүй бүрэн тооцоологдох боломжгүй байна.

Хоёрдугаарт нь ханган нийлүүлэгч тар тал гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх техникийн боломж алдагдаж дутуу нийлүүлж байна. Мөн дулаалгын үр дүнд бий болох дулааны хэмжилтийг хэмжих хэрэглээний дата мэдээллийг нарийвчлан бүртгэх зорилгоор 2024 онд Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийт 298 угсармал барилгад дулааны тоолуур суурилуулсан. Агаарын бохирдлыг бууруулах талаар талаар авах зарим зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоол Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны 04, 05, 06 дугаар тогтоол. Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 2025 оны А651, 983 дугаар тушаал захирамжийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг дулаалж хийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 3950 өрхийг бүрэн дулаалж 3976 өрхийг хийн түлшний төхөөрөмж суурилуулсан бөгөөд дулаалга хийснээр цахилгааны хэрэглээ 2 дахин буурч зардал багассан.

Асуулга 5.

Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын түвшинд нэгдсэн зохицуулалтын бүтэц тухайлбал ажлын хэсэг, зөвлөл, дэд хороо зэргийг байгуулж ажилласан эсэх бодлогын уялдаа холбоог төвлөрсөн байдлаар хариуцаж ирсэн ямар байгууллага байгаа талаарх тодорхой мэдээлэл хэрэгжилтийн явцад тулгасан эрх зүйн зохицуулалтын саад, санхүүжилтийн хүндрэл, институц хоорондын давхардал, уялдаа холбоо сул зэрэг бодит бэрхшээлүүдийн талаар Засгийн газрын зүгээс хийсэн үнэлгээ дүгнэлтийн хүрээнд:

Засгийн газрын хэрэгжүүлэхээр тогтоосон нэг заалтын хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын аргачлалын дагуу ЗГХЭГ-аас

2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ хийж, үнэлж, биелэлтийг Улсын Их Хуралд хүргүүлсэн. Энэхүү үнэлгээгээр тогтоолын хэрэгжилтийг 50 хувийн биелэлттэй буюу хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагыг тавьж дүгнэсэн.

Асуулга 6.

Цаашид 2026-2028 онд Ногоон санхүүжилтийн тогтолцоог эдийн засгийн салбарын бодит механизм болгох* иргэн ААН бодитоор хүртээмжтэй болгох, хотын агаарын бохирдол, эрчим хүчний хэрэглээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чиглэлээр Засгийн газраас баримтлах бод төлөвлөгөө, зорилт, шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны бодлогын талаар:

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ажлын алба хамтран нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлийн 5 зорилт, 47 арга хэмжээ бүхий 2026-2030 он хүртэлх дунд хугацааны төлөвлөгөөний төслийг шалгуур үзүүлэлтийг хамт боловсруулсан.

Уг төлөвлөгөөний төслийг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд төсөл дэмжигдвэл Засгийн газар.

Б.Заяабал: Одоо танилцуулга дуусчихсан уу? Хариулт.

Ажлын хэсгийг танилцуулъя аа. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга Даваасүрэн, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны ахлах мэргэжилтэн Төмөрбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, тус яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Орчны бохирдлын бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Мөнхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Тамираа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД Баяраа, тус яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхтөр, тус яамны Барилгын материалын хэлтсийн дарга Батзориг. Яамдууд хааччихсан юм. Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Батболд, ХХААХҮЯ Стандартчилал хэмжил зүйн газрын Мэдээлэл технологи стандартын лавлагаа сургалтын төвийн дарга Содном, Стандартчилал тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн Эрдэнэбилиг, ХХААХҮЯ ЖДҮ-ийн газрын дарга Эрдэнэсайхан, НЗДТГ Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар Ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Амартүвшин. Өргөдлийн байнгын хороон дээр бас зэрэгцээд хуралдаж байна уу? НБОГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхбаяр, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар. Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирал Амгалан, тус газрын Тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн захирал Эвшинхорлоо, тус газрын тогтвортой хөгжил ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн ахлах эдийн засагч Гонгор, тус газрын Тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн эдийн засагч Өрнүүн, банкнуудын төлөөлөл бас байгаа юм байна. ХХБ-ны Ногоон санхүүжилтийн

албаны дарга Нямсүрэн, Хаан банкны Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, ногоон банкны газрын захирал Болортуяа, Голомт банкны тогтвортой санхүүжилтийн хэлтсийн захирал Анужин, Хас банкны Эко банкны газрын захирал Туул, Төрийн банкны тогтвортой хөгжлийн албаны ахлах менежер Энх-Эрдэнэ гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн иржээ.

Асуулгын хариутай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Асуулга асуусан гишүүн дараа нь бас үг хэлж асуулт асуух дэгтэй юм байна. Гишүүд Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүний микрофон өгье.

С.Эрдэнэбат: Энэ өөрөө маш их чухал асуудал байж байгаа. Тэгэхээр та бүгд маань одоо Их Хурлын гишүүдийн тодорхой бас асуултууд бол байж байгаа. Хэчнээн айлыг одоо жишээлбэл энэ ногоон зээлд хамруулав. Хэчнээн төгрөг зарцуулав. Энэнээс болж хэчнээн одоо байгаль орчинд болон одоо утаа үйлдвэрлэхгүй болов гэдэг л гол үр дүн байх ёстой л доо.

Тийм учраас одоо манай аймгууд хүртэл одоо бүгдээрээ мод түлдэг байгаа. Нүүрс түлдэг байгаа. Дулааны тоолуур 298 тоолуур суулгасан гээд ярьж байна. Тэгэхээр ямар одоо угсармал 298 барилгад тоолуур суулгалаа гээд тавьчихаж. Тэгэхээр манайх чинь ямар барилгууд одоо яг та хэд маань сонгож байгаад тавьчихав. Гэр хорооллын гээд тавьчихлаа.

Зээлийн хувьд ингээд аваад үзэх юм бол яг ний нуугүй хэлэхэд энэ зээлийн эх үүсвэрт зарцуулж байгаа хөрөнгө мөнгө гэдэг юм уу энэ зүйл би бол хангалтгүй байгаа гэж харж хэлмээр байгаа юм. Хамгийн наад зах нь одоо төрийн байгууллагуудын дулаан алдагдал гэдэг бол бас замбараагүй юм байгаа шүү дээ. Ер нь бол яг ний нуугүй хэлэхэд бол сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сумын төвийн одоо байр гээд л. Одоо та нар харсан бол манай Хөвсгөл аймагт гэдэг юм уу, Булган, Архангай гээд харахад бол хашаагаараа дүүрэн одоо 500, 600 машин түлээ түлдэг. Тэр одоо жишээлбэл одоо хэдэн хувиар буурав аа. Тэр суманд ингэж буурлаа ингэж дулаалга хийснээр гэдэг байдлаар ингээд тийм талаар нэг маш тодорхой точный, нэг тоо статистикаар хэлээд өгөөч гэдгийг бас хэлмээр байна.

Хоёрдугаарт иргэд өөрөө энэ дулаан цахилгаанаа хэмнэх энэ тал дээр бол одоо яг ямар сувгаар мэдээлэл өгвөл илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ? Та хэд маань энэ яг энэ ямар сувгаар энэнийг сурталчлах ажлыг хийж байгаа вэ гэдгийг бас асуумаар байна аа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн хариултад яг хариулах эрх бүхий албан тушаалтнууд нь гараа өргөөд хариултаа өгөөд байгаарай. Монголбанкнаас ямар ч байсан эхэлчихье. Энэ зээлийн санхүүжилттэй холбоотой их бага байна ногоон санхүүжилт гэсэн асуудал яригдсан.

Ингээд Монголбанкнаас эхлээд дараа нь гар өргөөд хариулаад яваарай ажлын хэсгээс. Монголбанкны 3 номерын микрофон.

Б.Амгалан: Монголбанк санхүүжилтийн асуудлаар мэдээлэл өгөхөд Монголбанкны зүгээс энэ барилгын зээлийг нөгөө ялангуяа энэ ногоон барилгын зээлийг гаргах үүднээс 2024 онд, 2025 онд бол бодлогын арга хэмжээ авсан. Ингэснээрээ ногоон барилгын яг энэ ангилалд багтсан зээл бол нийтдээ нэг 98

тэрбум төгрөгийн зээл арилжааны банкнууд дээр олгосон байгаа. Тэгээд 2025 онд бас Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар энэ орон сууцын ипотекийн зээлийн энэ журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт, өөрчлөлт оруулснаараа энэ амины орон сууцыг яг энэ ялангуяа ногоон ийм арга хэрэгслээр барьсан. Энэ амины орон сууцыг энэ ногоон моргейжийн зээлд хамруулах ийм боломжтой болсон. Тэгээд энэ хүрээнд 857 зээлдэгч 163.8 тэрбум төгрөгийн амины орон сууцын санхүүжилтийн зээл авсан байгаа.

Ногоон зээлийн энэ зээлийн хүү ер нь энгийн зээлийн хүүтэй харьцуулахад 3 нэгж хувиар бага. Өөрөөр хэлбэл зүгээр олгож байгаа энгийн зээл бол нэг 17.1 хувьтай байгаа. Ногоон ангиллаар энэ багтаж байгаа зээлийн хүү маань бол нэг 14 хувьтай байгаа. Татаж байгаа эх үүсвэрүүдийн хувьд бол харьцангуй арилжааны банкнууд бол урт хугацаатай татаж байгаа. Энгийн хэлбэрээр татаж байгаа эх үүсвэрүүд бол нэг жил гаран хугацаатай байгаа. Яг ногоон ангиллаар энэ ногоон таксономын хүрээнд татаж байгаа эх үүсвэр бол нэг 4 жилийн хугацаатай байгаа.

Б.Заяабал: Мөн ногоон санхүүжилтийн зээлийн яг хэрэгжилтийн шатыг хариуцаж байгаа манай яг холбогдох арилжааны банкнуудын энэ одоо ногоон санхүүжилтийн албадын дарга нар ирсэн учраас бас банкнууд бас нэг нэг минутаар мэдээллээ бас өгөөд явбал зүгээр байх гэж бодож байна.

Ингээд ХХБ-ны ногоон санхүүжилтийн албаны дарга Нямсүрэн нэг номерын микрофон дээр суугаадаг даа. Нэг номерын микрофоныг нээе.

Д.Нямсүрэн: Сайн байцгаана уу? ХХБ-ны хувьд бол бид нар 21 оноос хойш эх үүсвэр гаднаас эх үүсвэр татан төвлөрүүлээд тэр татсан татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ ногоон таксономи болон өөрийнхөө баталгаажуулсан баримт бичгийн хүрээнд ногоон зээлүүдийг олгоод явж байгаа. Өнөөдрийн байдлаар манай нийт ногоон зээлийн ангиллын дийлэнх хувь буюу 35 хувийг сэргээгдэх эрчим хүч 32 хувийг эрчим хүчний хэмнэлт, үлдсэн нь хог хаягдал, тогтвортой бус хог хаягдал болон бусад ангиллууд эзэлдэг. Сэргээгдэх эрчим хүчний хувьд бол айл өрхийн гэхээсээ илүүтэйгээр дандаа байгууллагын эрчим хүчний хэрэглээг хангах төслүүд дийлэнх хувийг эзэлж байгаа. Энэ дотроо эрчим хүчний хэмнэлт гэдэг ангилал дээр одоо дулаалгаас авхуулаад эрчим хүчний хэмнэлттэй барилга байшин эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжүүд эзэлдэг.

Хүүгийн хувьд бол одоогийн байдлаар бид нар 1 сарын 35-аас 55 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Б.Заяабал: Нэмэлт авах уу? Нэмэлт нэг минут өгөөдөхье. Нэг номер дээр. ХХБ-ны одоо Ногоон зээлийн санхүүжилтийн албаны дарга.

Д.Нямсүрэн: Тэгээд бид нар ер нь бол энэ хугацаанд нийт 50 гаруй сая долларыг яг ногоон санхүүжилтэд зориулж цэвэр олгосон байгаа. Тэгээд зөвхөн ногоон санхүүжилтийн ангиллаар гэсэн зээлүүд. Тэгээд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцууд дийлэнхдээ орж ирдэг. Эрэлтийн хувьд бол нэлээн өндөр. Гэхдээ эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ буюу нийт 20-оос дээш хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгож байгаа харилцагч нарт бид нарт одоо зээлийг дамжуулан зээлдүүлж байгаа барилга барьж байгаа компаниуд болон иргэд энэ дээр зээлийн одоо хүсэлт давамгайлж орж ирдэг зээлүүдийг олгоод явж байна аа.

Б.Заяабал: Баярлалаа. Хаан банкны Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт Ногоон банкны газрын захирал Болортуяа 1 дүгээр микрофон дээр суугаад. 1 номерын микрофоны нээе.

Б.Болортуяа: Сайн байцгаана уу? Хаан банкны хувьд нийт нөгөө банкны салбарын ногоон зээлийн багц маань болохлоор 2.3 их наяд хүрсэн. 2025 оны эцсээр. Хаан банкны хувьд болохоор нийт зах зээлийн эзлэлт бол 48 хувьтай байна. Зээлийн багц маань 1.2 их наяд хүрсэн. Өнгөрсөн оны сүүлээр. Энэ дээр нөгөө зээлийн багцаа бид нар ер нь харах юм бол хамгийн их нь эрчим хүчний хэмнэлт чиглэлд бол нийт олгосон зээлийн маань 70 хувь нь олгогдсон байна.

Дараагийн нөгөө томоохон чиглэл нь болохоор тогтвортой хөдөө аж ахуй, тэгээд сэргээгдэх эрчим хүч гэх мэт одоо чиглэлээр олгогдсон байгаа. Хаан банкны хувьд мэдээж нөгөө маш олон салбар нэгжтэй. Салбар нэгжээрээ дамжуулан бүх нөгөө сегментийн иргэд болон ААН байгууллагын жижиг, дунд бизнес эрхлэхэд бүгдэд нь зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ гаргадаг. Ногоон зээлийн хувьд болохлоор нийт Хаан банк одоогоор бол.

Б.Заяабал: Нэг номерын микрофоныг дахиад нэг минут нэмээд өгчихье.

Б.Болортуяа: 13 төрлийн ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ харилцагчдад санал болгож ажиллаж байгаа. Энэ дээр мэдээж сая хэлсэн одоо нөгөө орон сууц эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын тухай ярьж байна. Энэ дээр ногоон барилга дээр бол нөгөө зээл олгож байна. Бас эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц дээр зээл олгож байгаа. Хамгийн сүүлийн байдлаар яг эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцын хувьд бол нийт 267 зээлдэгчид 60 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна аа. Ер нь Хаан банкны хувьд бол ногоон болон жендер тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааны чиглэлээр маш их хөрөнгө оруулалтыг гаднаас олон улсын санхүүгийн байгууллагуудаас авдаг. Нийтдээ нэг 2020 оноос хойш бол 380 гаруй сая долларыг зөвхөн ногоон санхүүжилт тал дээр татсан байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. Хас банкны Эко банкны газрын захирал Туул нэг номер дээр суугаад мэдээлэл өгье. Нэг номерын микрофоныг нээе.

Г.Туул: Тэгэхээр Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолыг ярьж байгаа учраас би яг тэр тогтоолтой холбоотой илүү дулаалга, халаагуур, гэсэн бүтээгдэхүүн дээрээ ярьж гэж бодож байна. Хас банкны хувьд бол одоо яг 1 дүгээр улирлын байдлаар нийт зээлийн багцын орчим хувь нь бол ногоон. Тэгээд яг бид нарын ингээд харахаар ногоон бизнесийн зээл бол дийлэнх нь байж байдаг. Мөн дараагийн нэг том багц нь бол эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц 16 тэрбумын үлдэгдэлтэй. Тэгэнгүүт бид нарын яг гэр хороолол гэж 2019 оноос хойш яг зорилтот зах зээлээ болгоод дулаалга халаагуурын зээл гаргахад одоогийн байдлаар бол үндсэндээ 40-50 л харилцагч 300-аад саяын багц яг энэ дулаалга дээр, тэгээд бас нэг 200-аад гаран сая төгрөгийн бас нэг 50 орчим харилцагч яг одоо халаагуур дээр одоогийн байдлаар яг үлдэгдэл одоо байгаа зээлийн багц маань ийм байгаад байгаа юм. Тэгэхээр энэний гол учир нь бол.

Б.Заяабал: Дахиад нэг минут нэмье дээ. Нэг номерын микрофон.

Г.Туул: Энэний гол учир нь бид нарын нөгөө зорилтот зах зээл буюу гэр хорооллын бага орлоготой иргэдийн хувьд хэрэглээний зээлийн 30 сар гэдэг энэ хязгаарлалтад ерөөсөө орчхоод зээлийн шалгуур хангахгүй ийм гол одоо бэрхшээл байсан. Сүүлийн 3 жил бид нар ерөнхийдөө Монголбанканд тавьсан хүсэлт. Тэгэхээр яг энэ Их Хурлын тогтоолын хүрээнд бол Монголбанк өнгөрсөн 7 хоногт бол энийг 30 сарыг нь 60 сар болгосон. Тэгэхээр үндсэндээ бол бас энэ дээр бид нарын одоо нөгөө гол бэрхшээлтэй асуудал шийдэгдсэн гэж үзэж байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. Төрийн банкны Тогтвортой хөгжлийн албаны ахлах менежер Энхэрдэнэ. 1 номерын микрофоныг нээе.

А.Энх-Эрдэнэ: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн банкны Тогтвортой хөгжлийн албаны менежер Энх-Эрдэнэ. Төрийн банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцынхаа 10 хувийг ногоон болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа. Үүнээс энэ жилийн хувьд бол 3 хувийг нь эзэлж байна. Үүн дотор нь агаар хөрсний бохирдлыг бууруулах буюу энэ зорилтот сегмент дээр бол нийтдээ 500 орчим өрхийг эрчим хүчний хэмнэлттэй байшин барих замаар янданг нь болгосон байна. Мөн бэлтгэн нийлүүлэгчтэйгээ хамтраад 2 мянган янданг байхгүй болгосон байна. Мөн өнгөрсөн онд бид нар 2 нийтдээ 6 төрлийн бүтээгдэхүүнийг зах зээл дээр санал болгосон. Нэг нь бол шинээр баригдаж байгаа эрчим хүчний хэмнэлтийн орон сууц болон ногоон орон сууцын бест гэр аргачлалыг шалгуураа болгоод олгож байгаа. Мөн энэ жилийн хувьд бол ногоон бест грийн шар шалгуур хангасан 4 зээлийг бол олгосон байна аа. Мөн дотоодын арилжааны банкнууд дундаа манлайлал үзүүлээд ногоон харилцах дансны бүтээгдэхүүнийг эх үүсвэр.

Б.Заяабал: Нэг минут нэмж өгье. Нэг номерын микрофон.

А.Энх-Эрдэнэ: Эх үүсвэр нэмэгдүүлэх чиглэлд ногоон бага хүүтэй ногоон харилцах дансны бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. Мөн олон улсын зах зээл дээрээс бид нар өнгөрсөн онд 200 сая ам.доллар татсан. Үүний 50 саяын ногоон. Энэ жил бол 100 сая долларыг олон улсын зах зээл дээрээс татсан. Яг энэ ногоон үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байна.

Хэлэлцүүлэгтэй холбоотойгоор дэмжлэг хүсэх нь бол эх үүсвэр дээр своп хэлцлийг хөнгөлөлтийг нэмэгдүүлэх юм бол энэ төрлийн үйл ажиллагаа маань нэмэгдэх гээд байна. Мөн Байгаль орчны яамны хүүгийн хөнгөлөлтийн хэмжээг нэмж өгвөл бас илүү өргөн хүрээнд хүрэх гэж байна. Түрүүн хэлсэн бид нар энэ чиглэлийн мэдлэг мэдээллийг хүргэхдээ тогтвортой хөгжил ногоон ирээдүй үзэсгэлэн худалдааг жил болгон хийсэн. Энэ жил 3 дахь жилдээ зохион байгуулж байна. Ингэснээрээ агаарын бохирдлыг бууруулах технологийг дулаалгыг нэг дор бүгдээс нь харах боломжийг олгодог.

Дээрээс нь газар дээр нь зээлээ шийддэгээр онцлогтой ийм арга хэмжээг жил болгон зохион байгуулаад ажиллаж байна аа.

Б.Заяабал: Баярлалаа Голомт банкнаас ирээгүй билүү? Анужин ирээгүй байсан.

Гишүүний асуулттай холбоотой дулаалга муу байна, төрийн байгууллага иргэдийг ер нь дулаан алдагдлыг буулгах чиглэлээр ямар арга хэмжээ явж байна

вэ гээд энэ асуулгын 4 дүгээр асуудалтай бас холбоотой юм байна. Ингээд Агаарын бохирдлын үндэсний хорооны дарга Даваасүрэн. 5 номерын микрофон нээе.

С.Даваасүрэн: Аймгуудад бол тодорхой хэмжээнд бол ажил хийгдэж байгаа. Дархан-Уул аймгаас бид нарт мэдээ ирсэн.

2026 онд бол 0.9 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэхээр төлөвлөөд ажил хийгдэж байна гэсэн. Хөвсгөл аймгаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах агаарын бохирдлыг бууруулах тоосжилтыг бууруулах 3 мянган яндан буулгах зорилтын хүрээнд Хөвсгөл аймагт төвлөрсөн дулааны шугам сүлжээг өргөтгөх ажил үе шаттай хийгдэж байна. Баян-Өлгийгөөс хийгдсэн ажлаар. Дорноговь аймгаас 140 айл өрх 4 ААНБ-тай хамтарч та 2026 оны 5 дугаар сард Дорноговь аймгийн Сайншанд сумын 6 дугаар багт.

Б.Заяабал: 4 номер Улаанбаатар хотын төлөөлөл билүү. Улаанбаатар хот Мөнхбаатар гээд. 4 номерын микрофоныг нээе.

Д.Мөнхбаатар: Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар. Нийслэлийн зүгээс дулаалгын талаар бол маш олон зүйлийг бол хийсэн. Эхний ээлжид бид нар олон улсын судалгааны байгууллагаар Улаанбаатар хотын гэр хорооллын тодорхой бүсийг сонгон аваад 51 мянган айлыг төлөөлүүлж 3032 айлаас итгэх магадлал 99 хувьтайгаар судалгаа бол хийлгүүлсэн. Ингэхэд бол нийт айл өрхийн маань дулаан алдагдал нь бол монгол гэр бол 77 хувьтай, сууц байшин бол 79 хувьтай гэсэн дулаан алдагдалтай гэсэн ийм тооцоолол бол гарсан. Мөн энэ жилдээ байраа одоо гэр сууцаа дулаалах сонирхол бол манай иргэдэд бол 67 хувьтай бол энэ жил бол төлөвлөж байна гэж байгаа. Гэхдээ ганц зүйл нь бол 74 хувиар бол одоо эх үүсвэр одоо санхүүгийн бэрхшээлтэй байна гэдэг ийм асуудал судалгаа бол гарч ирсэн байгаа. Уг судалгаан дээр тулгуурлаад бид нар өнгөрсөн жил 3950 айл өрхийг дулаалж.

Б.Заяабал: 1 минут нэмээд өгчихье 4 номер дээр.

Д.Мөнхбаатар: 5 мянган айл өрхийг бол хийн зууханд бол шилжүүлсэн байгаа. Одоогийн байдлаар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр бид нар тодорхой бүс дээр нийт 52 зуухыг мөн хий рүү шилжүүлэх айл өрхүүдийг мөн хий рүү шилжүүлэх гэсэн ийм төлөвлөгөө дээр саналаа тусгаад одоо батлагдахыг хүлээсэн байдалтай байна аа. Хариулж дууслаа.

Б.Заяабал: Баярлалаа Эрдэнэбат гишүүн нэмэлт тодруулга. Эрдэнэбат гишүүний микрофон өгье.

С.Эрдэнэбат: Тийм. Та хэд маань ер нь хэчнээн одоо айл өрх юмнуудыг ингэхээс тэдэн хувьд нь бид нар ажиллаж байна, одоо тэдэн хувь нь ийм байна гэдэг байдлаар хариулбал уул нь сайн байгаа. Тэгэхээр ийм юмыг би бичгээр авмаар байна.

Хоёрдугаарт, Хэрэг эрхлэхээс өмнө байгаа билүү? Байхгүй байгаа юу? Би хэлчихье ер нь бол. Маш олон сумдаар одоо явахад нийт халаалт буюу мод түлдэг байсныг эргээд нийтийн халаалт болгоод төрийн байгууллагуудаа ядаж цаашлаад айл өрхүүдийг хийе гэдэг ийм байдлаар явж байгаа. Гэтэл эсрэгээрээ манай төсөв дээр яаж байна вэ гэхээр нийтийн халаалтынх нь мөнгийг нь өгдөггүй, маш олон

сумдууд тийм байгаа юм байна лээ, төсвийг нь хасаад хаячихсан. Тэгээд яаж байна вэ гэхээр эргээд нөгөө мод түлдэг байдал руугаа орох бие биеийгээ дамжсан баахан өртэй болсон ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ чинь бол яах аргагүй ногоон зээл буюу тэр хувийнхаа хөрөнгө оруулалтыг хийчихсэн орон нутгийн өмчөөр хийчихсэн байж байгаа нийтийн халаалтынхаа системийг яг одоо дэмжээд явахгүй бол тэд нар чинь эсрэгээрээ нийтийн халаалтуудаа болиод хуучин тэр модоо түлдэг юм руугаа орох гээд байх ийм аюултай.

Б.Заяабал: Ингээд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албаны дарга Даваасүрэн даргадаа гишүүний асуултын дагуу тодорхой бас дахиад нэмэлт мэдээллийг хүргүүлээрэй холбогдох байгууллагуудаас нэмж аваад Эрдэнэбат гишүүн рүү албан бичгээр хүргүүлээрэй гэдэг ийм зүйл хэлье.

Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1.2-т заасны дагуу Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга болон Монголбанкны ерөнхийлөгчид асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамцыг асуулгын хариутай холбогдуулан асуултаа асуухыг урьж байна аа. Гишүүний микрофоныг нээж өгье.

Г.Лувсанжамц: Ажлын хэсэг болон манай арилжааны банкнууд маань орой хүртэл хүлээсэнд баярлалаа. Тэгээд 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг явцыг нь харъя гээд ингээд та бүхнээс асуулгаа тавиад ялангуяа ЗГХЭГ руу бичиг явуулсан. Сайд нь баймаар байна. Утааны асуудал зөвхөн Улаанбаатарын асуудал биш байгаа. Эсвэл дулаахан болчихсон гээд утаагаа мартаад байдаг юм уу? 57 дугаар тогтоол дээр Засгийн газар болон Монголбанкны хийх ёстой ажлуудыг бүгдийг нь бичиж өгсөн. Биечлэн уулзаад зөвлөгөөг нь хүртэл өгөөд замын зураглалыг нь хүртэл гаргаж өгсөн. Өнөөдөр Хэрэг эрхлэх газраас нэг ч хүн байхгүй байна. Чуулганыг үзээд сууж байгаа Хэрэг эрхлэх газрын хүмүүс байх юм бол тусдаа уулзалт товлон юм уу, бичгээр өнөөдрийн энэ тавих асуултуудад хариу ирүүлэхийг хүсэж байна. Олон асуулт байгаа учраас та бүхэн маань тэмдэглэл аваасай гэж бодож байна. Аль байгууллагаас юу асуухаа тодорхой асууна аа.

Байгаль орчны яамнаас ногоон зээлийн хүүгийн татаасны гэрээг жил бүрийн эхний улиралд багтааж хийнэ гэсэн заалт оруулсан байгаа. Энэ жил хэдэн төгрөгөөр аль банкнуудтай ямар бүтээгдэхүүн дээр гэрээ хийсэн бэ?

Хоёр дахь нь Нийслэл болон Байгаль орчны яамнаас 4 дүгээр заалттай холбоотой. Нийслэл дээр дахин төлөвлөх газрыг 820 га газар гэж байгаа. 4384 нэгж талбар гэж байгаа. Дээрээс нь ногоон бүс гэж тогтоосон. Агаарын чанарыг сайжруулах бүс гэж бас нэг зүйл гаргачихсан байгаа. Эдгээрийн хоорондын уялдаануудаа та бүхэн харсан уу. Аль дүүрэг аль хороо нь яг аль бүсэд хамрагдаж байгаа юм? Ийм мэдээлэл байгаагүй юу? Ялангуяа зурган мэдээлэл байхгүй бол иргэдэд тодорхойгүй байдлыг үүсгээд байгаа шүү. Хэрвээ одоо хариулах боломжгүй бол бичгээр зурган мэдээллийг надад ирүүлэх хэрэгтэй байна. Нийслэлээс 6 дугаар заалттай холбоотой ипотекийн зээлээр амины орон сууц ногоон орон сууц худалдаж аваад үл хөдлөхийн гэрчилгээ гаргуулахад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө байх ёстой гээд Улсын бүртгэлийн газраас хэлдэг. Яг энэ хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан дүүрэг хорооны жагсаалтууд байна уу?

Хот байгуулалтын яам. Өнөөдөр нэг ч хүн байхгүй байх шиг байна.

7 дугаар заалттай холбоотойгоор Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр энэ 7 дугаар заалтад байгаа эрчим хүчний хэмнэлт нь Си болон түүнээс дээш төрийн барилга байгууламж дээр бол В түвшнээс дээш байх ёстой гэсэн ийм шаардлагуудыг стандартуудыг Барилгын тухай хууль дээр тусгаж байгаа юу үгүй юу?

9 дүгээр заалттай холбоотой эрчим хүчний хэмнэлттэй гэрийн стандартыг батлах ёстой гээд. Одоо бэлэн болчихсон байгаа Барилгын хөгжлийн төв, Хот байгуулалтын яам 2 нь хамтраад нэг хуралдаад л батлах боломжтой. Энэ ажил хэзээ хийгдэж байгаа вэ? Хэзээ батлагдах вэ? ЖДҮ-лэлийн газар хүнс ХААЯ 10 дугаар заалт хэрэгжээгүй байна аа. Хэзээ хэрэгжүүлэх вэ?

Ер нь хэрэгжүүлэх хүсэл зорилго байна уу?

Сангийн яамнаас 11 дүгээр заалт. ХХОАТ-ын буцаан олголтыг шинэ хуулийн төсөл дээр тусгасан уу? Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох эсвэл эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдаж авах юм бол 15 сая төгрөгийг төлсөн татвараасаа буцааж авна гэж байгаа? Энэ заалт одоо өргөн барьсан байгаа хууль дээр байна уу? Яагаад байхгүй байна. Байхгүй бол яагаад байхгүй байгаа вэ? Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос тогтоолын хэрэгжилт 50 хувьтай байна. Үлдсэн 50 хувийг хэзээ хэрэгжүүлэх вэ? Үндэсний хороо учраас үндэстнээрээ бид нар утаагүй болох зорилгыг тэр зорилгодоо хүрч байна уу үгүй юу гэдгийг танай хороо хариуцаж ажиллах ёстой.

13 дугаар заалт дээр дулаалахад цахилгааны хэрэглээ 2 дахин буурна, гаргах утааны хэмжээ ч гэсэн байшин, гэр дээр 2 дахин буурна. Утааг бол бид нар дулаалж л шийднэ. Утааг бууруулах үндэсний хэмжээний дулаалгын төлөвлөгөөг боловсруул гэсэн байгаа. Энийг боловсруулсан уу? Нийслэл болон аймгийн Засаг дарга нараас үйл ажиллагааны тайлангууд ирсэн байна. Үүнийг танай хороон дээр нэгтгээд үр дүнг нь хэмжээд Монгол Улс ер нь хэзээ утаагүй болох юм бэ? Ямар ажил хийхээр төлөвлөж байна аа? Саяын төлөвлөгөөн дээр ийм зорилтууд туссан байгаа юу?

Монголбанкнаас свопын татаасыг ногоон зээл дээр 2 дахин нэмэгдүүлсэн байгаа. Сайшаалтай зүйл гэж бодож байна. Ногоон зээлийн журмын шинэчлэлийн ажил яваад өнгөрсөн 7 хоногт батлагдсан юм шиг байна тиймээ. Батлагдаад шууд хэрэгжиж эхлэх үү эсвэл арилжааны банкнуудтайгаа дахиж хэлэлцэх шаардлага байгаа юу? 2019 оны Монгол Улсын ногоон таксономи 3.3.2 дээр ногоон зээлд эзлэх агууламж нь 58 хувь байгаа гэж байгаа. Энэний задаргаагаараа яг дулаалгад, байшин, гэрийн дулаалгад хэдий хэмжээний зээл олгогдсон байгаа гэдэг мэдээлэл хэрэгтэй байна.

Гурав дахь нь шийдэл асуух гэсэн юм. Арилжааны банкнууд дундаа хамгийн бага хүү санал болгож байгаа арилжааны банканд ногоон зээлийн хүүгийн татаасны гэрээ хийнэ гэсэн. Ийм шийдлээр хийх юм бол илүү ба иргэдэд очиж байгаа хүүгийн ачааллыг бууруулах боломж байгаа юу? Тийм тооцоо хийж байсан уу?

Дээрээс нь ипотеكتэй холбоотойгоор нэг минутаа авчихъя.

Б.Заяабал: Лувсанжамц гишүүний нэг минутыг нэмж өгье.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Ипотекийн зээлийг олгохдоо журам дээр нь өөрчлөлт хийгээд эрчим хүчний хэмнэлтийн хувьтай нь дүйцүүлээд зээлийн хүү нь буурдаг гэсэн ийм уялдах ажлыг хийх боломжтой байдаг уу?

Дээрээс нь зөвхөн Амгалан, Баянхошуу, Сэлбэ дэд төв гэсэн яг утааны голомт болчихоод байгаа энэ газрууд дээрээ дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлж байгаа бол энэ хэсэг дээр л ипотекийн хөнгөлөлттэй зээлээ олгоё гэсэн утааг бууруулах бодлого, орон сууцын буудлага 2 хоорондоо цуг явж байх ёстой. Энэ журмыг уг нь танай дээр хийвэл боломжтой гэж харж байгаа. Энийг шинэчлэх ажил хийж байгаа юу? Арилжааны банкнуудаасаа асууя. Ногоон зээлийн бодлогоор орон даяар утааг шийдэх боломжтой гэж харж байна. 57 дугаар тогтоолоос олон зүйлүүд бас ахиц байгаа болов уу гэж бодож байна. Гэхдээ цаашдаа Засгийн газар болон Монголбанкны зүгээс ямар бодлогын дэмжлэг хэрэгтэй байна вэ гэдгийг бодитой санал хэлж өгвөл их хэрэгтэй байна аа. Баярлалаа.

Б.Заяабал: Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга Даваасүрэн даргаас эхлээд явъя. 5 номерын микрофон. Маш тодорхой ч эсэхээсээ хариулт өгөөрэй.

С.Даваасүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

57 дугаар тогтоолыг гарсан даруйд бид нар холбогдох аймаг нийслэл агентлаг яамтай бол биелэлтийг тухай тухайн үед нь гаргаж өгөөрэй гээд бичиг явуулсан. Тэрнийхээ дагуу хойноос нь бид нар явж өнгөрсөн 11 сард нэг биелэлт гаргасан, оны эцэст гаргасан, 3 сарын байдлаар сая бас дахин бас хэрэгжилтийн явдлыг шахаж бид нар авч байгаа. Энэ дээр үзэхэд бол оны эцсийн байдлаар 50 хувь байсан. Сая 3 сар дээр тодорхой хэдэн ажлууд бол Их Хуралд өргөн барилаа гэсэн юу хийчихсэн. Ер нь бол бид бол байнга хойноос нь нэхээд явж байгаа. Энийг бол ямар ч байсан биелүүлэх үүрэгтэй гэдгийн үүднээс явж байгаа.

Монгол Улсын хэмжээнд хэзээ утаагүй болох вэ? Ямар ч байсан Улаанбаатар хотын хүрээнд бол бид бол 2030 оноор гэхэд бол утаагүй байя гэж. 2026-2028 оны хооронд бол 30 хувь нь хатуу түлш, 70 хувь нь газаар, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүч газ руу шилжье гэж байгаа. 2028-2030 онд 90 хувь нь сэргээгдэх болон бусад эх үүсвэр, 10 хувь нь хатуу түлшээр гэж яваад 2030 оноос хойш бол бүрэн одоо бид бол хатуу түлшнээс татгалзана гэдэг ийм төлөвлөгөө өгч байгаа. Яг аймаг дээр бол нарийвчлан гаргаагүй. Ер нь бол 2026-2030 он хүртэл төлөвлөгөө дээр бол аймгуудынхаа санал аваад ер нь ирж байгаа. Тэгээд бид энэ дээр ирээд эргээгээд танд тодорхой Үндэсний хороогоор төлөвлөгөө орно. Тэрүүгээр тодорхой хүрээнд хариу өгье өө.

Б.Заяабал: Дараагийн байгууллага гараа өргөөд. 4 номерын микрофон нээж өгье.

Д.Мөнхбаатар: Нийслэлийн. Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя.

Эхний асуулт буюу дахин төлөвлөх бүс, ногоон бүс, агаарын чанарын бүс энийг зургаар гаргаж өгнө үү гээд. Дахин төлөвлөх бүс бол нийслэл дээр бол тодорхой бол байгаа. Агаарын чанарыг сайжруулах журам буюу 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн НЗД болон Байгаль орчны сайдын хамтарсан тушаалаараа

ногоон бүсийг тогтоосон байгаа. Тэгэхээр энэ 2 маань бол нэг ойлголт гэж бол ойлгож болно. Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоолоор энэ ногоон бүсээсээ 51 мянган айл өрхийгөө бид нар эхний ээлждээ хий рүү шилжүүлэе гээд ингээд 100 ногоон бүс маань бол 103 мянган айл өрхийг бол хамарч байгаа. Энэ рүү нь ахиад ингээд Засгийн газрын тогтоолоор 51 мянган айлынхаа бүсийг бид нар тогтоосон. Бид нар одоо эхний ээлжийн байдалдаа бол энэ 51 мянгын бүс дотроо бол ажиллаж байна. Би танд зургийг бол одоо албан байдлаар бид нар хүргүүлэе. Мөн 2 дугаар асуултын дагуу дахин төлөвлөгөөнд орсон байх ёстой гээд энэ жагсаалтыг бол би танаас мэргэжлийн байгууллагаас нь албан ёсоор гаргаад НЗД-аас тань руу хүргүүлэе ээ.

Б.Заяабал: 3 номерын микрофон.

Б.Амгалан: Гишүүний асуултад хариулъя. 7 асуулт асуусан. Нэгд свопын талаар. 2021 оноос хойш Монголбанк банкнуудын гол улсаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр дээр 05-ын нэгж хувиар хөнгөлөлт үзүүлж байгаа. 2025 оноос хойш нэг хувийн хөнгөлөлт үзүүлж байгаа. Тэгээд нийтдээ 803 сая долларын эх үүсвэр бол татан төвлөрүүлсэн арилжааны банкны нөхцөлөөр. Тэгээд өнөөдрийн байдлаар 3 сарын байдлаар үлдэгдэл нь 650 сая долларын үлдэгдэлтэй байгаа.

5 сарын 18-ны Ерөнхийлөгчийн тушаалаар энэ хэрэглээний зээлд хамаарах ийм 3 хэсгийг бол хугацааг нь сунгаж өгсөн. Нэг нь бол энэ цахилгаан ус төрөгч бусад сэргээгдэх хүч эрчим хүчээр нь хосолсон ийм эх үүсвэрээр одоо ажиллаж байгаа. Авто тээврийг бол хэрэглээний зээлийн хугацааг 30 сар байсан бол 60 сар болгосон.

Хоёр дахь нь гэрээний гэрт зориулалттай нарны панелыг бол бас хэрэв худалдан авалтад зориулбал 30 сарыг 60 сар болгосон байгаа. Дараагийнх нь барилгын дулаалга.

Тэгэхээр энэ 3 бүтээгдэхүүн дээр бол одоо бодлогын арга хэмжээ авсан. Бид хэдийн үзэж байгаагаар бол энэ бодлогын арга хэмжээ авснаар өрхийн орлого дээр бол 40 хувийн дарамт үзүүлэх нь бол буурна, 40 хувиар буурна гэж үзэж байгаа юм.

Дараагийнх нь энэ таксономын 3.3.2-той холбоотой 58 тэрбумын задаргааг нь ногоон барилгын задаргааг хэлбэл 56.8 тэрбум нь ногоон барилга, 14.2 тэрбум ногоон барилгын материал болон бүтээгдэхүүн, 1.9 тэрбум нь ногоон дэд дэд бүтэц гээд. Дараагийнх нь энэ шийдэл та асуусан. Шийдэлтэй холбоотойгоор бол яах вэ Монголбанкны зүгээс энэ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа энэ татаастай хөтөлбөр дээр бас оролцоод явдаг энэ татаастай хөтөлбөр дээр бол манай яах Монголбанк ямар байр суурьтай байна вэ гэхээр ялангуяа энэ улсын төсвөөс гарч байгаа эх үүсвэрийг аль болох ийм өрсөлдөөнт зарчмаар арилжааны банкнуудад хуваарилбал энэ зээлийн хүү буурах боломжтой гэж үзэж байгаа учраас энэ саналуудыг бол холбогдох яамдуудад нь бол өгч байгаа.

Дараагийн 5 дахь асуулт моргейжийн хүүг ялгавартай тогтоох. Бид хэдийн үзэж байгаагаар яг энэ MRB буюу хяналт тайлагнал, энэ баталгаажуулалтын систем эхний ээлжид бүрдүүлсэн үед яг энэ зээлийн хүүг хугацааг бол ийм ялгавартай тогтооход илүү үр дүнтэй. Тэгээд тэр тусмаа Монголбанкнаас авч байгаа энэ арга хэмжээг ялангуяа энэ төсвөөс авч байгаа бодлоготой уялдуулж хийвэл илүү үр дүн нөлөөтэй гэж үзэж байгаа. Утааг бууруулах чиглэлээр моргейжийн зээлийг бол

нэмэлт, өөрчлөлт энэ журамдаа бол өөрчлөлт оруулж байгаа. Энэ бид хэдийн төсөөлж байгаагаар энэ жилийн хагаст бол шинэ журам маань үйлчлэх тийм төлөвлөгөөтэй байгаа. Гол зорилго маань бол яг энэ яндан бууруулж байгаа энэ одоо айл өрх энэ дүүрэгт бол хамааралтай зээл дээр яг энэ моргейжийн зээлийг аль болох түлхүү гаргая гэсэн тийм бодлоготой байгаа.

Дараагийнх нь сүүлийн асуулт энэ бодлогын арга хэмжээ гэж Монголбанкны зүгээс банкнууд дээр бол зөвхөн энэ зохистой харьцаа шалгуур үзүүлэлтийг нь тогтоох хянах ийм зорилгоор энэ шалгалт явуулдаг. Өөрөөр хэлбэл энэ байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлгээ энэ чиглэлээр бол ерөөсөө хяналт шалгалт явуулах ийм эрх зүйн орчин байдаггүй. Тийм учраас яг энэ сая өргөн барьсан өнгөрсөн 7 хоногт өргөн барьсан энэ Уур амьсгалыг өөрчлөх тухай хуулийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Учир нь энэ хуулийн төсөлд бол Монголбанк санал өгсөн. Энэ чиглэлээр байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлэх энэ чиглэлээр бол мандатыг нь Монголбанканд авах ийм санал байгаа.

Бодлогын сүүлийн асуултад хариулахад бол бодлогын дэмжлэг бол Монголбанкны зүгээс ийм саналтай байгаа.

Б.Заяабал: 2 номерын микрофон. ЖДҮ-ийн газрын дарга.

Я.Эрдэнэсайхан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. ЖДҮ-ийн газар Эрдэнэсайхан.

2025 оны 6 сарын 19-ний өдөр тогтоол батлагдсан. Энэ үед бол 2025 ондоо бид нар төсөл сонгон шалгаруулалтаа зарлаад сонгон шалгаруулалт дуусчихсан байсан. Тийм учраас өнгөрсөн жил бол энэ нь одоо зарлагдаагүй сонгогдоогүй гэсэн үг. Төсөлтэй холбоотой ЖДҮ үйлчилгээг дэмжих тухай хуулиар ААН-д зээл олгодог. Энэ тогтоолын төсөл дээр иргэн гээд орчихсон байгаа энийг бас залруулахгүй бол болохгүй байх. Хуулиас одоо давсан ийм даалгавар өгчихсөн байгаа. Энэ жилийн хувьд бол бид нар ер нь улсын төсөв дээр сүүлийн 2019 оноос хойшоо ерөөсөө 1 ч төгрөг тавиагүй. Өөрөөр хэлбэл улсын төсөв дээр мөнгө 2019 оноос тэг төгрөг. Бид өмнө нь олгогдож байсан зээлийнхээ эргэн төлөлтөөс төвлөрүүлээд 2026 оны хувьд бол одоо эргэн төлөлтөөс 34.9, орон нутгаас 7.2 гээд энэ жил 42 тэрбум төгрөгийг ЖДҮ эрхлэгчдэдээ олгоно. Ингэхдээ орон нутгийн санхүүжилттэй аймгуудаа дэмжих буюу аймаг нь дэмжиж байгаа аймгуудыг дэмжих бодлого барьж байгаа.

Тэгэхээр сайд, аймгийн Засаг дарга, ЖДҮ-ийн газрын даргын гуравласан тушаалаар тухайн жил аль салбар чиглэлийг дэмжих вэ гэдэг саналыг аймгийн санал дээр үндэслэж гэрээ байгуулдаг. Үүнийг үндэслэж сайдын тушаал гардаг. Тэгээд энэ жилийн хувьд бол хамгийн боломжтой аймаг нь салбар чиглэл бүгдийг нь одоо хамрах боломжтой нь Өмнөговь аймаг байгаа. Бусад аймгууд дээр бол гол төлөв ХАА-н гаралтай одоо түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох ийм үйлдвэрлэлийг дэмжих ийм саналуудыг аймгуудаас нь ирүүлсэн учраас төсөл сонгон шалгаруулалт зарлаад явж байна.

Өмнөговь, Говьсүмбэр 2 аймаг дээр сонгон шалгаруулалт нь дууссан. Энэ дээр бол 1.1 тэрбум төгрөгийн 6 төсөл бол шалгараад байгаа. Бусад аймгууд бол сон сонгон шалгаруулалт нь одоо явагдаж байгаа. Тийм учраас бол одоо тоо гарах боломжгүй байгаа. Ер нь бас одоо нэгэнт одоо Байнгын хороон дээр байгаа учраас энэ ЖДҮ-лэлийн сан дээр бас сүүлийн жилүүдэд төсөв мөнгө тавихгүй байгаа. Энэ

дээр тодорхой хэмжээнд төсөв тавьж өгөхгүй бол бид одоо ингээд олон Байнгын хороон дээр орохоор үйлдвэрлэл, үйлдвэрлэл, үйлдвэрлэлээ дэмжинэ гээд яриад байдаг. Гэсэн мөртөө төсөв дээр мөнгө тавьж өгдөггүй. Тэгээд ингээд баахан даалгаврууд өгчихдөг ийм бас зовлон бэрхшээл байгаа юм аа.

Тийм учраас ер нь бид ЖДҮ үйлчилгээг дэмжих тухай хуулийг 2019 онд батлуулж байхад тухайн үед судалж үзэхэд дэлхийн 40 улсаас 39 нь ЖДҮ-ээ дэмжих ийм тусгай санхүүгийн байгууллагатай тэр нь арилжааны банкнаас нэн хөнгөлөлттэй ийм зээл олгож байж үйлдвэрлэлийн салбараа босгож ирдэг ийм бүтэцтэй юм байна лээ. Гэтэл манайд энэ нь одоо байгуулагдсан нэг хэсэг алдаа оноотой явсан. Тэгээд одоо төсөв дээрээс санхүүжилт байхгүй. Ингээд эх үүсвэр нь хуулиараа бүрдүүлэх нь улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, эргэн төлөлт гээд ингээд заачихсан хязгаартай. Тэгэхээр хамгийн гол одоо эх үүсвэр нь шийдэгдэхгүйгээс болоод ингээд төсөв мөнгө бол үнэхээр хэцүү байгаа. Баярлалаа.

Б.Заяабал: Сангийн яам. Энэ микрофон хэдэн номер байна. Нэг номер дээр суучих уу? 1 номерын микрофоныг өгье. Нэг минут.

Ш.Бат-Эрдэнэ: Оройн мэнд хүргэе. Сангийн яам Бат-Эрдэнэ Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол 2025 оны 12 сарын 30-нд өргөн барьсан Татварын багц хуулийн шинэчлэлийн төсөлд бол таны ярьж байгаа зохицуулалт бол тусгагдсан гээд явж байсан. Тэгээд сая сүүлд бол Татварын хуулийг буцаан татаад 5 сарын 7-нд бол зөвхөн Татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг бол одоогийн одоо эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад эдийн засагт одоо нөлөөллөө шууд үзүүлж болох энэ зохицуулалт дээр нь эхний ээлжид нэмэлт, өөрчлөлтүүдээ оруулах нь зүйтэй гэж үзээд одоо яах вэ ингээд оруулсан байгаа. Яах вэ энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр бол одоо яригдаж байгаа энэ зохицуулалт бол тусгагдаагүй явж байгаа.

Энэ дашрамд одоо мэдээлэл өгөх юм бол яг татварын хөнгөлөлт чиглэл чөлөөлөлттэй холбоотой өнгөрсөн оны гүйцэтгэлээр бол нийтдээ 582 ААН иргэнд бол нийт 28 тэрбум төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлтийг бол эдлүүлсэн байгаа. Энэ бол илүү нөгөө байгаль орчинд ээлтэй тэгээд нүүрстөрөгч.

Б.Заяабал: Нэг минут нэмж өгье. Нэг номер дээр.

Ш.Бат-Эрдэнэ: Нүүрс төрөгчийн одоо бага ялгарлыг дэмжсэн одоо сэргээгдэх эрчим хүчийг одоо дэмжсэн ийм татварын бодлогын хүрээнд бол дээрх хөнгөлөлт чөлөөлөлтийг бол эдлүүлсэн. Дээр нь бол Сангийн яам бол энэ татаастай зээлүүд дээр бас энэ ногоон зээлийг дэмжсэн бодлогуудыг бол ингээд шигтгээд явдаг. Тухайлах юм бол энэ атар сүүлд хэрэгжиж байгаа Атар болон Хүнсний хувьсгал, Цагаан алт гэдэг хөтөлбөрүүд дээр бол ногоон зээл авах юм бол банкнууд нэг хувиар арай бага хэмжээгээр одоо харилцагчид бол хүү санал болгодог энэ нөхцөлийг бол ерөнхий гэрээн дээр нь бол тусгаад өгчихсөн ингээд явж байгаа. Баярлалаа.

Б.Заяабал: Хот байгуулалтын яамнаас байна уу? Хүн орж ирсэн үү? Галсанбат манай байнгын хорооны ажлын албаныхан энэ орж ирж байгаа ажлын хэсгийнхэн дээр анхаарал тавиарай. Байгаль орчны яам байна уу? Байгаль орчны

яам байна уу? Байгаль орчны яамных нь хүмүүс байхгүй байна шүү дээ. Энэ чинь маш чухал асуудал яригдаж байгаа чухал асуулга. Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол.

Дээрээс нь энэ тогтоолын хэрэгжилт нь 50 хувьтай байна гэж байна. Өвөл болдгоороо л болно. Тэгээд хариуцаж байгаа 2 бодлогын яамдаас нь ингээд хүмүүс ирдэггүй. Тэр 2 яам руу нь бас бичиг явуулаарай Галсанбат. Нэмж асуух уу? Нэмэлт нэг минут Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Тодорхой хариулсанд баярлалаа. Тэгээд Байгаль орчны яам, Хот байгуулалтын яам, ЗГХЭГ чуулган үзээд сууж байгаа байлгүй. Бичгээр хариугаа ирүүлэх хэрэгтэй. Тэгээд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2030 он гэхэд Улаанбаатар бол утаагүй болно гэж байгаа юм байна шүү дээ тиймээ? Тэр төлөвлөгөөгөө бичгээр та бүхэн маань хүргүүлнэ үү. Энэнтэй танилцаад бас зөв байна уу буруу байна уу энийг нэг харах хэрэгтэй байгаа. Ялангуяа газар шийдье гэж байгаа тийм шийдэл бас байгаа. Энэ бол гэхдээ шатаад л дуусна. Газар дээрээ татаас өгөөд байх юм бол дахиад л үргүй зардал болох учраас бид нар дулаалга болон сэргээгдэх эрчим хүчнийхээ бодлогыг түлхүү явуулаад өгөх ёстой. Тэгээд гол нь Үндэсний хороон дээрээ энэ бүх аймаг орон нутаг, нийслэлийн бүх ажлууд, яамдуудын ажлууд ингээд уягдаад явж байх ёстой гэж би харж байгаа.

Тэгэхээр тийм том хэмжээний дүр дүр зургаар нь харсан зүйл бол хэрэгтэй болов уу гэж бодож байна. ЖДҮ-ийн газраас бас тодорхой хариулсанд баярлалаа. Тэгэхээр энэ жилдээ бол хэдэн төсөл бол шалгарч магадгүй юм шиг байна тиймээ? Сонгон шалгаруулалт хийж байгаа. Хариу нь гарахаар хүргэхийг хүсье.

Б.Заяабал: Арилжааны банкнууд хариулаагүй юу тиймээ? Арилжааны банкнууд нэмээд мөн саяын дарааллаар хариулаад явчихъя. Хаан банкнаас эхлээд. Хаан банк, ХХБ 2 зэрэгцээд суучих уу? 1, 2 дугаар микрофон дээр. Нэг номерын микрофоныг нэг минутаар нээж өгье, товчхон хариулаарай.

Б.Болортуяа: Ер нь ямар дэмжлэг туслалцаа хэрэгтэй вэ гэдэг асуулт хэлсэн. Ямар ч байсан сүүлийн үед бол Монголбанк маань ямар ч байсан тодорхой нөгөө нэг ногоон зээл дээр, ногоон санхүүжилтээр өөрчлөлтүүд хийгээд зохицуулалтын өөрчлөлтүүдээ хийгээд нэлээн нааштай болж байгаа. Энэ дээр яг манай зүгээс бол товчхон ярихад бол ямар дэмжлэг хэрэгтэй байна вэ гэхээр мэдээж нөгөө ногоон зээл маань ногоон гэдгээ баталгаажуулах шаардлагатай байдаг.

Тэгэхээр энэ чинь нөгөө нэг нэмэлт ажил хийгдэж байгаа. Тэгэхээр мэргэжлийн байгууллагууд хэрэгтэй байдаг. Энэ яг төсөл нь энэ тоног төхөөрөмж нь ногоон юм гэдгийг магадгүй одоо усны газар нь юм уу, байгаль орчны яам нь юм уу тийм нөгөө нэг баталгаажуулалт хийдэг мэргэжлийн байгууллага хүмүүсийн дүгнэлтүүд бид нарт хэрэгтэй байдаг.

Тэгэхээр тэр хэсэг дээр бас нөгөө холбоотой маш олон яамдууд оролцож байгаа. Мэдээж нөгөө ногоон таксаномын хүрээнд маш олон чиглэлийн үйл ажиллагаа байгаа. Тэгэхээр тийм АЖС ч юм уу агентууд тийм байгууллагуудыг нэлээн олноор байгуулж өгвөл.

Б.Заяабал: Баярлалаа 2 номерын микрофон. Бас нэг минутаар нээж өгье.

Д.Нямсүрэн: Давхцуулахгүйн үүднээс нэг ганц хоёрхон санал дээр хэлье. Ерөнхийдөө ногоон зээлийн нөхцөл байдал хүмүүс аягүй хямд байх ёстой гэдэг ойлголттой байдаг. Ногоон зээлийн эх үүсвэр бид нар гаднаас татан төвлөрүүлсэн зээлээр одоо эх үүсвэрээрээ зээлээ олгодог. Зээл гаднаас эх үүсвэр татахад 8.5 орчим дээр буудаг. Дээд тал нь 11 хувьтай байгаа энэ дээр свопын зардал одоо 8.3-тай байна өнөөдрийн байдлаар ногоон зээл бол нэг хувь хасагдана. Тэгэхээр энэ ер нь нэг 15.4, 15.5 орчим дээр эх үүсвэрийн зардал бууж ирж байгаа тэгээд энэ дээр ашгаа нэмэгдээгүй байгаа. Дээрээс нь одоо юу гэдэг юм банкны эх үүсвэр татаж байгаа зардлууд нэмэгдээгүй байгаа гэх мэтчилэн. Тэгээд харилцагч дээр очиж байгаа хүү өндөр очдог. Дулаалга эрчим хүчний хэмнэлттэй нэг байшин барилга байшин дээр ирэхээр ихэнхдээ гэр хорооллын айлууд байдаг. Гэр хорооллын айлуудын өр, орлогын харьцаа ханга хлалтдаа хүрдэггүйн улмаас энэ зээлд хамрагдаж чаддаггүй.

Дээрээс нь энэ хүү нь өндөр байгаад байдаг даа. Тийм учраас энэ татаастай зээлүүд дээрээ яг энэ сэргээгдэх эрчим хүч, дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, халаагуур зэрэг дээрээ.

Б.Заяабал: 2 номерыг нэг минут нэмчихье. Дараа нь Хас банкны захирал нэг номер дээр суучхаарай.

Д.Нямсүрэн: Тэгээд ерөнхийдөө энэ татаасын хэмжээтэй энэ зээлүүд дээрээ Байгаль орчны яамнаас хэрэгжүүлж байгаа зээлүүд дээрээ нэмчих юм бол бусад нэмж банкууд орох боломжтой. Дээрээс нь олон харилцагч хамрагдах боломжтой.

Хоёр дахь санал юу вэ гэхээр гэр хорооллын айлууд ихэнхдээ зээлд хамрагдах учраас гэр хорооллын энэ айлуудын газрыг гэрчилгээжүүлэх юм бол харилцагчид маань одоо юу гэдэг юм энийгээ барьцаалах боломж бүрдэнэ тэгж байж нөгөө зээлийн одоо банкны шалгуурыг хангана гэсэн санал бол ХХБ-аас тавьж байгаа.

Гурав дахь асуудал бол ерөөсөө мэдлэг мэдээллийн асуудал. Хүмүүс ерөөсөө одоо юу гэдэг юм энэ одоо энэ тогтоолын 17 дугаар заалт дээр байна шүү дээ Боловсролын яам, боловсролын байгууллагуудад мэдээлэл хүргэх энэ бол маш чухал. Цэцэрлэгийн наснаасаа авхуулаад одоо энэ их сургууль хүртэлх энэ мэдээллийг заавал хүргэх ёстой тэрэн дээр бол банкууд өөрсдөө ингээд мэдлэг мэдээллээ түгээгээд ажиллаж байгаа. Энэ дээр маш их зардал хүний нөөц гардаг.

Тийм учраас энэ дээр нь бас хамтраад ажиллах одоо санал дэвшүүлж байна.

Б.Заяабал: Баярлалаа. Нэг номерын микрофоныг нэг минутаар нээж өгье. Төрийн банк 2 номер дээр суучхаарай.

Г.Туул: Баярлалаа. Би өмнөх банкны хүмүүсийнхээ ярьсан дээр давхцуулахгүйгээр бас санаагаа нэмчихье. Ерөнхийдөө бид нар яг ААН-ийнхээ хувьд хувийн байгууллагынхаа хувьд юу хийж чадах вэ гээд нэлээн бас судалгаанууд хийдэг. Тэгээд та бүхний мэдэж байгаачлан татвар ноогдох орлогын 1 хувиар хэрвээ ААН бас тодорхой яг ийм ийм ажлыг хийх юм бол татвараас чөлөөлөгдөнө өө гээд уул нь бол хууль нь байгаад байдаг. Гэтэл энийг бол яг

хэрэгжүүлээд авчихсан тийм байгууллага өнөөдрийн байдлаар нэг ч байхгүй байгаад байна. Тэгээд бид нар одоо энүүгээр бол бас банкны хувьд бол татвар ногдох орлого гээд ингээд үзэхээр жилдээ бол бас хөөрхөн мөнгөөр бид нар бас ажил хийчхэж болохоор байгаа байхгүй юу. Ялангуяа гэр хороололд орлого багатай иргэдэд зориулсан ийм ажлуудыг хийе олон санаачилгыг биднүүд одоо ингээд жагсаачихсан хийх ийм хүсэлтэй байдаг. Гэтэл яг амьдрал бодит амьдрал дээр яваад ирэхээр энэ огт хэрэгжихгүй байна. Тэгэхээр хэрвээ энийгээ үнэхээр бас тодорхой болгоод хэрэгждэг болгоод ингэх юм бол банкнуудын хувьд ер нь.

Б.Заяабал: Нэг минут нэг номер дээр нэмээд өгчихье.

Г.Туул: Тэгэхээр энийг тодорхой болгоод үнэхээр яг хийсэн ААН-үүд нь энэ нэг хувиа авч одоо татвараас чөлөөлүүлж чаддаг ийм болгох юм бол бид бид нарт бас одоо хийе гэсэн санаачлах ажил маш их потенциал байна гэж ингэж харж байгаа. Тэгээд дээрээс нь яг бизнес модель гэдэг бол маш чухал байдаг л даа. Ялангуяа банкны хувьд бол бид нар хэрвээ ийм орлого багатай олон айл өрхүүдтэй одоо зээл гаргахын оронд Монголд ерөөсөө хамгийн гол хэрэгцээтэй үйлчилгээ буюу тэр эско үйлчилгээ гаргаж ирмээр байгаад байгаа байхгүй юу. Хэрвээ эско үнэхээр байгаад энэ айлуудад яг тэр халаагуурыг нь хийгээд нийлүүлээд ингээд чадах юм бол банкны хувьд бол зөвхөн одоо бизнесийн ногоон зээл буюу эскод нь зээл өгөөд цаашаа одоо цааш тэр айл өрхүүдтэй яг эско нь харьцаад явдаг ийм бизнесийн моделиуд маш сайн хэрэгжих боломжтой. Бизнесийн моделиудыг хэрвээ хэрэгжүүлэх юм бол илүү одоо олон айл өрхүүдэд маш бодитойгоор хүрэх боломж бий гэж харж байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. 2 номерын микрофоныг нэг минутаар нээж өгье.

А.Энх-Эрдэнэ: Төрийн банкнаас санал хэлье. Хамгийн түрүүнд дулаалгыг хэрэгжүүлэхийн тулд утаагүй болгохын тулд бид нарт платформ хэрэгтэй байгаа. Дулаан шийдэл төслийн хүрээнд бол одоогийн зарчмаар бол зөвхөн утсаар яриад захиалга өгөөд явдаг. Энийг платформ байдлаар шийдвэрлэж чадах юм бол мэргэжлийн оролцогч байгууллагууд болон банкны санхүүжилт харилцагч өөрөө шууд утсаараа л бүх асуудлаа шийдчих боломжтой. Ийм платформ үүсгэж чадвал бид нар дулаалгыг маш хурдтай мөн тайлагнахад хялбар болох ийм асуудал үүсэж байгаа.

Дараагийн нэг хэсэг нь бол эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд ОУБ-ын санхүүжилтийн хүү өөрөө своп зардал хийхээр өндөр болчхож байгаа. Тэгэхээр энэ дээр төрийн болон ОУБ банкны санхүүжилтийн байдлаар холимог санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлбэл бол илүү үр дүнтэй санагдаж байна аа. Мөн одоо хэрэгжүүлж байгаа төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн зээлийн хүү дээр ногоон байх юм бол 2 хувь зөрөөтэй байдаг. Энгийн зээлтэй 6, 8 гэдэг ч юм уу тэрний хүүгийн зөрөөг.

Б.Заяабал: 2 номерын микрофон нэг минутаар сунгая.

А.Энх-Эрдэнэ: Хүүгийн зөрөөг нь нэмэгдүүлбэл илүү ногооныг авахыг хичээнэ, шаардлагуудаа илүү хангуулна. Ингэснээрээ ногоон зээлийн энэ тогтолцоо маань өөрөө илүү уян хатан болох ийм боломжтой гэж үзэж байна аа.

Б.Заяабал: Боловсролын яам байхгүй байх тийм үү? Сая дуудахад байсан уу? Боловсролын яамнаас Тамираа байсан даа. Тийм Боловсролын яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Тамираа. Нэг номер дээр суучих уу? Нэг номерын микрофоныг нээе.

Х.Тамираа: Боловсролын яамны хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Тамираа гишүүний асуултад хариулъя.

Их Хурлын тогтоол дээр бол яг боловсролын салбартай холбоотой 2 үндсэн заалт бол хэрэгжсэн байгаа. Яг саяын асуултад бол тухайлсан асуулт манай яамтай холбоотой гараагүй. Тэгэхээр тогтоолтой холбоотой хийгдэж байгаа ажлын талаар товчхон мэдээлэл өгье өө. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургууль цэцэрлэгүүдээр бид нарт нийт яг одоо уурын зуухтай буюу энэ ногоон санхүүжилт хэрэгцээтэй байгаа 114 сургууль 227 цэцэрлэг байна. Үүнээс нийслэлд бол 38 байгаа. Тэгэхээр нийслэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бид нар үе шаттайгаар эдгээр сургууль, цэцэрлэгүүдийн барилгыг одоо эрчим хүчний хэмнэлттэй болгох ажлыг бол хийгээд явж байгаа. Тэгээд цаашид ер нь бид нар сайжруулах дулаан алдагдал багатай болгох ийм сургууль цэцэрлэгийн бай барилгуудыг бол нэмж барих хэрэгцээ шаардлага бол бас байгаад байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. Одоо асуулгын хариутай холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдийн нэр авъя. Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Очирбат гишүүнээр нэр тасалъя. Соронзонболд гишүүнээр эхэлье. Соронзонболд гишүүний микрофон өгье.

Л.Соронзонболд: Энэ тогтоол дээр энэ төрийн өмчит болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг төлөвлөхдөө ногоон барилгын шалгуур бест гэр гэж байгаа юм. Гэрчилгээний В болон түүнээс дээш үнэлгээтэй 50-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэй байх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гээд. Одоо ингээд энэ Боловсролын яам ч бай, ЭМЯ ч бай ингээд ер нь бол маш их улсын төсөв дээр ч тэр АХБ-ны төслөөр ч олон сургуулийн цэцэрлэгийн барилгууд байгууламжуудыг бариулж байгаа. Тэгэхээр одоо эдгээр барилга байгууламжуудынхаа төлөвлөгөө төсөв дээрээ энэ бест гэр гээд ангилал стандартаараа ямар ангиллын байна вэ гэдгийгээ ингээд тусгадаг болох тал дээр анхаарахгүй болохоор ингээд тайлангууд ирэхдээ бол ямар ч байсан тодорхой хэмжээнд эрчим хүчний хэмнэлттэй эрчим хүчний хэмнэлтийн С болон түүнээс дээш гэрчилгээтэй эд нар гээд ингээд тайлан ирүүлж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарын нөгөө шаардаад байгаа нь болохоор Бест гэр гэдэг стандартаар асуугаад байдаг. Хариулт нь болохоор арай өөр тайлбартай ирээд байдаг.

Тэгэхээр цаашдаа бол ялангуяа энэ тайлан мэдээлэл энэ гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ энэ Бест гэр гэдэг стандартаар бол энэ ямар одоо стандарт ангилалд хамрагдаж байгаа юм бэ гэдэг талаар мэдээлэл ирүүлэх дээр нэлээн сайн анхаармаар байна гэж бодож байгаа. Тэгэхээр энэ дээр бас Байнгын хорооны зүгээс нэлээн анхаармаар юм болов уу гэж бодож байгаа юм.

Дараагаар нь болохоор бол энэ Монгол гэрийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын стандартыг шинээр боловсруулж батлуулъя гээд. Энэ дээр одоо яг тодорхой эзнийг нь бол заагаагүй. Яах вэ СХЗГ-аас бол энэ чиглэлээр бол хийж

байгаа ажил бол байхгүй байна гэсэн ийм мэдээлэл ирсэн байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр бас яг хариуц эзнийг нь тодорхой болгох ажлыг бол зохион байгуулах нь зүйтэй юм болов уу гэсэн ийм 2 юм байна.

Дээрээс нь болохоор бол энэ 11 дээр болохоор бол энэ ногоон барилгын шалгуур бест гэр гэрчилгээ 70-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлтийг нотлох тохирлын гэрчилгээтэй дулаалгын ажил гүйцэтгэсэн гэж байгаа юм. Ажил гүйцэтгэсэн иргэнд ХХОАТ-ын хөнгөлөлт эдлүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулна гээд. Өөрөөр хэлбэл энэ одоо Бест гэр стандартаар одоо яг ингээд дулаалгын ажлыг ингээд хийж чаддаг ийм хувийн бизнес энэ салбарыг дэмжих утгаар нь энэ ХХОАТ-ын асуудлыг тусгасан юм болов уу гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чиглэлийн ажлууд маань нэлээн орхигдсон байна уу даа гэж хараад байгаа. Энэ бест гэр стандартаар одоо ажил хийж чаддаг хувийн хэчнээн компани байгаа юм бэ?

Дараагаар нь болохоор энэ хийсэн ажлыг нь үнэлдэг тэр аудитууд нь хэд байгаа юм бэ гэдгийг энэ мэдээллүүдээс бас нэлээн боловсронгуй болгох шаардлага байна. Тэгээд тэр МСҮТ-үүд их, дээд сургуулиудтай хамтрах тал дээр л бас анхаарах ёстой байна гэж бол энэ одоо ногоон санхүүжилтийн ажлын хэсэгт ажиллаж байсан гишүүний хувьд бол нэг иймэрхүү саналууд хэлмээр байна.

Б.Заяабал: Одоо Лувсанжамц гишүүн сүүлд дэгийн дагуу сүүлд хэлэх учраас Очирбат гишүүний микрофоныг өгье өө. Очирбат гишүүн.

Г.Очирбат: Тэгээд Их Хурлын 57 дугаар тогтоолын асуулгын бас хариултууд ирсэн байна. Мэдээллийг түрүүн бас сонслоо. Арилжааны банкнууд маань нэлээн сайн ажиллаж байгаа юм байна. Харилцаа холбоо нэлээн сайжирчихсан юм байна. Монголбанк ч гэсэн нэлээн дүрэм журмаа өөрчлөөд дорвитой ажиллаж байна гэж харж байна. Тэгэхдээ ер нь цаашдаа бид нар илүү энэ тогтоолын хэрэгжилтийг 50 хувь биш 80, 90, 100 хувийг хэрэгжүүлэх шаардлагатай байгаад байгаа. Одоо ерөнхийдөө бол та хэд мэдэж л байгаа. Одоо ингээд зун болчихоор нөгөө утаагаа мартчихдаг. Хөрсний бохирдлоо мартчихдаг. Асуудлууд үүсдэг. Тэгэхээр уялдаа холбоогоо улам сайжруулаад бид нар бас Байнгын хороон дээр бас та хэдийг бодлогоор өшөө дэмжиж ажиллана гэж бодож байгаа.

Тэгэхээр Монголбанк, арилжааны банк дээрээс нь ЖДҮ-лэл үндэсний хороодууд нэлээн ажлаа идэвхжүүлээрэй гэж хүсье. 50 хувь гэдэг бол хангалттай тоо гэж би зүгээр хувьдаа бодохгүй байна. Цаашдаа илүү сайжруулахгүй бол тэгээд болохгүй 1 дүгээрт.

Хоёрдугаарт гэх юм бол хоттой холбоотой бас нэлээн манай Байнгын хороон дээрээ ч гэсэн энэнтэй бас нэлээн уулзалтууд хийх ёстой гэж бодож байгаа. Нийслэл хот өөрөө бие даасан шийдвэрүүд гаргаж яваад байдаг. Тэгээд үр дүн нь ямар байдаг вэ гэхээр нэг хэдэн сарын насжилттай ажил хийгээд л тэрүүгээрээ ажил хийсэн юм шиг зүгээр нийгэмд харагдаад байгаа. Яг бодитойгоор энэ Их Хурлын тогтоолоо ажил болгоод цаашаа нийслэл маань ч гэсэн ингээд явах ёстой шүү. Түрүү жил гэхэд та хэд нь бид хэд бүгдээрээ л мэдэж байгаа. Зөвхөн утаан дээр гэхэд коксожсон нүүрс авна гээд 226 тэрбум төгрөг гаргаад явуулсан. Яах вэ мэдээж өвлийн улиралд утааны тодорхой хувиар буурсан уу буурсан. Тэгэхдээ эргээгээд тэр 226 тэрбум төгрөг чинь илүү нэмүү өртөг шингээсэн сэргээгдэх эрчим хүч рүү орсон. Нөгөөдөх нь иргэддээ болон одоо нийгэмд үр дүн гаргасан ийм юмнууд руу

чиглэж улсын бодлого нийслэлийн бодлого цаашаа яваад арилжааны банк, Монголбанк, арилжааны банкаараа дамжуулаад хувийн хэвшлээ дэмжээд үр дүнг нь иргэд нь хүртдэг энэ гинжин урвалуудаа хаа хаанаа авч байвал зүгээр шүү дээ. Тэгээд та бүхэндээ ажлын амжилт хүсье. 50 хувь гэдэг бол хангалтгүй.

Дараа жил илүү эрчимжүүлэх хэрэгтэй, илүү сайжруулах хэрэгтэй. Арилжааны банкнууддаа маш их баярлаж байна. Та хэд маань их зүтгэж байгаа. Түрүүн тэгээд саналуудыг бас зөндөө сонслоо. Ялангуяа тэр орлогын албан татварын нэг хувьтай холбоотой асуудал дээр ч гэсэн бид нар цаашдаа өшөө бас та хэдийнхээ дуу хоолойг сонсож хаашаа илүү захиран зарцуулж болох эрхийг нь нээж өгөх чиглэл рүү бас шийдвэрүүд гаргавал их зөв зохистой болох юм байна гэж харж байна. Тэгээд бүгдэд нь ажлын амжилт хүсье. Баярлалаа.

Б.Заяабал: Энхцэцэг гишүүний микрофоныг нээе.

М.Энхцэцэг: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Ингээд танилцуулга хийсэн хүмүүстээ баярлалаа. Ингээд агаарын бохирдлыг бууруулахад одоо маш их хэмжээгээр нөлөө үзүүлэх ийм одоо түүхэн тогтоолыг бол Лувсанжамц гишүүн маань бас ахлаад ингээд баталсан. Тэгээд яагаад одоо түүхэн тогтоол вэ гээд тэгж байгаа гэхээр мэдээж энэ одоо тогтоол дээр байгаа заалтууд маань бүрэн утгаараа хэрэгжих юм бол агаарын одоо бохирдол маань том хэмжээгээр одоо буурна.

Дээрээс нь хамгийн гол нь олон айл өрхүүдийн амьдралын чанар одоо сайжрах ийм одоо чиглэл рүү явах юм байгаа юм аа. Тэгээд яах вэ тодорхой хэмжээгээр бас ажлууд хийгдсэн юм байна гэж ингэж харагдаж байна. Гэхдээ бас л одоо энэ хангалтгүй байна. 50 хувь гэдэг бол одоо энэ чинь яг ингээд жилийнхээ ойн дээр очиж байгаа энэ одоо тогтоол батлагдаад. Тэгэхээр бас энэ тогтоолын хэрэгжилт дээр бас онцгойлон анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна аа.

Ялангуяа одоо айл өрхүүдийн. Ер нь ингээд бид нар бас нэг ийм нөлөөллийн ажлыг маш сайн хийх ёстой юм байна лээ. Одоо ер нь хүн болгон л манай нэг нийтлэг хандлага бол юу вэ гэхээр өөрсдөө л ерөөсөө нэг ийм байшингаа барьчихдаг. Хэдэн одоо банз хадаас байх юм бол нэг ингээд стандартын шаардлага хангахгүй банз барьчихдаг. Тэгээд ашиглалтын зардал бол асар их хэмжээний одоо дулаан алдагдалтай. Тэгэхээр бид нар ингээд нөлөөллийн ажил буюу өөрөөр хэлбэл одоо стандартын дагуу, зургийн дагуу, мэргэжлийн байгууллагаар хийх юм бол та одоо та нар минь ингээд ашиглалтын зардал ийм одоо бага байх юм гэдэг юмыг л ингэж хүмүүсийн тархинд ойлгуулах ажлыг сайн хийх ёстой юм байна гэж л би ингээд ажигласан.

Хоёрдугаар зүйл нь болохоор Стандарт ерөөсөө бид нарт ингээд стандарт байхгүй юм байна. Ядаж л одоо тэр айлуудын барилга байшингуудыг одоо барих нэг төрлийн стандарт нэг маягийн зургууд дулаан алдагдалтай барих тийм юмнууд ер нь их ховор юм байна гэж ингэж ажигласан. Мөн тэр одоо дулаалгын материал бас их ховор байдаг юм байна. Тэрэн дээр бас стандартууд бас их ховор байдаг юм байна гэж ингэж нэлээн ажигласан. Тэгээд одоо бид нар сүүлийн үед бол ялангуяа миний хувьд бол сэргээгдэх эрчим хүч ашиглаад айл өрхүүд маань зуух

яндангаасаа салах бүрэн боломжтой байна. Эрчим хүчээ хэмнэх боломжтой байна. Амьдралынхаа чанарыг одоо сайжруулах боломж байна.

Дээрээс нь хамгийн гол чухал юм нь илүүдэл цахилгаанаа сүлжээнд нийлүүлээд орлого олох боломжтой байна. 10квт-ын одоо нарны панел суурилуулсан айл сардаа бол 400 гаран мянган төгрөг, жилдээ одоо 5 сая төгрөг, 20квт-ын нарны панелтай айл бол сардаа сая гаран төгрөг жилдээ 10 сая төгрөгийн нэмэлт орлого олох гээд байна аа.

Дээрээс нь тэр одоо нүүрс түлээндээ зарцуулдаг мөнгө, тэр эм тариандаа зарцуулдаг ийм асар их хэмжээний юмнуудыг хэмнэнэ ээ. Тэгэхээр энэ юм маань биеллээ олохын тулд бол хамгийн 1 дүгээрт ерөөсөө л дулаалга юм байна лээ. Бид бүхэн мэднэ. Одоо тэвний чинээ нүхээр тэмээн чинээ жавар орно л гэдэг. Хэрвээ тэгээд л дулаалгаа сайн хийж чадахгүй бол ямар ч технологи ажиллахгүй. Тэнд бүүр алт эрдэнэ байгаад ч гэсэн ажиллахгүй юм байна лээ. Тэгээд л нөгөө зуух, яндантайгаа зууралдах юм байна лээ. Тэгэхээр бид нар ингээд хүмүүсийн жаахан ийм уламжлалт хэрэглээг нь байхгүй болгохын тулд маш их хэмжээний нөлөөллийн ажлыг хийж байж л хүмүүс ингээд тийм байна байшингаа барьсан ч гэсэн 5 сая төгрөгөөр барих байшингаа нэг одоо юу гэдэг юм 7 сая төгрөг зарцуулах юм бол тэр дулаан алдалтаа барих юм байна гэдэг ийм нөлөөллийн юмыг бол маш сайн хийх ёстой юм байна аа. Стандартаа боловсруулаад, гарын авлагаа боловсруулаад тэгээд ард иргэдэд маш их хэмжээний одоо зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллах л юм бол хамтдаа хэдүүлээ энэ нэг сайхан одоо технологийг хэрэглээд агаарын бохирдлоосоо салж чадах юм байна лээ л гэж ингэж хар ж байгаа.

Тэгээд Лувсанжамц гишүүндээ бас одоо дэмжиж ажиллаж байгаа Засгийн газрын одоо сайдууд энэ яамдуудаа бас банкнууддаа талархъя. Энэ одоо ажил дээр бол Лувсанжамц гишүүн бол үнэхээр одоо манлайлж тэргүүлж ажиллаж чадаж байгаа. Тэгэхээр энэ хүний манлайллыг бид нар бас бүрэн утгаараа сайхан ашиглаж хэдүүлээ хамтдаа энэ хөгжлийн төлөө явъя гэж ингэж хэлмээр байна гээд анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Заяабал: Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3.4-д заасны дагуу Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга болон Монголбанкны Ерөнхийлөгчид асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц таныг асуулгын хариутай холбогдуулан үг хэлэхийг урьж байна аа. Гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Та бүхэндээ баярлалаа.

Дэлгэрэнгүй асуултууд дээр дэлгэрэнгүй хариуллаа. Боловсролын яаманд бас баярлалаа. Ажлуудаа хийгээд явж байгаа юм байна тийм ээ. Сургууль, цэцэрлэг энэ төрийн үйлчилгээний барилгууд дээр урсгал зардал нь 70, 80 хувьтай болчихдог. Тэгээд л нүүрсээ түлээд л сууж байдаг гэсэн ийм нөхцөл байдал зөвхөн Улаанбаатар гэлтгүй орон нутагт илүү маш олон байгаа. Тэгэхээр бид нар орон даяараа энэ төрийн үйлчилгээний байгууллагуудын урсгал зардлыг хэмнэх буюу дулаалга сэргээгдэх эрчим хүчийг хамтад нь хэрэгжүүлээд явах ёстой гэсэн байр суурьтай байна аа. 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг энэ жил асуулаа. Ирэх жил дахиад асууна. Та бүхэн маань бэлэн байгаарай. Нэхэл хатуу ажиллана аа.

Дээрээс нь нэмээд өнгөрсөн жил 12 сард баталсан Их Хурлын 119 дүгээр тогтоол байгаа. Энхцэцэг гишүүнтэй цуг хамт ажиллаад явсан. Энэ тогтоолын төслийн хэрэгжилтийг бас асууна аа ирэх жил. Тэгэхээр та бүхэн маань энэ тогтоолын төслүүдийн хэрэгжилтийг ямар байгааг нь холбогдох байгууллагуудаас нь мэдээлэл авахаас гадна хоорондоо уулзаж ярилцмаар байна. Төрийн байгууллагууд хоорондоо уялдаатай ойлголцоод ажиллах юм бол төсвийн хязгаарлагдмал хөрөнгөөр бид нар маш олон үр дүнг авчрах боломжтой, зорилго зорилтуудаа биелүүлэх боломжтой.

Тэгэхээр энэ ажил дээр анхаарч өгөөсэй гэж хүсэж байна. Дулаалга сэргээгдэх эрчим хүч энэ утааг шийдэхтэй холбоотой Дулаанбаатар аяныг хэрэгжүүлээд өнгөрсөн жилээс 7 хоног болгоны хагас сайн өдөр болгон хороодуудаар тойроод явж байгаа. Иргэдэд дулаалгын мэдээллийг өгөөд явж байгаа. Хаан банк нэг удаа ирсэн. Бусад банкнаас бол нэг ч удаа оролцоогүй байгаад бол би бага зэрэг харамсалтай байгаа. Хамтдаа хэдүүлээ яваад ногоон зээлийн ийм бүтээгдэхүүн байдаг юм байна аа. Одоо Монголбанкны журам шинэчлэгдсэн юм байна аа. Тэгэхээр иргэд ээ, дулаалга, сэргээгдэх эрчим хүч дээр зээл авах нөхцөл бол хангагдаж байгаа юм биш үү гэсэн ийм мэдээллийг хамтдаа хүргээд явах юм бол илүү олон хүнд хүрэх боломжтой болов уу гэж бодож байна. Монгол Улсын бараг бүх хүнд манай арилжааны банкнууд маань хүрч чадна шүү дээ.

Тэгэхээр энэ зүйл дээр хамтарч ажиллах саналтай байна аа. Тэгэхээр арилжааны банкнууд маань бас бодож бодолцож үзээсэй гэж бодож байна.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо бас адилхан шүү. Ялангуяа орон нутаг дээр би одоогийн байдлаар хүрч чадахгүй байгаа. Зөвхөн нийслэлийн төвийн 6 дүүрэг, Налайх дээр л ажиллах боломжтой боломжтой байсан. Тэгэхлээр энэ дээр бас хэдүүлээ хамтраад ажиллая гэж бодож байна. Нийслэлийн зүгээс бас энэ жил ирэх жил дулаалгын төслүүд дээр илүү бодлогоор дэмжлэг үзүүлээд явна гэдэг дээр бол найдлагатай байгаа.

Арилжааны банкнууд маань зөв зохистой бодлогын дэмжлэг хэрэгтэй гэсэн зүйлүүд хэлж байна аа? Баярлалаа бас миний санаанд орохооргүй тийм зүйлүүд бол санаачилгууд хэлж байна. Ногоон гэсэн гэрчилгээг олгох.

Дээрээс нь нэмээд Эско үйлчилгээг бий болгох гэж байгаа энийг бол хувийн хэвшил нь хийх ёстой болов уу гэж би боддог. Тэгэхээр шинэ бизнест ялангуяа бизнесийн салбар дээр хамгийн шинэ технологийг нэвтрүүлж чаддаг банк санхүүгийн салбарынхан маань. Бусад энэ барилгын салбарууд болон бригадуудтайгаа хамтарч ажиллах тал дээр бол бас ахиц гаргаасай гэж бодож байна. Тэгээд миний зүгээс сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй 38 компани барилгын дулаалга хийдэг 200 орчим бригад гэрийн дулаалгын материал үйлдвэрлэдэг 23 цехийг нийлүүлээд нийлээд та бүхэн маань Эско үйлчилгээ үзүүлэх компанийн одоо бүтээгдэхүүн гаргаач гэсэн санал тавихаар уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа.

Тэгэхээр арилжааны банкнууд маань бас энэ уулзалт товлохлоор та бүхэндээ мэдээлэл хүргэе. Боломжтой бол та бүхэн маань бас хамтраад яваасай гэж бодож байна. Дулаалгын платформ дээр бас дулаанбаатар цэг сити гээд сайтыг хөгжүүлээд явж байгаа. Боломжтой бол уг нь уг нь миний хийх ёстой ажил биш. Уг

нь хувийн хэвшил нь ч юм уу тийм байгууллага байна. Эсвэл Агаарын бохирдлын үндэсний хороон дээр эсвэл нийслэл дээр хийх боломжтой ажил байгаа. Гэхдээ энэ ажлыг бас хийгээд эхний ээлжид таны яг хэлсэн Төрийн банкны саналыг дэмжиж байна. Энэ хавар, намар, зундаа багтаад энэ сайтыг бүрэн болгох ажлыг хийгээд явж байгаа.

Газрыг гэрчилгээлүүлэх ажил хэрэгтэй байгаа гэж. Энэ маш чухал байгаа тийм ээ. Яг нөгөө барьцаанд тавих гэхээр газрын эзэмших ч байдаг юм уу эсвэл ашиглах гэрээтэй байхаар яг барьцаа хөрөнгөөр тооцож болдоггүй, өмчлөлийн гэрчилгээтэй байж байвал илүү боломж нь бүрдэнэ гэсэн санал байсан. Тийм тэгээд энэ дээр бол санал нэг байгаа. Тэгээд уг нь ЗГХЭГ энд байсан бол энэ дээр ярилцах боломж нь бүрдэнэ.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооныхон маань өнөөдөр ирээгүй Хот байгуулалтын яам, Байгаль орчны яам, ЗГХЭГ-т энэ дээр тусад нь Байнгын хорооны хурлаар ч байдаг юм уу, Байнгын хорооныхоо даргын өрөөнд тусдаа бас уулзалт зохион байгуулаад энүүн дээр ярилцсан зүйлүүдийг нь бас мэдээлэл аваад цаашдын чиг баримжааг нь аваад явсан бол зүйтэй болов уу гэж бодож байна. Тэгээд 50 хувийн хэрэгжилт гэдгийг бол би бас тийм бага бол дүн гэж бодохгүй байгаа. Энийг батлаад жил л болж байна тиймээ?

Тэгэхээр та бүхэн маань ирэх жил илүү өндөр гүйцэтгэлийн хувьтайгаар орж ирээсэй гэж хүсэж байна. Илүү тодорхой бодлогын одоо шийдлүүдийг яриасай гэж бодож байна. Та бүхэнд амжилт хүсье.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамцаас Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга болон Монголбанкны Ерөнхийлөгчид тавьсан асуулгын хариуг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байгаа тул хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүдтэй болон ажлын хэсгийнхээ нийт гишүүдэд бас талархсанаа илэрхийлье ээ. Баярлалаа.

19.33 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА